


ОКСФОРД

Хятад

Ардын Үлгэрүүд



Сырил Берч

Хятад Ардын Үлгэрүүд

Сэргэл Берч

ХЯТАД АРДЫН ҮЛГЭРҮҮД

Сургуулийн бага, дунд наасныханд зориулав.

Өрчүүлагч Х.Худан

Э.Ганболд

Б.Зандан

Н.Овоунбаяр

Хянагч Ж.Гэрэлмаа

Дизайнер Н.Хөдөлмөр



Хэвлээн ийтгэлийг Интерпрес ХХК

2007 он

Хятад

Ардын Үлгэрүүд



Улаанбаатар хот
2007 он

Гарчиг

Тэнгэр газар, дэлхий ба хүн	5
Агуу их мэргэн харваач	9
Үерийг номхтгогчид	17
Өөрөө чанагдсан хоол	28
Хэрхэн гэрлэдэг вэ	33
Үиэ цэнэтэй турван боодол	37
Загасны нухаш болох шахсан нь	42
Сүнснүүдийн жихүүдэс	47
Замын ид шилдтэнүүд	61
Илжигний дэн буудал	68
Аюулт байшин	73
Борооны эзэд	77
Өндгөн торолт	84
Ариун явдалт нагац эгч	91
Бичвэр	101
Мөнхжин	110
Гурван анд	117
Шулмыг дарсан нь	122





Тэнгэр газар, дэлхий ба хүн

Газар, уул ус, гол горхи далай тэнгисийн хамт тэнгэр, нар сар, оддынхоо хамтаа эхлээд нэг л эмх замбараагүй бөөн юм байлаа.

Юу ч хэлбэр дүрсээ олоогүй бүгл дээр дооргүй, эргэн тойрон эрчилсэн, самуурсан будилаан дунд байлаа. П АН Кут тэрхүү эмх замбараагүй байдлын дундаас гарч иртэл тоологдошгүй олон жилийн турш энэ нь хэлбэржээгүй, гэрэл гэгээгүй сртөнцийн оршин тогтоно ганц зам нь байсан юм.

ПАН Кумашудаанбиежин, тэрхүү замбараагүй байдлын бүрэлдэхүүн хэсгүүдээр хооллосоор урган гарч ирлээ. Түүний нүд нь аниатай байсан ба тэрээр 18 жилийн турш унтсан юм. Эцэст нь түүний нойроосоо сэрэх меч боллоо. Түүнийг нүдээ нээхэд самуурсан, будилсан зүйлс болон харанхуйгаас өөр юу ч харагдсангүй. Уурласандaa тэрээр аварга том гарсаа өргөж, сохроор харанхуйн нүүрэн дундуур нь шохилоо. Мөн ганцхан хүчтэй үзээлтээр самуурсан будилсан зүйлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг энд тэндгүй тарааж орхилоо.

Хүйларсан хөдөлгөөн намжиж, түүний оронд шинэ төрлийн хөдөлгөөн бий боллоо. Баригдсан, хүлэгдсэн юм байхаа болж, жингийнхээ хувьд хөнгөн, шинж чанарынхаяа хувьд цэвэр бүх юмс дээш цойлон урган гарлаа. Харин хунд бөгөөд бохир бүх юмс доош живлээ. Хүчирхэг үзээлтээрээ П АН КУ тэнгэрийг газраас чөлөөллөө.

Одоо П АН КУ газар дээр хөл дээрээ зогсож, тэнгэр түүний толгой дээр амар амгалан байв. Түүнийг тэр хоёр зүйлийн хооронд зогссоноос хойш тэд дахин нийлж байхаа болж, мөн түүнийг зогссоноос хойш цойлон ургах, живэн доошлох үйл ажиллагаа үргэлжилсэн билээ.

Газар дэлхий арван тохойгоор зузаарч, тэнгэр арван тохойгоор өндөрт өргөгдлөө. Тэдний хоорондын тулгуур газраас өдөрт мөн арван тохойгоор өсч байдаг П Ан Кугийн бисийн хэмжээгээр холдоор байлаа. П Ан Кугийн бие аварга том болтол, газар дэлхийг асар зузаан болж бүрдтэл, тэнгэрийг асар өндөрт өргөгдтөл тэр арван наймаас илүү жилийн турш оссоор байлаа. Мянга мянган бээрийн өндөртэй тэрээр газрыг тэнгэрээс тусгаарлах багана болсноор тэр хоёр зүйл нэгэн эх захгүй бөөгнөрсөн зүйл байхаа больж, хэзээ ч дахин нийлэхээргүй болсон юм. Олон зууны турш газар дэлхий болон тэнгэр өөр өөрсдийнхөө байранд найдвартай тогтоож, хэзээ ч дахин нийлэхгүй боллоо гэж бодтолоо П Ан Ку зуу зуун жилийн тушид зогссон билээ.

Тэр үүрэг даалгавраа амжилттай биселүүлснийхээ дараа газар дээр амрахаар хэвтэж, амар амгалангийнхаяа үхэлд очлоо. Өөрийнхөө амьдралын туршид орчлон өртөнцийг хэлбэр дурсэнд нь оруулсан тэрээр одоо газар дэлхийг баян, үзэсгэлэнтэй болгохын тулд үхэж, биеэ өгсөн билээ. Салхи, үүлсийг бий болгохын тулд өөрийнхөө биеэс амьсталаа, аянгын нүргээн бий болгохын тулд дуу хоолойгоо, нар сар байлгахын тулд хоёр нүдээ, одод гаргахын тулд толгойныхоо үсийг болон сахлаа, бороо шүүдэртэй байлгахын тулд хөмсөгнийхөө хэлсийг өгсөн байна. Газар дэлхий, уулс толгодод зориулж биеэ, хоёр туйлд болон баруун зүүн хязгаарт зориулж гар хөлөө өгсөн байна. Түүний цус нь газрын гол горхи болон урсаж, судаснууд нь газрыг бүрхсэн зам болон явжээ. Харин түүний бисийн зөвлөн эд нь талбайн хөрс болж, түүний бисийн үс нь цэцэг мод болон ургажээ. Харин түүний яс, шүл зэрэг нь дэлхийн гадаргыг үнэт металлаар баяжуулсан юм. Иймээс П Ан Ку эмх замбараагүй байдлаас тэнгэрийг түүний бүхий л сүр жавхлантай нь, газрыг түүний бүхий л агуу зүйлстэй нь бий болгосон юм.

Гэвч одоо газар дэлхий өөрийнхөө гоо үзэмжийг харуулж, адгуус амьтад нь ой тайгадаа давхилдаж, загас нь гол усандaa сэлж байвч ямар нэгэн юм дутуу мэт санагдаж байлаа. Түүнийг дундуур биш байлгахад, мөн гадарга дээгүүр нь хэрэн хэсүүчлэх тэнгэрээс бууж ирсэн бурхдал зориулж, тэднийг уйтгар гуниг багатай байлгахын тулд ямар нэг юм дутагдсан мэт санагдаж байлаа. Нэг өдөр luun биетэй боловч хүн толгойтой охин тэнгэр Ну-куа газар дэлхийн ганцаардлаас залхан гарч ирлээ. Удаан бодсоны эцэст тонгойж газраас хэсэг бөөн шавар авлаа. Өөрийнхөө luun савраараа очүүхэн жижиг шавран амьтны дурсийг хийллээ. Толгойг нь өөрийнхтэйгөө адил хэлбэр дурстэй хийж, харин

биед нь хоёр хөл, хоёр гар гаргав. Тэгээд тэр жижигхэн зүйлээ газарт буцааж тавилаа. Ингээд анхны хүн амьдралд ирж охин тэнгэрийн нүд, чихийг баясгахын тулд бүжиглэж, дуу гаргалаа. Тэрээр дур булаам ийм хүнийг олныг хийж, тэд түүнийг тойрон бүжиглэснээр тэрээр ганцаардал уйтгарлалыг дахин мэдрээгүй билээ.

Дараа нь өөрийнхөө даалгавраас бага зэрэг амсхийж, өөрийнхөө бүтээсэн газар дэлхийгээр хамтдаа одож буй охид хөвгүүдээ хармагцаа шинэ бололц автлаа. Түүний бий болгож өсгөсөн эдгээр хүмүүс хөгшреөд үхэхийн цагт дэлхий дээр юу болох бол? Тэд газар дэлхийн араатан амьтдад тогтоосон журамд сайтар нийцсэн сайн хүмүүс байсан. Гэхдээ тэд мөнхөд амьдрахгүй. Газар дэлхийг хүнээр дүүргэх нь охин тэнгэрийн хувьд хязгаартгүй үргэлжлэх даалгавар гэсэн үг юм. Иймээс энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд Ну-куа нь эмэгтэй, эрэгтэй хүнийг хамтад нь авч ирж, тэдэнд гэр бүл болох арга замыг зааж өгсөн байна. Одоо тэд өөрсдийнхөө хөвгүүд, охидыг бүтээж чаддаг боллоо. Ингээд цаг хугацааны туршид газар дэлхий дээр хүмүүс үүнийг үргэлжлүүлж чадах болсон билээ.

Ну-куагаас өгсөн энэхүү гэрлэлтийн бэлгийн дараагаар түүний нөхөр болох агуу их бурхан Фү-хсигээс нь нөхрүүдэл адис хүртээсэн билээ. Тэрээр мөн л хүн толгойтой байсан боловч бие нь луу хэлбэртэй байлаа. Тэр эрэгтэй хүмүүст олс нэхжэй, загасны тор хийхийг зааж өгөв. Мөн эрчүүдийн эхлэн тоглосон хөгжим пийпааг (хөгжмийн зэмсэг) хийжээ. Түүний өгсөн гал ч бас үнэлж баршгүй бэлэг байсан юм. Дуу шаилгаантай борооны эзэн явж өнгөрөхдөө гаргасан ой модны түймрийг хараал хүмүүс айдаг байлаа. Гэхдээ энэхүү эзний хүү Фү-хи модыг хооронд нь үрж өөрсдийнхөө хэрэгцээнд ашиглаж, дулаачах болон хоол хүнсээ хийх зориулалтаар гал гаргахыг эрчүүдэд зааж өгчээ.

Ну-куагийн бүтээсэн хүн аль хэдийнээ өөрсдийнхөө бодлыг бусдад хэлж чаддаг болжээ. Гэтэл Фү-хи дараа гарч ирэх хүмүүст зориулж аливаа зүйлийг тэмдэглэхийн тулд найман үнэт тэмдэгтийг зурж өгчээ. Тэрээр тэнгэрийг төлөөлж гурван шулуун зураас \equiv зуржээ. Тасархай гурван зураасаар $\equiv \equiv$ газар дэлхийг төлөөлүүлжээ. Дундах зураас нь тасархайгүй тэмдэгт нь $\equiv \equiv$ усыг төлөөлсөн бол дундах зураас нь тасархайтай нь \equiv галыг төлөөлжээ. Дээрээ тасархайгүй зураастай нь $\equiv \equiv$ уул нуруудыг тэмдэглэж, харин доороо тасархайгүй зураастай нь $\equiv \equiv$ шуургыг тэмдэглэсэн байна. Доороо тасархайтай $\equiv \equiv$ зураас нь салхийг үзүүлсэн бол дээрээ тасархайтай $\equiv \equiv$ зураас нь намагтай газрыг


үзүүлжээ. Энэхүү найман хүчтэй тэмдэгтүүдээр хүмүүс түүний эргэн тойронд байгаа өртөнцийн талаар ажигласан бүх зүйлсээ тэмдэглэж эхэлсэн байна.

Олон жилийн турш эрчүүд амар тайван амьдарцгаасан ажээ. Гэтэл гэнэт тэнгэрээс газар дэлхий үрүү бүхий л хүнд төгсгөл авчрах аюул заналхийлсэн зөрчилдөөн дэгдлээ. Энэ нь усны сүнс болох Кунг-кунг болон галын сүнс болох Чу-жунт нарын дунд үссэн тулаан байсан юм. Гол нуурын аварга том давалгааг ташуурдах, өөрийнхөө ширүүн боөгнөрлийг өстөн дайсан болох галын эсрэг чиглүүлэхийн тулд хуйлран, дур зоргоороо аашлах Кунг-кунг газар дэлхий үрүү бууж ирлээ. Чу-жунт галын дөл, халуун амьсгаагаараа эсэргүүцэн тулалдаж, усны тарьсан үймээнийг замд нь зогсоолоо. Кунг-кунгийн арми бутран тарж, удирдагч нь болох Кунг-кунг өөрөө эргэн зугтаалаа. Гэвч түүний дэгдэлт ихээхэн аюул ослыг авчирсан юм. Ухаан жолоогүй баруун зүйт зугтаж байсан Кунг-кунг баруун өнцөгт дэлхийг тулж байсан тулгуур Пучоу-шан уулыг толгойгоороо мөргөлөө.

Кунг-кунг зугтаж чадсан хэдий ч дэлхийг аюултай байдалд орхисон билээ. Тэнгэрт аварга том нух гарсан бөгөөд газар дэлхий баруун зүйт дээш хэвийв. Энэ бүс нутагт хагарал, ан цав гарсан байна. Одоо ч үүнийг харж болно. Бүх гол мөрөн, нууруудын ус хальж доош хазайсан зүүн урд зүг үрүү урсан, тэнд өргөн уудам далайг үүсгэсэн байна. Тэр үеэр ганхаж байсан уулын ойн гол дүрэлзэн цаашилж, янз бүрийн зэрлэг амьтад, сүл дорой, айдаст автсан хүний өртөнц дундуур дээрэм тонуул хийхээр үүр ичээгээ орхин оджээ.

Охин тэнгэр Ну-куад дэлхийг өртөнцийг буцаан эмх цэгцэнд оруулж, гол болон үер усыг номхтож, мөн хэрэн тэнэж буй араатан амьтдыг гаршуулж сургах үлдлээ. Тэрээр гайхамшигтай сайхан өнгөтэй голын ёроолын чулуут сонголоо. Тэдгээрийг хэвэнд орох болтол нь халааж, дараа нь тэнгэрт гарсан нүхийг нохлоо. Эцэст нь тэрээр аварга том яст мэлхийг алж газар дэлхий дээр тэнгэрийг унахааргүйгээр бат бөх тулгуур хийхийн тулд хүчит хелийг нь тасдан авлаа.

Ингээд дэлхий дээр энх тайван дахин сэргэсэн юм. Гэхдээ уул нуурууд баруун зүйт сүндэрлэсээр байгаа бөгөөд хэвийсэн тэнгэрт нар, сар, одод одоо ч гэсэн гарсаар байдаг ба харин зүүн зүйт газар дэлхийн ус эцэж цувашигүй далайлд цутгасаар байгаа билээ.



Агуу их мэргэн харваач

Бухарваачдын дундаас агуу их харваач нь Ии байлаа. Түүний хөнөөлт сүм нь сүрлээр хийгээгүй ба байнууд нь мах цуснаас бурдсэн зүтгээр нэг хүн амьтан ч байсангүй. Иигийн тулалдаж, эзэлж байсан дайснууд нь гэгээн эзэн хаан Яаогийн үед байгалийн эмх цэгчийн эсрэг боссон хүчтэй сүнснүүд байлаа. Яаог захирч байх үед эрчүүд тайван амгалан амьдарч байлаа. Харин хорон санаат сүнснүүд байгалийн хүчийг өөртөө авч, амьдарч байсан бүхнийг устгахаар заналхийлж байв.

Энэ бүхэн нь өөрөө өөртэйгөө тоглохоос уйдсан арван хүүхэд хамтарч тоглоохор шийдсэн тэр үед хор гэмгүйгээр эхэлсэн билээ. Агуу их удирдагчийн эдгээр хүүхдүүд нь түүний эхнэр Хси-хогоос төрсөн хүүхдүүд байсан юм. Эдгээр хөвгүүд нь асар том од, нар байсан ба тэд бүгдээрээ зүүн далай дээгүүр хамтдаа амьдардаг байжээ. Тэнд Фү-санг гэдэг аварга том мод усны гадаргаас мянга мянган тохой ондорт ургаж байлаа. Түүний их бисийг нь гарса алдалсан мянган хүн бүслүүрдэж чадлагтуй байсан юм. Тэнд түүний мөчруүд дээр нь арван нар амарч байдаг байв. Үүр цайх болгонд ээлж нь ирэхэд хуваарийн дагуу тэдгээрийн нэг нь мандаж, тэнгэрээр аялах замдаа газар дэлхийд гэрэл дулааныг авч ирж байлаа. Тэд хуваария дуулгавартайя мөрддөг байсан учир хүмүүс нэгээс илүү нарыг тэр цагт хэзээ ч хараагүй ба үнэн хэрэг дээрээ тэд арвуулаа яг адилхан байсан учир нэгээс илүү нар байдаг гэдгийг мэддэгтүй байжээ.

Яагаад эдгээр арван нар-хүүхдүүдийн толгойд нэг өглөө тэнгэрт бүгдээрээ мандах бодол гэнэт орж ирснийг хэн ч мэдээгүй билээ. Гэхдээ агуу их удирдагч энэ зүйл болохыг зөгнөн мэдэж байжээ. Тэр хүүхдүүдээ газар дэлхийд нэг л нар байх ёстой гэсэн адис хүргэсэн

боловч, арвуулаа тэнгэрт хамтдаа байх юм бол сүйрэл авч ирэх нь дамжигтгүй гэдгийг мэдэж байсан юм. Эзэн хаан Яао талархлын тухай заниссан мөргөлөө үйлдэж байхдаа нуд сохлом гэрэл, тэвчишгүй халуун, ундаассан мал сүрэг, шатам үр тарианы талаар ярж эхлэх үед түүний айлас батлагдсан юм. Бүхий л хүчийг агуулсан эзэн хаан Яао хэдийвээр газар дэлхий дээр байсан ч тэнгэр огторгуйд учрах энэхүү шинэ аюул осолтой нүүр тулах үед өөрөө ч гэсэн сүл дорой, тамиргүй нэгэн болсон юм. Түүнд тусламж илгээж, дэлхийг аюул заналхийлж буй хувь төөрөгөөс аврах зарим нэг баатруудыг дооши буулгах ёстой байв. Тэр даруй агуу их удирдагч гарамгай дайчдынхаа талаар бодлоо.

Тэнгэрээс заяасан Ии мэргэн харваач дэлхийд хэрэгтэй байгаа авьяас чадвар, зориг тэвчээр, өгөөмөр сэтгэлтэй байжээ. Иймээс Ии бүтэн сартай шөнө газар дэлхий үүрүү бууж, Яаогийн хүмүүсээ захирдаг байсан тэрхүү энгийн сууцны үүдэн дээр ирж, өөрийнхөө байгааг зарласан юм.

Яао зочноо уттан авч, гартаа барьж явсан агуу их улаан нумыг нь магтан үнэллээ. Тэрээр түүнийг гудамжинд дагуулан гарч, нийслэл хотын дээгүүр алсал сүндэрлэж байгаа уулын оройг зааж өглөө. Түүний орой дээр сондгой нэгэн нарс ургаж байлаа. “Авч явж байгаа хүчтэй нумаараа юу хийж чаддагаа билэнд үзүүл” гэж эзэн хаан тушаалаа.

Агуу их мэргэн хажуудаа байх саадагнаас нэгэн урт, шулуун, хатуу бөгөөд хүрэл үзүүртэй сумыг удаан гэгч нь сонгон авлаа. Түүнийгээ баруун гарцаараа жигд арагш нь татаж байгаад хөвчиндөө таарууллаа. Хөлдөө зайдтай, биеэ цэх авч алсын оргил тийш харж зогслоо. Нарс сарны гэрэлд мөнгөн тuya цацуулж байв. Ии байгаа ониллоо. Түүнийг нумныхаа хөвчийг татахад аварга том ятга татаж байгаа мэт дуу гарч уулын орой дээрх нарс хурдтай сумны цохилт очихоос өмнө хоёр хэсэг болон цуурлаа.

Эзэн хаан инээн, “Одоо амар” гэж тушаагаад, “Маргааш чамд хийх юм их байх болно” гэж хэллээ.

Ии анхилуун үнэрт өвсөн орон дээр шөнийг өнгөрөөв. Эзэн хаан өөрөө түүнийг сэрээхээр ирэхэд гэгээ ороогүй байлаа. Ии Яаог унтаагүй гэдгийг мэдэж байв. Тэрээр хүмүүсдээ аврал эрэн залбирал үйлдэж тэр шөнийг өнгөрөөсөн байх ёстой. Түүний өгөөмөр царайд яларсан шинж тэмлэг байсангүй. “Одоо хүрээд ир дээ” гэж эзэн хаан тайвнаар хэлээд, “Би чамайг үүр цайхыг өөрийн биеэр хараасай гэж хүсч байна” гээд дагуулан явав.

Бараа бологсодгүйгээр тэр хоёр унтаж буй нийслэл хотын гудамжаар алхлаа. Үдний харуул эзэн хаанаа танин газарт сөгдөн моргөхөд, Яао түүний хөл дээр нь босгоод үдний цамхгийн орой дээр гарах тэдний замыг дэнлүүтээрээ гэрэлтүүлэхийг тушаалаа. Зүүн зүгт тэнгэрийн хаяаны анхны мөнгөн цацраг, тэнгэрийн гүн хөх цэнхэр өнгөтэй уусч эхлэхээс өмнө тэд арай л очиж амжсангүй. Үүр цайж байлаа. Хэдэн мөчийн турш бүх юм үүрийн туяанд автлаа. Гэвч удалгүй тэнгэрийн хаяан доогуур гарч ирэх өглөөний гэгээнээс агуу их гэрэл гарлаа. Нөгөө мөнгөн цацрагууд одоо үер мэт болж, маш хүрц тод боллоо. Хормын дотор л зүүн зүгт тэнгэр алтаар туяарсан мэт санагдлаа. Тэрхүү алтны төвд газраас нар урган тодорлоо. Эхлээд харахад аль аль нь тэнцүүхэн хүрц хоёр нарны цагираг тэнгэрийн хаяан дээгүүр гялс хийллэ. Бүлэг нарны орчимд тэнгэр ууртайяа улалзаж байв. Олон юмс шингэн зүйлс болон буцалж, бур тэнгэрээр нэг цаашсан нүд гялбам цагаан туяа болж ч чадахаар байв.

Их халуун байлаа. Үүр туяарч эхлэх үед Ии чулуун хэмрэн дээр гарваа тавихад түлэгдэж товруутсаныг олж үзээд гайхав. Ярих гэж амаа нэээтэл хуурайшсан агаар түүний амьг тэр даруйд нь хатааж орхив. Иймээс амнаас нь зөвхөн соёнгөтсөн дуу л гарч байлаа. Эзэн хаан Яао түүнийг ойлгоод толгой дохин, гарваараа зангав. Энэ үес тэд доош буух хараахан амжаагүй байхдаа хотын хананы эсрэг талд байх бог будааны талбай тийш харвал будааны иш ногоон байх ёстой ч хүрэн өнгөтэй, хатангиршиж гандсан харагдлаа. Хэдхэн мөчийн дараа талбай улайсан, нэгэн булангаас нь утаяа суунаглана. Тэр ч бүү хэл дахин нэг хором өнгөрөхөд талбай тэр чигээрээ цагаан үнс болж доорх газар нь хагаа үсэрч байв.

Нөгөө хоёр эр дээврээс хурдан буув. Тэд цамхгийг орхин газраар явахад хөлийнхөө улыг түлэгдэж байгааг мэдэрлээ. Ии цамхаг уруу буцаж эргээд сүүдэрт бага зэрэг устай байгаа хувинг олж харан түүнд углаашаа нортож, хэдийвээр өвдөж байсан ч цааш явах боломжтой болов. Тэд эзэн хааны сууцанд буцаж ирлээ. Эзэнт гүрний өнцөг булан бүрээс зуу зуун бээрийн газраас ирсэн элч нарынхаа талаар Яао зочиндоо ярж өглөө. Тэнд худгууд нь хатаж ширгээд, цангаснаас болж бүхэл бүтэн тосгоноороо нас барж байгаа талаар, халуунд ядарснаас болж талбай дээрээ хүмүүс үхэж үрэгдэж байгаа тухай, ойл гол дүрэлзэж байгаа талаар, бур өмнө зүгийн буцалж буй нуурын дээгүүр өтгөн уурын манан татсан талаар, мөн уулын хажуу хайлснаас тосгод лаваар бүрхэгдсэн талаар өгүүлсэн байна.

Иймэрхүү мэдээг сонсоход маш аймшигтай байлаа. Гэвч бүр ч муу мэдээ байв. Эээн хааны ярьж байх хооронд ороөний гадна талд үймэн шуугиан болж нэгэн эрэгтэй хүн орж ирлээ. Элч аялалдаа ядарч айлас хүйдэст автсан харагдана. Түүний ярьж байгаа зүйл нь хамгийн муу мэдээ байсан юм. Тэр нь аварга хүний биетэй, амьтны толгойтой ер бусын амьтан гарч ирсэн явдал байлаа. Тэрээр нэгэн аюултай зэвсэгтэй байв. Цүүц мэт хурц үзүүртэй аварга том шуд, бүхэл бүтэн зургаан хөлтэй байлаа. Тэр мангас өмнө зүйт эмх замбараагүй байдлыг үүсгэн, хүмүүсийг тасдан хаяхынхаа өмнө тэдний оромжуудыг хэмхчин хаяж байв гэнэ.

Өөр нэгэн ирэхэд тэрхүү элч арай гэж мэдээллээ дуусгалаа. “Цог жавхлант эээн хаан минь, зовсон ард иргэлдээ тариан түрүү өгөөч ээ” гэж ирсэн хүн уйлан хайллаа. “Зүүн зүйт асар том далавчтай, аварга том шувуу болох тогос нисч байна. Түүний дэвэлт нь аймшигтай хүчтэй салхи дэгдээн модод үндсээрээ булгарч, яг л намрын хүйларсан навчис мэт орон байр шидэгдэж, хүмүүс айн, дагжин чичирч, хөөрхийлөлтэй болж агуй болон газрын нүхэнд орж байна” гэв.

Мөн тэрхүү арван нарны аагим халуунд хийсэн аяллаасаа ядарсан гурав дахь элч ирлээ. “Өргөн уудам Танг-тинг нуур аюул тарьж байна. Тэнгисийн мөгөй болох мангас усан дээгүүр явахдаа далайн шуурга, үер авчирлаа. Хэчинээн загасчид нуурын ангайсан хоолойд живж алга болсон, хэчинээн тосгод бүхэл бүтнээрээ усны цагирагт живснийг хэн ч мэдэхгүй” гэлээ.

Ии эээн хааны өгүүлж байгаа зүйлийг сонч, зөвхөн өөрийнхөө төлөө биш бүх ард иргэдийнхээ төлөө санаа зовж байгааг нь мэдлээ. “Энд нэг л арга байна. Эхлээд хуурамч нарыг устах ёстой. Үгүй бол бүх л амырал төгсөх болно” гэж агуу их мэргэн харваач хэллээ. Ингээд Ии ажиллахаар болов. Анхаарал болгоомжтой гэгч нь саадагтаа байгаа арван сумыг сонгон авлаа. Нуура авч шалгалаа. Дараа нь нүд сохлом гэрэл, бүгчим халуун өөд алхав. Эээн хаан түүнийг дагалаа. Ингээд тэднийг зах зээл дээр ирэхэд нийслэлийн хүмүүс аль хэдийнээ тэнд цуглаж аврагчийг тэвчээртэй хүлээж байлаа. Түүний тухай тэдэнд хотын хаалганы харуул ярьж өгсөн байлаа.

Ии төөнөж буй нарны өөдөөс нүдээ анин зогсоно. Тэгээд тэр нумаа авч харвав. Агуу их мэргэн харваачийн хөлд эхлээд өд, дараа нь хэсэг хар юм дуу чимээтэй унав. Тэр нь суманд оногдсон үзэшгүй муухай том хэрээ шувуу байлаа. Энэ нь эртний ид шидтэнгүүдийн үргэлж сануулдаг байсан нарны сүнс ажгуу. Одоо тэр “Алтан хэрээ” Иигийн

суманд өртжээ.

Есөн нар үлдлээ. Тэнгэр улалзаж газар дэлхий шатсаар байв. Ямар ч үед аварга том хэрээ болон хувирч, тэнгэрийн хаяан дээгүүр далавчаа дэвэх есөн нар түүний хурдан суманд оногдолгуйгээр үлдсэн байна. Яаралгүйгээр, гэхдээ нэг ч хором алдалгүйгээр сумаа авч татан тавьсаар байлаа. Тийм алс холын зайд тэнгэрт дахин хоёр удаа дутгуй тэсрэлтүүд боллоо. Дахин хоёр удаа өд сөдний хүй дэгдэж, дахин хоёр хар биес сүйрэн газарт уналаа. Дахин дахин хүнд ажил хийж нумаа гайхамшигтайгаар татсан Иигийн булчингууд нь товойж, мөр нь хөндүүрлэж, агаарт түүний нумны хөвчийн дуу хадаж байв. Одоо дөрвөн нар үлдсэн бөгөөд арай хайлчхаагүй байгаа тэнгэр цэв цэлмэг байгаа тул тэдгээрийг тоолж болохоор боллоо. Шатах явц бараг л зогсож үзэгчдийн царай уг сүтгүй хуйхлагдхаа болин, харин бага зэрэг итгэлээр гэрэлтэж байлаа.

Эзэн хаан Яаогийн нүд Иигийн саадаг дээр тусав. Одоо дөрвөн сум үлдсэн. Ии тэнгэр дэх нарыг харвахаас өөр юут ч мэдрэхээргүй болсон байв. “Гэхдээ мөнхийн шонө, оволтэй байх гээгүй л юм бол бидэнд нэг нар байх ёстой” гэж Яао болдоо. Хурдхан гэгч нь харваачийн саадагнаас нэг сумыг нь аваад өөрийнхөө ханцуйд нуулаа. Долоо дахь нар тэнгэрээс уналаа, мөн найм дахь, ес дэх нар. Ингээд Иигийн гар саадагтаа хүрч хоосон байгааг мэдэрлээ. Хөлстэй, ядарсан тэр эзэн хаан Яао уруу, дараа нь дээш цэлмэг хөх тэнгэр лүү, мөн тэр цагаас хойш дэлхий өртөнцийг олон зууны туршид адислан байгаа ганцхан нарны зүг харлаа. Ингээд түүнд харж зогссон хүмүүсийн бөөн хашираан сонсгодоход инээмсэглэн нумаа доош буулгалаа.

Тэнгэрийн хаягаар хатаж хуурайшсан газар дэлхийд удахгүй бороо авчрахыг зөгнөсөн үүл аль хэдийнээ гарчээ. Энд, одоо ээлтэй болсон тэнгэрийн дор сэтгэл татам сайхан байлаа. Дэлхий өртөнцийг сүйрлээс аварсных нь төлөө дэлхий өртөнц даяараа түүний анд найз болсон ба гэгээн эзэн хаан Яао баатар эрд зориулж найр наадамд бэлтгэх зарлиг буулгаад байсан юм. Ии баатарлаг үйлсийнхээ дараа сайхан амарч алжаалаа тайлах байлаа. Гэвч Ии түүний ажил дусаагүй байгаа гэдгийг мэдэж байв. Урд болон зүүн зүгт цүүцэн шүдээт мангас, салхин шувуу, Тунг-тинг нуурын мөгий зэрэг нь хүрхэрсээр л байлаа. Зөвхөн саадгаа дахин дүүргэж, сэлмээ бэхлэхийн тулд түр зуур амсхийсэн Ии өмнө зүгийн элчүүдийг уриалж цүүцэн шүдтийг нэхэн хөөв.

Энэ нь урт бөгөөд хүнд хэцүү аян байсан ч агуу их мэргэн харваач, хамтран зүтгэгчдийнхээ хамтаар тал газраар, даваа гүвээг гатлан намаг

болон ой шугуйг дамжин явсаар л байв. Цүүцэн шүдтийн орон гэр байгаа өмнө зүгийн ууланд хурч очтол завьчин тэднийг өргөн гол мөрөн дээгүүр зөөж, газарчид зуу зуун гол горхийн гармаар дагуулан гаргаж байв. Тэд мангасын ул мөрийг олоход газар дээгүүр тонгорог шиг хүрс собонд нь толгойгоо тасдуулсан их биенүүд хэвтэж байв. Мөн дэргэд нь урц овоохойнууд нь сууриараа хуу татагдсан байх нь харагдав. Ийнхүү харж зогсон байхдаа Ии ард нь уурсан хүрхрэхийг сонслоо. Тэрээр эргэн харахад түүний ан зогсож байв. Түүний цээжин дээр нь шар туяа цацуулсан нэгэн том шүд байлаа.

Тэрхэн агшинд Ии нумаа өргөж сумыг нь хөвчинд нь тааруулахад хөвчөө татахаас нь өмнө цүүцэн шүдэт түүний ард байгаа агуй уруу орж алга болчхов. Ии болгоомжтойгоор агуйд дөхөж очлоо. Нөгөө мангас үүдээр нь дахин гарч ирэх яг тэр үед түүний бие аварга том бамбайн цаанаас цухуйж байв. Ии тэр газар дээрээ зогсож хүлээхэд нум нь татаастай байсан бөгөөд сумыг нь хөвчин дээрээ тавьсан байлаа. Цүүцэн шүдэт маш удаанаар, арайхийн урагшилж бараг л тэр хоёр тулах шахахад асар хурдтайгаар хөдөлж, хуягаа буулгаад аварга том сөбогоо өргөн цахиллаа. Энэ мочил Ии удаан гэгч нь татсан сумаа тавихад тэрээр шулуухан нисч түүний онылсон мангасын шүдийг нь онов. Ийнхүү харвахад аянга цахих мэт их чимээ гарч мангас ч үт дуутгүй үхэв.

Нар баруун зүгт шингэсэн боловч Ии амрах бас л болоогүй байлаа. Оройн сэргүүнд жаргаж буй нар луу нуруугаа харуулж салхин шувуут эрхээр зэхэв.

Нэлээд их замыг туулж өргөн уудам голыг уруудан сэлж зүүн зүгийг зорилоо. Эцэст нь тэрээр эрж байсан зүйлийнхээ мөрийг олов. Хүчтэй салхинд сүйрсний ул мөр, үр тариа налан унаж, модол, урц овоохой болон завь бүтгээрээ яг л сүрэл шиг шидэгдсэн байхыг олж харлаа. Дараа нь алсад, бүр тэнгэрт шаржигнах чимээг сонсов. Нэгэн хар цэг буюу салхин шувуу ирж байв. Тэрээр эрэг үрүү сэлүүрдэж харайн гараад ойртох буй шувууны замд байх төгөл дунд нуутгав. Хүлээж байхдаа тэрээр “Ийм хэмжээний шувууг нэг сум алж чадахгүй байж болох юм. Хэрвээ зөвхөн шархдуулчих юм бол үүрэндээ очоод шархыг нь эдгэртэл хүлээх болно. Ингэх юм бол намайг дахин олохос өмнө асар их хор хохирол учруулж болох юм. Тэгэхлээр цорын ганц арга бол түүнийг одоо барьж авч дуусгавар болгох явдал юм” гэж боллоо.

Ингэхийн тулд тэр цагаас хойш шувууны анчдын мөрдлөг болсон нэгэн аргыг хэрэглэжээ. Тэрээр хамгийн шулуухан сумандaa урт хүчтэй

уяаг бэхэлж, нөгөө үзүүрийг нь өөрийнхөө нуманд уяв. Дараа нь сумаа нумныхаа хөвчинд бариад төгөл дотор хүлээлээ. Тун удалгүй түүний сонссон шаржигнаа нь хүрхрээ болон өсч, дараа нь хүрхрээ нь чих дөжрөм аянга цахилгаан болоход тэнгэр харанхуйлж аварга том тогос шувуу толгой дээгүүр гарч ирлээ. Агуу их мэргэн харваач харваж, сум нь түүнийг оноход, харин шувуу нисэлтэндээ дээш шидэглээ. Тэрээр дээгүүр ниссээр л байв. Ии түүний далавчны дэвэлтээс үүдэх шуургыг давж гарахын тулд хөлөө газарт жийн зогслоо. Энэ зуур өндөрт исгэрэн буй салхинд эргэн тойронд байгаа модод ганхаж нуран уналаа. Ии нумнаас бэхэлсэн уяагаа хөвчирсон шугам мэт татаж мөрийг нь өвтгөж байсан ч чирсээр л байлаа. Эцэст нь салхин шувууны тамир тэнхээ барагдаж газарт уналаа. Ии түүн үрүү гүйж очижол газарт далавчаараа шурган унасан харагдана. Тэрээр сэлмээ гарган тогоосны их биес нь толгой нь тасдан авлаа.

Салхин шувуу үхлээ. Мөн цүүцэн шүдээт ч үхлээ. Гэвч Тунг-тинг нууран дээр далайн мөгой аюул тарин ноёрхсоор л байлаа. Дахиад л Ии нумаа авч цааш одов. Хэдэн өдрийн дараа нөгөө нуурын эрэгт хүрч иржээ. Энэ нь нутгийн гүний далайгаас жижигхэн нуур байсан юм. Тэнд очоод жижигхэн загасчны завь авч устай нүүр тулахаар нуур луу орж сэллээ. Тэрээр удаан бөгөөд хүчлэн сэлсээр түүний өмнө хайрслаг мангас цагираглан уснаас цоройн гарч ирж байгааг харан хартлаа хайсаар байлаа. Дөхөж очижод нуурын ус бүр ч илүү хуйлран давалгаалсаар байв. Тэрээр улаан нумаа авч эхнийхээ сумаар нөгөө мөгойн хүзүүг оносон боловч зөвхөн ус урд өмнө байгаагүйгээр өндөрт давалгаалснаас өөр юм болсонгүй. Тэрээр мөгойны их биеийг сумаар сийчиж, хилэнтэйэс тарчлан байх хүргэл дахин дахин харвасаар байлаа. Түүний жижигхэн завь шидэгдэж уул шиг өндөр их давалгаанд оров. Ингээл одоо тэр дахин харвах боломжгүй боллоо. Завь нь давалгааны усанд автагдахад тэрээр сэлмээ шүүрэн авчээ. Дараа нь мангас далайн ногоон өнгөтэй ангалын ирмэгт дагжин байхад доош үсрэн мөгийн өргөн бөгөөд гулсамттай нуруун дээр гарч очлоо.

Ингээд Иигийн мэдэх хамгийн аймшигтай тулаан болжээ. Түүний сэлэм нь ишиндээ тултал мөгойн биед байн байн зоогдож харин тэр дээрээ хүрхрэн байгаа мөгойн заналхийлсэн соёонаос биээ бултуулж байлаа. Пор пор хийн цалгилж буй нуурын ус ногоон байхаа больж харин далайн мөгойн цусны улаан хүрэн өнгөөр будагдаа. Эцсийн эцэст төгсгөл ирлээ. Сүүлчийн ганцхан ухасхийлтээр баатрын сэлэм мангасын амин тус газар нь гүн шигдлээ. Хорон санаатай мангасын

хайрслаг бие нь хөдлөхөө болж, чичрэн дагжиж, эцсийн эцэст улаан хүрэн давалгаан дор живж алга боллоо.

Ядарсан Ии нуурын эрэг үрүү хөвөөв. Түүний даалгавар дуусгавар боллоо. Есөн хуурамч нарыг устгасан ба урьд өмнө дэлхий өртөнцийн дээр хэзээ ч байгаагүй гурван мангасыг устгажээ. Гэгээн эзэн хаан Яао хүн төрөлхтний өртөнцийг амар амгалан захирч чадахаар боллоо. Агуу их мэргэн харваач Ии амар сайхандаа жаргах болжээ.



Үерийг номхотгогчид

Ноагийн үеийн Библийн газар шиг эрт дээр үед Хятадад тэнгэрийн хилгэнэл аймшигтай бөгөөд бүхнийг авч одсон үерийн хэлбэрээр гарсныг үзсэн билээ. Өнө удаан жил тэнгэрийг захирагч Шар эзэн хааныг газар дэлхийн дээрх хүний хорон арга л гунигт автуулж, уурлуулсан билээ. Эцсийн эцэст хамгийн хатуу ширүүн ял л үхлийн өртөнцийг жинхэнэ утгаар нь амжилттай авчрах явдал бөгөөд энэ ялаа хэрэгжүүлэхэд түүний сонгосон зэвсэг нь төгсгөлгүй үерийн бороог доош илгээх явдал юм гэж бодлоо. Тэгээд догшин ширүүн, хонzon өвөрлөсөн усны сүнс Кунг-кунгт үүнийг даалгасан байна. Кунг-кунг үүрэг даалгавраа ямар ч өрөвдөх сэтгэлгүйгээр хийж гүйцэтгэсэн байна.

Эхлээд бороо хүмүүсийг гадагшаа талбайруугаа гарах боломжгүй болгож гэр оронд нь шигтгэжээ. Зам харгүй намаг болгож, нүх болгонд усан сан үүсгэсэн байна. Удалгүй халхавчгүй байсан бүх зүйлс нэвт норж, ялзарч муудав. Хураасан үр тариа, тэжээлийн овоо бүгдээрээ тэр бороотой хэдэн өдөрт ашиглах боломжгүй болов. Хэврэг сүрлэн дээврүүдэд нүх гарч хүмүүс хүйтнээс, мөн өлслөнгөөс болж дагжин чичирч, зовж зутарч байлаа.

Түүнчлэн ээлж дараалан гол мөрнууд эргээ эвдэлж байв. Тал газар, хөндийд оршин суугчид, нуур буюу далайн эрэг орчмоор амьдрасад тэдний зүг ус давалгаалан ирэн удаанаар тэдний хөл доогуур урсан орж нэмэгдэж байгааг харж байлаа. Хол явж чадахгүй нэг нь тэд нарыг ус аваад явчхаас өмнө урц овоохойныхоо дээвэр дээр нь гарав. Үлдсэн нь хөрөнгө нь салхинд хийсэж ухагдсан уулан дахь агуйд хорогдож байв.

Харин зарим нэг нь хүйларсан, заналхийлсэн уснаас хол байхын тулд шувуут дуурайж, модны мочирийн оройд нь, мөн хүрч болох газар бүрт өөрслөдөө зориулан бүдүүн хадуун үүр барьж байлаа. Жууз тэрэг ямарч үнэ цэнэгүй болов. Хүн болгон завьтай болохыг хүсч, завь хийгчид өдөр шөнөгүй ажиллаж байв. Мах ч байсангүй. Эрэгтэй хүн бүр загасчин болж эмэгтэй хүн бүр өдөржингөө гэр бүлээ хооллохын тулд навчтай холтостой мод хайж байлаа. Энд бүх худаг, гол горхинууд үгүй болсон тул ууж болох ус нь үерийн бага зэрэг давстай, шавартай ус байлаа.

Үнэн хэрэг дээрээ хамгийн аймшигтай нь Шар эзэн хааны хилэгнэл байсан юм. Гэхдээ тэнд хүний өртөнцийг дээрээс нь харж тэдний зовлон бэрхшээлийг өрөвдөн байсан нэгэн сүнс байлаа. Энэ бол Шар эзэн хааны ач хүү Кун байсан юм. Түүнийг цагаан морин хэлбэртэй сүнс гэдгийг хүмүүс мэддэг байв. Кун юу ч хийлгүй, ийм зовлон шаналалыг харсаар суж чадахгүй байлаа. Түүнийг өвөг эцэг болох тэнгэрийн захирагчид хандаж уурнаасаа болж үер тарьж байгааг зогсоохыг хүсэхэд тэрээр татгалзсан билээ. Өвөг эшгийнх нь арга хэмжээ бүрэн гүйцэд биеллээ олоогүй байсан юм. Кун эзэн хааныг орхин уй гашууд автан зогслоо.

Ийнхүү гутран зогсож байхдаа сониуч хоёр этгээд түүн үрүү ирж байхыг харлаа. Нэг нь эврэктэй шар шувуу, нөгөө нь хар өнгөтэй газрын яст мэлхий байсан бөгөөд тэд бие биендээ дэм болсоор явлаа.

- Юу чамайг ийм уй гашууд хүргэв, агуу их сүнс минь? гэж ирж яваа хоёрын нэг болох шар шувуу асуулаа.

- Би хүнд учирсан зовлон шаналалыг бүрэн өрөвдөж байна гэж Кун хариулаад,

- Энэ агуу их үерээс тэдний өртөнцийг хэрхэн чөлөөлөх вэ гэдгийг одоо болтол мэдэхгүй байна гэв.

- Амархан гэж хар өнгөтэй газрын яст мэлхий хуухиран дуугарлаа.

- Та бүхэнд хэрэгтэй зүйл бол шидэт шороо юм.

- Шидэт шороо? гэж Кун гайхан уулга алдлаа.

- Энэ нь ямар юм байдаг бол?

- Энэ бол миний л хэлсэн тэр юм. Энэ бол шидэт шороо гэж газрын яст мэлхий хариуллаа.

- Энэ үнэн гэж шар шувуу дэмжлээ.

- Энэ бол түүний л хэлсэн юм. Энэ бол шороо. Чи харж байна. Газар, хөрс гээд чи мэднэ дээ. Энэ чинь шидтэй. Энэ нь чиний хүссэн хэмжээгээр өөрөө өсдөг гэсэн үт.

- Гэвч үүнийг хаанаас авах вэ?

- Өвөг эшгээсээ. Тэр түүнийг хадгалж байдаг гэж шар шувуу хэлэв. Кунд бий болж байсан итгэл найдвар нь тэр дороо алга болов.
- Тэр наадаа хэзээ ч өгөхгүй л дээ гэж тэрээр шүүрс аллаа.
- Амархан. Түүнийг хулгайл гэж хар өнгөтэй газрын яст мэлхий дахин хэлэв.

Кун түгшиж байв. Харин шар шувуу түүн үрүү дохиж, чихэнд нь шивнэнэ. Нөгөө газрын яст мэлхий мөн нэг үт нэмж хэллээ. Кун тэд нарын хэлсэн зүйлтэй санал нэг байгаагаа илэрхийлж толгой дохив. Удалгүй тэр гурав шар эзэн хаанаас шидэт шороог хулгайлах төлөвлөгөөг боловсруулахаар болов.

Харамсалтай нь одоо эртний номуудын аль нь ч тэр ямар төлөвлөгөө байнсыг билэнд өгүүлж чадахгүй байгаа боловч, үнэн хэрэг дээрээ Кун л тэрхүү үнэтэй шороог авчирч, тэр төлөвлөгөө амжилттай болсон талаар л өгүүлж байна. Хэдийвээр бид түүний хэрхэн хийсэн талаар тийм ч сайн мэдэхгүй байгаа боловч олон давуу талуутдтай байжээ гэдэг нь тодорхой байна. Шидэт шороог ордны гүнд нуусан, цоож цуурга нь бат бөх, хана нь зузаан байж, харгис хаалгачил түүнийг хамгаалж байсан боловч Кун тэдгээр хаалгачдыг нэвтрэн гарахын тулд бөөн угаанд хувирсан байсан юм. Хаалгачдыг өнгөрсний дараа тэрээр ханыг нэвтлэн гарахын тулд дорго болж хувирах хэрэгтэй болов. Ханыг нэвтэлсний дараа түүний хайж байгаа эрдэнэсийг агуулсан хайрцагны цоожийг хайлуулахын тулд тэр мөн л галын дөл болж хувирах хэрэгтэй болсон юм.

Шидэт шороог авмагцаа Кун газар дэлхий дээр бууж ирж, үертэй тэмцэж эхэллээ. Тэр нэгэн уулын орой дээрээс үржил шимтэй өргөн уудам хөндий байсан газрыг далдалсан маш их усыг харж байлаа. Кун өөрийнхөө авч явсан үнэтэй хөрснөөс буурцагнаас томгуй өчүүхэн жижиг хэсгийг таслан авч ус уруу чулуудаж, түүнд “Зогс!” гэж хэлтэл осохийг тушаалаа. Нөгөө жижиг хэсэг усны гадаргын доор орж үзэгдэхгүй болов. Удалгүй усан доороос сүүдэр үүсч харагдав. Хэсэг хутсааны дараа нуурын ёроол дээш өргөгдхө мэт гарч ирж байгаа нь илэрхий боллоо. Ёроолгүй нуурыг бий болгосон зүйл нь одоо гүехэн ус болсон байлаа. Хөрс нэг газраас нөгөө газарт гадаргыг нэвчин гарч ирж байв. Нуур нь намаг болов. Кун доорх хөндийн газрыг уснаас ангижирч байгааг харлаа. Ус шингэж дуустал шидэт шороо өссөөр л байв. Дараа нь хөндийл хүрэн өнгөтэй үржил шимтэй хуурай хөрсөөр дүүрэхэд Кун түүнийг зогсохыг тушаалаа. Тэрээр баясгалантайяа өөрийнхөө хийсэн ажлыг цэгнэн харав. Дараа нь уулын хажуугийн агуйгаас ядуу тарчиг,

азгүй хүмүүс гарч ирлээ. Тэд арайхийн хүч чадлаа олж авч байв. Гэхдээ тэд өөрслөд нь ид шидээр олгогдсон үргжил шимтгэй хүрэн хар шороонд хүрч очихын тулд уулан дээрээс ганц нэгээрээ бүдчин гарч ирж байлаа. Зарим нь үнэ цэнэтэй үртэй саваа авч ирэхээр агуй уруугаа буцан явж байгаа харагдav. Үүнийг тэд бухий л өөрчлөлтийн турш хамгаалсаар ирсэн бөгөөд энэ нь эцэст нь одоо л тарьж болох үр байсан юм.

Энэхүү эхний туршилтын дараагаар Кун ядралгүйгээр газрыг хөндлөн гулд тууллаа. Тэрээр хөндийг дүүргэж, тал газрыг бий болгож байлаа. Түүний шидээт шороог шидсэн газар бүр яг л ямар нэгэн аварга том хөвсийсөн зүйл үерийн усыг шингээж авсан мэт болгож байв. Тэр тэгш тал газарт шидээт шороондоо уртаашаа өсөхийг тушааж, хаалт далан барьж байлаа. Дараа нь тэр далангийнхаа ар талд эрчүүдийг ажиллахад зориулж шинэ талбай, бэлчээрийн газрыг бий болгож байх юм.

Гэвч Шар эзэн хааны хилэгнэлийг тийм ч амархан арилгачих эд биш байсан юм. Түүнл шидээт шороо хулгайлагдсан байна гэдгийг мэдэгдэхэд түүний уур хилэн дахин сэргэлээ. Энэ нь тэнгэрт гарсан бослого үймээн байсан юм. Түүний ач хүү урван тэрсэлжээ. Үүнд ганцхан үхлийн ял л тулгаж болох байлаа. Галын сүнс Чу-жуңг дуудаж аймшигтай захиалга өгөв. Чу-жуңг доош газар дэлхий үрүү явж эзэн хааны ач хүү Куныг цаазалж түүний хулгайлсан шидээт шороог буцаан авч ирэхээр болов.

Түрэмгий Чу-жуңг даалгавраа цаг алдалгүй биелүүлэв. Кун бол түүнд юу ч биш байлаа. Тэрээр газар дэлхийн агуу их орон зайд Куныг мөшгөн хөөж эцэст нь хойд туйлын ойролцоо оршдог Өдөн ууланд гүйцэж ирэв. Энд бүх зүйл хүйтэн, уйтгартай байлаа. Нарны гэрэл эдгээр онгон зэрлэг зүйлсийг хэзээ ч нэвтэлж байгаагүй. Туйлын бүсийг хамгаалж байдаг лаан лууны аманд байдаг лааны үл ялиг сүүмэлзэх гэрэл харанхуйг гийгүүлж байв. Өдөн уулаас холгүй үхсэний дараа хүний сүнс амарч байдаг чимээгүй хот байдаг байлаа. Энэхүү мөс харанхуйн оронд Чу-жуңг Куныг алж бисийг нь түүний хэвтэж байсан Өдөн уулан дээр орхив.

Харин тэнгэрлэг сүнсийг төгсгөл болгох нь тийм ч амар хялбар шийдэх асуудал биш байлаа. Куны өрөвч сэтгэлийн хүч, хүсэл эрмэлзлэлийн хүч нь үерээс сэргээгдэж буй газрын гадаргын дээгүүр түүнийг авч явахад хүрэлцэхүйц байлаа. Түүний бие нь амьгүй хэвтэж байсан хэдий ч энэхүү өрөвч сэтгэл, хүсэл эрмэлзэл нь үргэлжлэн амьдарч байлаа. Тэд нарын хүчээр үхсэн бие муудахаас хамгаалагдаж

байсан ба үүний улмаас турван жилийн дараа ямар нэгэн өөрчлөлт гараагүй байсан байна. Өөрчлөлт гараагүй хэдий ч мосон хаягдлын дунд Куны бие хэвтэж байгаа учир түүний биед алуулсан сүнсний агуу их хүсэл шинэ хүн – нэгэн хүүт бий болгож байв. Аажмаар гадарга доор Кунд байсан бүх хүч шинэ амьтныг бүтээхэд очиж байлаа. Үерийн бороо орсоор л байв. Кун бүхий л хөдөлмөрөө зориулж байсан ч үер хараахан дарагдаагүй байлаа. Олон газарт хүмүүс хүйтэн, өлсгөлөн, мөн нүшгэн уулын зовлон зүдгүүрт дагжин байна. Мөн зарим нэг Куны бий болгосон бэлчээрүүд нь дахин усанд живж байлаа. Куны эхлүүлсэн ажил үргэлжлэх ёстой.

Энэ бол Шар эзэн хааны айж байсан нэгэн зүйл юм. Куны бие нь турван жилийн турш Өдөн уулан дээр хэвтэж байгааг болон түүнийг амьд байхад нь байсан онго төрх нь хэвээрээ байгааг түүнд уламжлахад тэрээр аюултай гэдгийг мэдэж байлаа. Чу-жуугаар түүний гэр бүл доторх урвагчийг хороолгосон боловч түүний эрх мэдлийн эсрэг хийсэн бослого байсаар байгаал айж байлаа. Иймээс тэрээр Куны бисийг устга гэж хоёр дахь сүнсийг туйлын бүсэд илгээлээ. Энэ даалгаврыг гүйцэтгүүлэхийн тулд тэнгэрийн захирагч түүнийг юуг ч алддагтуй алдарт Вугийн сэлмээр зэвсэглэлээ.

Сүнс доош бууж, Вугийн сэлэм гялс хийхэд, Куны биед турван жилийн турш чимээгүйхэн осон торниж нуутдан байсан хүмүүн өдрийн гэгээнд гарч ирлээ. Сэлмээр Куны бие зүсэгдэхэд залуу бөгөөд хүчтэй эврэйтэй луу далавчаа дэлгэн харанхуй тэнгэр өөд дүүлэн одлоо. Энэ бол хүн төрөлхтнийг үерээс аврах гэсэн Куны хүсэл зоригтоос төрөн гарсан хүү нь байлаа. Тэр нь эцсийн эцэст усыг хяналтандaa байлагах хувь занатай агуу их Ию байсан юм.

Нөгөө луу шулуухан тэнгэрийн үүд үрүү Шар эзэн хааны байгаа газарт хүрэн хүртглээ нислээ. Тэнд Ию хүндэтгэн мэхийн ёсолж, нэн долгөөн байдлаар хүчирхэг өвөг дээдсийнх нь хамт байгаа хүмүүсийг хайж байлаа. Шар эзэн хаан Июг өөрийнхөө хаан ширээндээ түүний юу хэлэхийг хүлээн байсан нь энэ юм.

- Цог жавхлант эзэн хаантан минь, би танаас үхлийн ертөнчийн шаналж ял гүйцсэн эсэхийг бодож үзээч ээ хэмээн гүйж байна.

- Олон жилийн турш үхэж үрэгдэлгүйгээр зовсон тэд нар өлсгөлөнд нэрвэгдэж, үгээгүй ядуу амьдарсаар байна. Мэдээжийн хэрэг хүн төрөлхтний амссан аймшигт явдал, тэдгээрээс үүдэлтэй нь лавтай биз ээ? Жишээлбэл миний авын хийсэн ажил.

- Чи авынхаа тухай ярихгүй байсан чинь дээр гэж эзэн хаан түүний

үгийг тасаллаа.

- Тэр миний засаглалын эсрэг боссон хүн. Миний өөрийн ач хүү наадаас шидэт шороог хулгайлсан авч, миний ажлыг саатуулсан билээ.

- Тэрээр шидэт шороог хулгайлсан. Энэ хэрэгтээ тэр буруутай гэж Ию хэллээ.

- Гэхдээ би танаас, таны гараас, шидэт шороогоо өгнө үү гэж түйхээр ирлээ. Ингэнсээр газар дэлхий дээр болж буй үймээнийг төгсгөл болгож, өвөг дээдсийнхээ бүтээсэн дэлхий сртөнцийг бүр мөсөн сүйрэхээс аварч болох юм. Хязгаартгүй их ухаан болоод өрөвдох сэтгэлдээ миний хүсэлтийг сонсон хүлээн авна уу.

Шар эзэн хаан эргэцүүлэн бодлоо. Үнэн хэрэг дээрээ тэрээр өнгөрсөн хэсэгт хугашаанд үерийн асуудлыг хариуцуулахаар бүр урьд өмнө нь түүний томилсон сүнс Кунг-кунг нь хүн төрөлхтөнд учруулсан гай гамшигтаа тийм ч их хатуу ширүүн хандаагүй юм уу даа гэж гайхаж байлаа. Куны бослого түүний уурыг хүргэсэн билээ. Гэтэл энэхүү залуухан хүү нь түүнд хүрч ирээд номхон хүлцэнгүй, зөв хандлагаар түүнтэй харьшаж байлаа. Тэрээр хүсэлтийг нь зөвшөөрөхөөр болов. Хэрвээ тэр зөвшөөрөхгүй бол дахин шинэ бослого гарагчийг байж болохыг хэн хэлж мэдлээ. Куны бүхий л халуухан хүч залуухан хүүд нь түүнийг бүтгэж байх гурван жилийн турш дамжсан билээ. Хэрвээ түүний засаглалын эсрэг ийм сүнс босох юм бол тэнгэрийн гэр булийн амгалан тайван байдалд аюул учрах байлаа.

- Чиний хүсэлтийг зөвшөөрлөө гэж Шар эзэн хаан мэдэгдэв. Тэрээр дохиход нэгэн хар өнгөтэй газрын яст мэлхий хаан ширээ үрүү нь алгуурхан дөхлөө. Энэ бол бүр урьд өмнө нь сүнс Кунд зөвлөж байсан ногеө хар өнгөтэй газрын яст мэлхий байлаа. Тэр цагаас хойш түүнд өршөөл үзүүлсэн байжээ.

- Энэхүү амьтны өргөн нуруун дээр овоолох хангалттай шидэт шороо танд байгаа байх аа. Тэр таны өмнөөс газар дэлхийн хaa сайгүй түүнийг аваачих болно.

Эзэн хаан хоёр дахь удаагаа дохилоо. Жигүүртэй луу орж ирээд түүний өмнө мэхийн ёсolloо.

- Энд тэрхүү бослогыг дарагч Ч-Их-Юу байна. Энэ чамд ажилд чинь туслах болно. Харин авын чинь тухайд гэвэл түүний сүр хүч нь чамд ирсэн бөгөөд түүний даалгаврыг чи гүйцээх болно. Ч-Их-Юу нь шар өнгөтэй луугийн хэлбэртэй бөгөөд тэрээр түүний гэр болох Өдөн агуйд ажлаа гүйцэтгэснийхээ дараа амьдрах ёстой билээ. Ажилдаа алдаа бүү гаргаарай.

Ию баяр хөөртэйгөөр хааны дэргэдээс холдлоо. Тэрээр нөгөө хар өнгөтэй газрын яст мэлхийн авч явж чадахаар хэмжээний шидэт шороог аваад хүн хэлбэрт орж, өөрийнхөө нөхдийн хамтаар газар дэлхийд эргэн ирлээ. Гэвч түүнийг ирэхэд урьд өмнө байснаас бүр муу үймээн самуун болсон байхыг үзлээ. Усны сүнс Кунг-кунг Шар эзэн хааны түүнийг устгах ялын шинэ аюулыг сонсон хилэгнэсэн байлаа. Газар дэлхийг бүрхсэн усыг цалгиулж халгиулан тэрээр ур хилэнгээ гаргажээ. Дөлгөөхөн зах хязгааргүй нуур цөөрөм нь одоо хүчтэй хүйларсан далай болсон байлаа. Үерийг давж туулахаар хичээж буй хүмүүстэй очижжэн жижиг завьнууд босч ирж буй давалгаанд живж байлаа. Мөчруүд дээр нь хүмүүс шувуу шиг үүр зассан өндөр молнууд цалгин ирэх усаар шүршигдэн ороолгуулж байв. Хүйларсан энэ их ус урьд өмнө нь юу ч хүрч байгаагүй уулын агууд хүртэл цалгин байв. Энэ нь хүн төрөлхтөнд учирч байгаагүй хамгийн аймшигтай гэсгээлт байлаа. Энэхүү хүчтэй шуурганы үед орилоон чарлааны аймшигтай их дуун сонсогдож байв.

Ажлаа эхлэхийнхээ өмнө Ию эхлээд Кунг-кунгийг дарах хэрэгтэй байлаа. Ингээд тэрээр Хүи-чи уулан дээр байрлан тэндээ бүхий л сүнснүүдийг авч ирэн өөрийнхөө өмнө цуглууллаа. Сүнснүүд Июгийн зарилгыг сонсохоор цугларч байсан учир агаарт яарч тэвдсэн дуу хоолой дүүрэн байлаа. Кунг-кунг болон үер усны хамгаалагчаас бусад нь бүгд ирсэн байлаа. Үер усны хамгаалагч хожигдож ирсэн бөгөөд Ию түүнийг урвалаа хэмээн сэжиглэж байв. Тэрээр шууд үйл ажилагаандаа оров. Эрсдэл даах зөвшөөрөл олгох нь түүний даалгаврын хамгийн хэцүү нь байлаа. Тэрээр бусдад аймшигтай сануулга болгож үер усны хамгаалагчийг Хүи-чи уулнаа цаазлав. Тэд түүний биеийг нь оршууллаа. Олон зууны дараа Хүи-чи уулан дээрээс аварга том ясыг гаргаж ирсэн билээ. Тухайн үеийн хүмүүс түүнийг үер усыг хамгаалагчийн яс гэж таньсан юм. Ганцхан ясыг нь олон хүн зовж байж өргөж байсан ба түүнийг том тэрээр авч явваад маш хүнд ачаа байсан аж.

Ию цугларсан сүнснүүдэд усны сүнс үрүү дайрч довтлохыг тушаалаа. Өөр лүү нь дөхөж байгаа агуу их армийг харж байхдаа Кунг-кунг айдас хүйдсээр дүүрэн байлаа. Тэрээр зугтлаа. Хэн ч түүний нутгdsan байж болох газрыг мэдэхгүй байлаа. Одоо л агуу их Ию түүний аавын хийж байсан ажил яагаад дуусалгүйгээр үлдсэнийг дүгнэж чадах байлаа. Шидэт шороог авч явсан тэрээр нөгөө хар өнгөтэй газрын яст мэлхийг дагуулан газар дэлхий дээгүүр хaa сайгүй явж байв. Яг л урьд өмнө аавынхаа хийж байсанчлан хөндийг дүүргэж, тал газарт далан босгож,

далангийн хажуугаар тариаланчлад зориулсан шинэ газруудыг бий болгожбайлаа. Ус гүехэнбайсан газруудааруулнуурудыг сүндэрлүүллээ. Тэдгээрийн оргилууд болоод нуруудыг бид одоо мэдэх билээ. Үргэлж л Ию өөрийнхөө өмнө нөгөө жигүүртэй луут жолоодож явлаа. Луугийн сүүл хүрсэн газарт усны судал бий болж байсан ба тиймээс Ию талын үерийн усыг гадагшлуулах агуу их гол мөрнийг бүтээж байв. Ию гучин жил зогсолтгүйгээр ажиллав. Гэвч эцсийн эцст тэрээр өөрийнхөө амьдралыг, түүнийгээ хуваалцах эхнэр хэрэгтэй байгаа талаараа бодож эхэллээ.

“Газар дээрх миний амьдралын өдрүүдэд миний хань, эхнэр минь болох хувь занаятай төрсөн нэгэн эмэгтэй хаа нэгтээ байх нь дамжитгүй” гэж тэрээр өөртөө хэллээ. “Би түүнийг яаж олж таних вэ? Түүний байгаа газрыг зааж өгөх ямар нэгэн шинж тэмдэг байгаа болов уу?”

Энэ бодол түүний толгойд орж өнгөрөх үед тэрээр өтгөн бургасан шугуйд дөхөж ирж байлаа. Гэнэт модон дундаас түүнийг чиглэн жижигхэн амьтан гүйн гарч ирлээ. Энэ бол цагаан өнгөтэй есэн сүүлтэй үнэг байлаа. Тэр эргэж хараал зугтхахад нутгийн хүмүүсийн дуулдаг байсан нэгэн дуу Июгийн санаанд нь орлоо. Үг нь сонин байсан бөгөөд ямар нэгэн юмыг урьдчилан хэлж байлаа:

Есон сүүлтэй цагаан үнэг харах юм бол
Түүнд хааны ширээ залгамжлан ирнэ
Т У-шан уулын охинтой гэрлэх юм бол
Эрүүл үр удамтай болох болно

Тэр цагаан үнэг үнэхээр онцгой шинж тэмдэг нь байсан юм. Хэдийгээр тэрхүү зөгнөлийг бүрэн ойлгоогүй байсан боловч Ию Т У-шан уулын зүт чиглэлээ. Тэнд тэрээр аятайхан, үнэнч шударга, ухаалаг харцтай нэгэн охиньг олж харлаа. Тэр охин нь Ню-чиао байсан бөгөөд анх ажлаа эхэлсэн Х У-чи уулиаа түүнтэй гэрлэжээ. Гэвч Июгийн хувыг гэр бүлийнх нь амьдрал амгалан тайван байсангүй. Тэрээр үүрэг даалгавраа гүйцээхээр дахин буцаж ирэв. Ню-чиао түүнийг дэлхий даяар аялахад нь цут явсан бөгөөд түүний ажилд нь тусалж байлаа.

Ию, Ню-чиао нарын хүү Ч-И сонин байдлаар төрсөн байна. Хуан-Июан уулын үерийн байдлыг ажиглаж байгаад Ию уулыг нүхэлж гарах хэрэгтэй юм байна гэж шийд гаргажээ. Тэнд аймшигтай цул чулуутай байсан бөгөөд нүх ухаж малтахын тулд Ию өөрөө аварга том баавгай болж хувирах шийдвэр гаргалаа. Хүчтэй хурц савраараа чулууг малтан

хаяж гарлаа. Удалгүй ажилдаа улайрсан тэрээр Ню-чиао түүнд үлдээс хойш хоол авчирч өгнө гэж байсныг мартсан байлаа. Уулын гүнд нь нүх гаргаж байсан тэр уулын орой дээрээс буюу түүний нүхээ малтаж эхэлсэн газраас Ню-чиаогийн хоолой цуурайтан байгааг сонсоод ихэд гайхлаа. Түүнийг сонсохын тулд аварга том савраа татаж аваад өрвийсон толгойгоо дээш өргөлөө. Тийм ээ энэ бол түүний эхнэр байлаа. Баярласан тэрээр өөрийнхөө ухсан нүхийг даган бушаж харайлган гарлаа. Гэвч тэр сэтгэл догдолсноосоо болоод өөрийнхөө хуучин дурийн талаар бодсонгүй. Гарсан дээр хүлээж байсан Ню-чиао өөрийнхөө нөхөртэй биш, нүхнээс гэнэт гарч ирэх нүсэр том баавгайтай учрах нь тэр.

Айсан тэрээр бушаад зугтав. Ию түүнийг тайтгаруулахын тулд дуудахад тэрээр зэвүүцсэн янзтайгаар өөрийнх нь нөхөр байсныг мэдлээ. Магадгүй энэ бол түүний үнэн төрх нь байж болно. Одоог хүртэл тэрээр зүсээ нууж байсан юм болов уу! Зүрх сэтгэлд нь айх, ичих холиллон байлаа. Тэрээр хурдан хурдан гүйж байсан боловч баавгай түүний ардхан талд нь хүнд хүнд гишгэлэн явж байсан ба хэзээ ч түүнд ойртох байгаагүй билээ. Энэ замд Ню-чиао зугтаж, Ию баавгайн дүрээрээ түүний араас хөөж хэдэн бээрийг барав. Эмэгтэйн зүрх бараг хагарах дөхөж, хүч чадлаа алдаж эхэллээ. Тэр бүдрэн унаж, дахин хүчээ аван босч цааш гүйсээр байлаа. Одоо тэрээр өөрийнх нь өмнө эгц хажууд сүндэрлэн байхыг харлаа. Энэ бол Өндөр оргил байсан юм. Ийм өндөрт тэрээр хэзээ ч гарч чадахгүй гэдгээ мэдэж байлаа. Аргаа барсан тэрээр нөхөр болох баавгайн дайралтаас хамгаалахын тулд үхэр чулуу болон хувирч Өндөр оргилын бэл үрүү орлоо.

Эхнэрийнхээ зугтсан явдалд Ию яахаа мэдэхгүй тэвдэн байлаа. Тэрээр үхэр чулууны өмнө мухардалд орон зогсоходоо нэг л зүйлийг боллоо. Хойд хоёр хөл дээрээ дээш цоройн, “Хүүг минь өг” гэж тэнгэрийг доргитол хашгилаа.

Үүний хариуд үхэр чулуу хагарлаа. Энэ нь Ч-И торж буй явдал байна. Июгийн хүү Ч-И хагарсан үхэр чулуунаас гарсан хоёр луу унасан маш царайлаг эр байлаа. Тэрээр хөгжимл дуртай байсан бөгөөд түүнд хүний ертонц хамгийн ховор зохицлыг бий болгосон байна. Ч-И өөрийнхөө лууг байнга унаад тэнгэрийн шүүх үрүү явдаг байлаа. Тэнд баяр ёслолын үеэр тэр газар дээрх хүмүүс мэддэггүй байсан тийм хөгжмийг сонсдог байлаа. Тэрээр энэ хөгжмийг тэмдэглэн авч дэлхий ертонцөд өгөхөөр өөртөө нууцлан авчирсан билээ.

Гэхдээ энэ нь хожмын өдөр болсон явдал юм. Ию өөрийнхөө ажлыг

хараахан дуусгаагүй байлаа. Тэрээр уулыг өсгөж, гол мөрний усыг ширгээж, үргжил шимтэй тал нутгаас үерийн усыг хөөн зайлтуулахдаа газрын өргөн уудмыг хэмжсэн байна.


Үүний хийхийн тулд хоёр сүнсэд даалгажээ. Нэг нь газрыг хойноо нь урагш, нөгөөх нь зүүнээс нь баруун тийш алхаж хэмжих байлаа. Нөгөө хоёр сүнс ажлынхаа талаар тайлагнахад тус бүр хоёр зуун гучин гурван мянга таван зуун ли далан таван алхам байгааг олж мэдсэн байна (Гурван ли нь нэг бээртэй тэнцэнэ). Иймээс газар яг хавтгай дөрвөлжин хэлбэртэй байв. Судалгаа хийж байхдаа сүнснүүд олон үерийн усны нүх дахин давалгаалан гарч ирэх боломжийг хүлээн ус орсон ан цав цууралтуудыг дайран өнгөрсөн байна. Өргөнөөрөө найман алхмаас том нүхнүүдийн тоо хоёр зуун гучин гурван мянга таван зуун тавин ес байв. Энэ бүгдийг Ию зогсоосон бөгөөд харин жижиг нүхнүүд нь тооны хувьд маш олон байсан учир тэр бүгдийг зохицуулж, арга хэмжээ авах чадалгүй байлаа. Тийм учраас дэлхий өртөнц одоо ч гэсэн үерт нэрвэгддэг билээ. Гэхдээ энэ нь Июгийн үсийн агуу их сүйрэлтэй харьцуулах юм бол хормын төдийхон хэмжээтэй байдаг юм.

Бурхдыг газар дэлхий дээр зочлоход нь зориулж орд харшаар хангахыг хүсч Ию тэнгэрээс Кун-лун уулын нуруудыг ухан авч газар дээр зөөж авчирсан юм. Түүнийгээ Хятадын баруун хил дээр авчирч байрлуулсан бөгөөд одоо ч тэндээ байсаар байгаа билээ. Тэд нар нь газар дэлхийгээс тэнгэр хүрэх шатыг үүсгэдэг. Гурван оргилынх нь тухайлд гэвэл хэрвээ хүн эхнийх нь оргилд авирч гарах юм бол ухэшгүй мөнхийн хутгийг олдог болох юм. Хоёр дахь уруу нь авирах юм бол илшидийн хүчийг авах ба салхи бороог захирна. Хэрвээ гурав дахь уруу нь авирах юм бол тэнгэрт хүрч, сүнс болох юм.

Агуу их Июгийн баатарлаг амжилт нь дэлхий өртөнцийн хүмүүсээс талархлын мөндөр хүртсэн билээ. Эртний дууны зөгнөл биеллээ олж, тэд түүнийг эзэн хаан болгосон ба дөрвөн зуун гучин есөн жилээс багагүй хугацаагаар оршин тогтиносон Хсиагийн эзэнт улсыг байгуулжээ. Ию өөрөө түүнийг зөвхөн найман жил захирсан билээ. Тэрээр хаан ширээнд залрахдаа аль хэдийнээ нас дээр гарсан байсан юм. Эцэст нь тэр Ню-чиаотой гэрлэсэн Хүи-чи ууланд явж байхдаа насан эцэслэжээ. Түүнийг тэнд оршуулсан боловч сүнс нь мөнхөд оршихоор тэнгэрт буцаж ирсэн билээ.

Июг оршуулсан агуу их агуйг одоо ч Хүи-чи уулнаа харж болох бөгөөд тэнд мөн Июгийн бусад баатарлаг үйлсийн ул мөр ч байдаг юм. Шанси, Шинси мужуудын зааг дээр голын хоёр талд унжсан

зовхи шиг өнгийсөн хадан цохионууд бий. Энэхүү түрж орсон хадан цохионуудын доогуур олон жилийн өмнө Ию, тус бүс нутгийн үерийн усыг юулж байсан ангал байдаг. Тэр газрыг Лунг-мэн нэргтэй луугийн үүд гэдэг билээ. Жил бүр тодорхой хугацаанд далай тэнгис, голын загас бүгд энэ цэгт цугларч тэмцээн зохиодог. Тус бүр угсгүй газраас өнгийсөн хадан цохиог хөндлөн үсрэх оролдлого хийдэг. Хичээл зүтгэл нь талаар болсон загаснууд голдоо ирж бушаж үлддэг. Харин Лууны үүдийг чөлөөлсөн загаснууд нь тэр даруйдаа луунд хувирэн үсрэлтээ үргэлжлүүлж, тэнгэрийн хөх бунхан уруу дүүлэн оддог билээ.



Өөрөө чанагдсан хоол

Залуу хөвгүүний дагах ёстай бүх зочдын дотроос түүнтэй гэрлэж, эхнэрээ болгон аз жаргалтай амьдрах гэж байгаа бүсгүйг дагах нь хамгийн хэцүү нь билээ. Эрт дээр үед Хятадад залуу эрчүүд эхнэрээ эрж олох эрэл дуусахаас өмнө олон саад бэрхшээлийг даван туулах хэрэгтэй болдог байлаа. Ингээд Хсиех Туаны сүйт бүсгүйгээ эрж олох явдал нь бүтэлгүйтсэн талаар өгүүлье.

Туан нь 18 настай, цэх шулуухан биетэй, царайлаг залуу юм. Тэр шүүгчдийн танхимд ажилладаг даруухан бичиг хэргийн ажилтан байлаа. Гэхдээ тэр урам зоригтой ажилладаг байсан ба түүнийг мэддэг хүмүүст шударга зантай, юманд хүндэтгэлтэй ханддаг гэсэн сэтгэгдэл төрдөг байжээ. Эцэг эх хоёр нь түүнийг бага байхад нь нас барсан ажээ. Гэвч сайхан сэтгэлтэй хөрш хөгшин Ванг нь түүнийг авч өөрийнхөө хөвгүүдийн адил өстгөжээ. Одоо Туан эрийн цээнд хүрч, өөрийн гэсэн бяцхан сууцанд амьдрах болжээ. Гэрээсээ холгүй жижигхэн зурvas газартай байв. Өдөр бүр танхим дээрх ажлаа дуусгаад, тэндээ ирж, будааныхаа ургамал болон бууршиа арчилж торддог байлаа. Туанд эхнэр олуулахаар нэгэн зуучлагчийг хөлслөн авсан хүн бол хөгшин Ванг юм.

Зуучлагч суурингийн захад амьдардаг тариачны охин царайлаг Ч-Енийг санал болгохээ. Гэвч тэд нарын төрсөн өдрийг нь харьцуулж үзэхэд Ч-ЕН бүсгүй муур жил төрсөн болох нь тодорхой болов. Туан нохой жилтэй байсан юм. Нэгэн дээвэр дор муур нохой хоёр хэзээ ч амгалан тайван амьдардагтүй билээ. Хэсэг хугацааны дараа зуучлагч дахин нэг оролдлого хийсэн байна. Гэвч энэ удаад залуу хатагтай нэгэн зүйл буруу байсан нь түүний нэрээ бичсэн үсэгт нь байв. Тэр үсгүүд “мод” гэсэн утгатай тэмдэглэгээг агуулж байсан ба Туаны нэрэнд “газар” гэсэн утгатай тэмдэглэгээ байлаа. Одоо модон анжис газрыг сэндийлдэг учир мод газрыг дийлийнэ. Иймээс Туан энэ бүсгүйтэй

гэрлэх юм бол өөрийнхөө гэрийн эзэн нь байж чадахгүй.

Дараа дараагийн хос болох хүнийг авч үзсэн ч бас л тохиорхгүй байлаа. Бусад зүйлс нь тохирсон боловч хүмүүс Туаныг охидтойгоо гэрлүүлэхэд тун ядуу юм хэмээн татгалзсаар байлаа. Гэхдээ энэ бүхэн Туанын өдөр тутмын ажилд ямар нэгэн өөрчлөлт хийсэнгүй. Түүний ажил тахиа донгодах цагт шүүгчдийн танхим уруу явахаар эхэлж, харуй бүрий болоход өчүүхэн жижиг талбайгаа боловсруулах ажлаасаа гэртээ буцаж ирснээр дуусдаг байлаа.

Нэгэн шоно Туан гаапуугаа мөрөн дээрээ тавиад талбайгаасаа сууц уруугаа хүрдэг нарийхан зөрөг замаар ганцаархнаа айвуу тайвуухан алхалж байлаа. Тэрээр ердийнхөөсөө оройтож ажилласан бөгөөд харанхуйд далан дээр сандайлж суун сар гарахыг хүлээсэн аж. Тэр нь бүтэн сар байсан бөгөөд гэрэл нь өөрийнх нь сүрлэн байшингийн дээвэр дээр тогтсон цас шиг тусч, чинээлгэ хөршүүдийнх нь ваaran дээвэр дээр буусан цан шиг гялбан байв. Тэрээр муштигсан нарийхан замаа даган доош харж явлаа. Замын захал түүний хөлийн дэрэгдэх нэгэн чулуун дээр сарны гэрэл сүүмэлзэн тусав. Гэхдээ урьд өмнө нь тэнд хэзээ ч чулуу байгаагүй билээ. Ер нь ингэхэд энэ үнэхээр чулуу юм болов уу? Тэрээр бөөрөнхий бөгөөд орой дээрээ үзүүртэй байлаа. Тэр тонгойн ойртож харахад чулуу биш харин эмгэн хумс байв. Агуу том, бараг жижигхэн хувингийн хэмжээтэй эмгэн хумс байлаа.

Ийм ховор зүйл олох нь мэдээжийн хэрэг агуу их аз ирэхийн шинж тэмдэг байлаа. Баярласан Туан эмгэн хумсыг эвтэйхнээр гар дээрээ өргөн авч гэр лүүгээ яаран одлоо. Тэр замдаа түүнд идүүлэх гэж зарим нэг шүүслэг навчсыг түүж авав. Гэрийнх нь үдэнд дотор талд байдал том бөгөөд дотроо зйтай юм хадгалдаг шавран вааранд тэдгээрийг хамтал нь хийв. Азтай байгаадаа баярласан тэрээр унгахаар хэвтлээ. Өглөө сэргэнгүүтээ бодсон анхны бодол нь вааран доторхыг харах байсан бөгөөд эмгэн хумс өглөөнийхөө хоолыг их идсэнийг нь харахад түүнд таатай байдал байлаа.

Дараа нь бүр ч сохирихолтой зүйл тохиолдов. Туан урьдын адил танхим уруугаа яваад үдээс хойш талбай уруугаа явахын өмнө үмх юм идэхээр гэртээ буцаж ирэв. Бяцхан гэртээ орж ирээд ширээн дээр аяга, савх тавиастай байгааг олж харлаа. Чанасан будаа, ногоотой тавагнаас шүлс гоожим уур савсаж, дөнгөж шүүрдсэн шалан дээр угаалга хийдэг том түмпэн нь халуун усаар дүүрэн, хэрэглэхэд бэлэн болсон байлаа.

“Хүмүүс ямар зэлдэг юм бэ” гэж Туан бодоод гар нүүрээ угаагаад хоолондоо дайран орохоор доош завилан суулаа. “Энэ хатагтай Ванг л

байж таарах нь, тэр л надад гэнэтийн бэлгэ өгөхөөр нуушаар хийж. Энэ чинь ямар сайхан зүйл бодож олоо вэ!”

Тэрээр амыдралдаа ийм сайхан амттай хоол хэзээ ч идэж үзээгүй байв. Угаалга хийж дуусмагцаа талархлаа илэрхийлэхийн тулд тэр хатагтай Вангийн гэр лүү харайлган очлоо. Гэвч тэрээр алдсан байжээ. Хатагтай Ванг түүний сурлэн байшингийн дэргэдүүр явагүй ажээ. Ингээд хэн байж болохыг төсөөлж чадсангүй. Дараагийн өдөр нь танхимаасаа гэртээ бушаж ирэхэд мөн л яг ижил зүйл тохиолдлоо. Туаныг орж ирэхэд бүр илүү сайхан үнэртгэй шарсан гахайн махан онхруүш, жигнэсэн будааны хамт байсан тавагтай ширээ угтлаа. Өлссөн тэрээр савхaa аваахдаа энэ хэн юм бол oo гэж дахин сайтар бодлоо. Эцэст нь түүнд нэгэн санаа төрлөө. Энэ бол буруу жилд төрснөөсөө болоод түүний эхнэр болж чадаагүй боловч ганцаархнаа байгаад нь оровдлон эхнэртэй болтол нь түүнд туслахаар шийдсэн хөөрхөн бүсгүй Ч-Ен байна.

Ингээд тэрээр Ч-Ен бүсгүйн сайхан сэтгэлд нь талархлаа илэрхийлэхээр хотын захын тариалагийн талбай уруу явлаа. Харин Ч-Ен бүсгүй энэ талаар хатагтай Вангаас ч илүү мэдэхгүй байлаа. Үнэнээ хэлээч гэж Туаныг хичээнгүйлэн гүйхад тэр бүсгүй түүнийг шоолж эхлэв. “Би чиний яриад байгаад чинь итгэхгүй. Чи аль хэдийнээ эхнэртэй болчихсон хэрнээ түүнийгээ нуугаад байна гэж би бодож байна. Тэр үргэлж л танай гэрт байдаг боловч чи түүнийг хүмүүст харуулахгүй байна. Тэгчхээд хэн нэгэн өөр хүн хоолыг чинь хийгээд байна гэж дур эсгээд байна” гэлээ.

Урьд өмнө нь гайхаж байгаагүйгээрээ гайхсаар Туан гэртээ бушаж ирлээ. Том шавран вааранд байрлаж байгаадаа маш их баярлаж байгаа мэт санагдсан эмгэн хумсаа хооллох замдаа тэрээр хулсны шинэхэн нахиаг түүж авч ирэв.

Нэг долоо хоногийн турш өдөр бүр яг л нэг л зүйл үргэлжлэн тохиолдсоор л байлаа. Өдөр бүр гэртээ ирэхэд Туаны ороо нь цэвэрхэн, угаадаг ус нь дандаа халуун, хоол нь ширээн дээрээ бэлэн болчихсон түүнийг хүлээж байдаг байв. Энэ тухай мэдээ бүх хөршүүдийн дунд тархсан боловч хэн ч энэ оньсогыг тайлбарлах гээгүй билээ. Эцэст нь Туан үүний үндэслэлийг тогтоохоор шийдлээ. Тэрээр урьдын ашил тахиан дуунаар гэрээсээ гарав. Нар дээр гарсан үед тэрээр нуушаар бушаж ирээд, гэрт юу болж байгааг харахаар хашааны гадна талд нуутгдлаа.

Хэсэг хугацааны турш юм бүхэн байдгаараа л байв. Дараа нь гэнэт

нэг юм болов. Хаалганы завсраар том шавран ваарнаас нэг гар гарч ирж байхыг харлаа. Дараа нь ногөө гар. Торгон номрөг номөрч, сайхан хувцасласан хөөрхөн залуухан бүсгүй болж ваарнаас авиран гарч ирж, өрөөн дотуур явж, буланд байсан зууханд хүрч очлоо.

Туан хурдхан гэгч нь нуугдаж байсан газраа орхин, гэртээ орж ирлээ. Тэрээр эхлээд юм хадгалдаг байсан ваарныхаа дотор талыг үзэхийт хүслээ. Тэнд эмгэн хумс байсангүй харин хоосон хясаа л байлаа. Буланд зуухны хажууд нөгөө охин хана налан, түгшин зогсож байлаа.

- Чи чинь хэн бэ? Чи хаанаас гараад ирэв, яагаад миний өмнөөс гэр орныг маань харж хандах болов? гэж Туан асуу.

Охин юу ч хэлсэнгүй. Түүний айсан нуд өрөөгөөр тэнүүчилж, тэрээр шавран ваар луу ухасхийхээр оролдсон боловч Туан түүнийг хориглов.

Эцэст нь тэр ингэж ярилаа. Түүний дуу хоолой нь тунгалаг бөгөөд цангинах жад шиг хөөрхөн байлаа.

- Би бол шидэт дагина гэж тэр хэлээд цааш нь

- Намайг Цагаан давалгаа гэдэг. Тэнгэрийн эзэн чамайг өнчин бөгөөд ганцаараа амьдардаг учир өрөвдсөн юм. Мөн чи ажилдаа шаргуу, үнэнч шударга, бас зэлдэг учир чамайг харж хандаж бай гэж тэр намайг илгээсэн юм. Би өөрийг чинь баян болоод гэрлэж эхнэр авталь өөртэй чинь арван жилийн турш хамт байхаар байлаа. Тэгээд өөрийг чинь орхиод үлгэрийн оронд буцаж очих байсан юм. Гэвч одоо чи намайг нууцаар харж миний жинхэнэ төрхийг харчихлаа. Үүнийг энгийн хунд зөвшөөрдөггүй юм. Би нэн даруй явах ёстой. Чи танхим дээрээ ажлаа сайн хийж өөрийнхөө бүхий л хүчээр газраа боловсруулах ёстой. Гэхдээ чи вааранд орхисон миний хясааг хадгалж авч үлдэж болох юм. Түүнийг будаа хадгалахад ашиглаарай. Зөвхөн өлсгөлөнгийн аюул ирэхэл л түүнийг хоосолж болно. Тэр шууд л будаагаар дахин дүүрэхийг чи олж харах болно гэлээ.

Туан хий дэмий л түүнийг үлдэхийг гүйлаа. Ямар ч хичээл зүтгэл нэмэр болсонгүй, тэр явах ёстой байлаа. Тэнгэр харанхуйлж, шуурга дэгдэж, салхи исгэрэн, бороо дээврийг нь гүядан байв. Цагаан давалгаа өрөөгоор хөнгөн гүйж, хаалгаар гадагш гарч, гарсаа алдлан, алс хол салхиар дүүлэн одлоо. Эхэлсэн шигээ салхи шуурга гэнэтхэн намдлаа. Тайван өглөөний цагаар Туан нүдэндээ дүүрэн нулимтай үлдэн хоцорлоо.

Хисех Туан шидэт дагина Цагаан давалгаанд зориулж жижигхэн шүтээн босгосон ба найр наадмын өдруүдэд тэнд байнга өргөдөг

байлаа. Тэр цагаас хойш Туан хэзээ ч хүнсээр гачигдаж байгаагүй билээ. Тэрээр онцгой баян хүн болоогүй ч, эцсийн эцэст бүхий л амьдралынх нь туршид түүнийг аз жаргалтай байлгасан эхнэртэй гэрлэсэн билээ. Тэрээр ямагт даруухан бичиг хэргийн ажилтан хэвээр байсангүй, харин өөрөө нутгийн шүүгчдийн нэг нь болж амьдран суусан билээ.



Хэрхэн гэрлэдэг вэ

Бас нэгэн гэрлэхийг хүссэн хүн бол Уэй Ку байлаа. Эцэг эх нь түүнийг жаахан байхад нас баржээ. Тэрээр эрийн цээнд хүрч өөрийн гэсэн гэр бүлтэй болохын тулд эхнэр авахаар болов. Сүйт бүсгүйгээ алс хол, өргөн уудам нутгаар хайлаа. Гэвч энэ нь тийм ч хялбар шийдэх асуудал биш байсан юм. Ямар нэгэн юм ямагт буруу явж байгаа мэт санагдаж байлаа. Эцэст нь тэр өөрийнхөө төвөгтэй асуудлын талаар нэгэн найздаа ярихад тэр нь дүүрэгтээ шинээр ирсэн нэгэн албан тушаалтны охинтой гэрлүүлэх ажлыг зохион байгуулж, түүний зуучлагч болно хэмээн амлав. Найз нь шинээр ирсэн албаны хүнийг тэр орой нь урьж, дараа өдөр үүрээр Уэй түүнтэй Лунг-Хsing сүмийн гадаа уулзана гэснийг дуулгахаар болов.

Уэй Ку найзыгаа тэр шонен унтичихгүй байгаа гэж санаа нь зовж байв. Тэр үүр шайхаас өмнө босч найзыгаа ирэхийг хүлээхээр сүмийг зорилгоо. Тэнд түүнийг ирэхэд сартай байсан ба сүмийн шатан дээр нэгэн настай хүн сарны гэрэлд ном уншин сууж байлаа. Уэй Ку түүний юу уншиж байгаагаа нь сонирхон мөрөн дээгүүр нь харав. Гэвч тэр харсан зүйлийнхээ хөл толгойг нь мэдэж чадсангүй.

- Та юу уншиж байгаагаа хэлж өгнө үү гэж тэрээр настай хүнээс асуув.

- Би ингэж бичсэн зүйлийг урьд өмнө харж байгаагүй юм байна. Би хүүхэд байхдаа их л уншиж байсан. Гэвч би ийм хэлбэртэй Хятад үсгийг мэдэхгүй юм байна. Энэ бас Энэтхэгийн бичиг ч биш байна. Энэ юу юм бэ? гэхэд настай хүн инээв.

- Чи үүнийг яаж таних вэ дээ гэж тэр хэлэв.

- Энэ чинь хүний ертонцийн ном биш, газар доорх ертонцийн бичиг байна. Хэрэв энэ тийм юм бол, та бас доод ертонцэд хамаарах нь. Та энд юу хийж байгаа юм бэ? гэж Уэй Ку хэлэв.

- Би танаас ижил асуулт асууж болох нь ээ дээ гэж настай хүн хариулав.

- Доод өртөнцийн бид нар үхэгсдийн хэргийг зохицуулах ёстой бөгөөд үүнийг бид танай өртөнциөөр дахин дахин зочлолгүйгээр хэрхэн хийж чадах билээ. Биднийг хэн ч мэддэгтүй учир хааяа ирэхдээ бид болгоомжтой байдаг. Энэ удаад би тийм их удаан энд байв уу эсвэл чи эрт ирчхэв үү. Ямартай ч бид уулзалдлаа. Одоо салах цаг боллоо.

Тэрээр ном уруугаа буцав. Харин Уэй Ку дахиад ихийг мэдэхийг хүсч байв.

- Та хүмүүсийн үйл хэргийг тохинуулах талаар ярьж байна. Ямар тодорхой үйл хэргийг хариуцдаг болохыг чинь би танаас асууж болохсон болов уу гэж тэр үргэлжлүүлэн хэлэв.

Настай хүн санаа алдан, дахиад номоо тавиад,

- Би хүмүүсийн гэрлэлтийн талаар анхаарал тавыдаг гэж хэлэв.

Уэй Кугийн царай баярласнаасаа болж гэрэлтэн,

- Тэгэхээр чи бол миний хайж байгаа хүн – сүns гэсэн үг байна. Миний эцэг эх намайг маш залуу байхад, надад эхнэр олж өгөхөөсөө өмнө нас барсан. Би хэдэн жилийн турш эхнэр болох хүнээ хайсаар л байна, амжилт олсонгүй. Миний нэг найз шинээр ирсэн шүүгчийн охинтой намайг танилцуулахаар оролдож байгаа. Энэ удаад би амжилттай байх болов уу? гэв.

- Би нэг үзээтгэхье гэж настай хүн хэлээд хайж байсан хуудсаа олтлоо номоо эрхий хуруугаараа эргүүлж байв. Тэр хуудсыг нэгэн мөчийн турш уншсанаа толгойгоо сэргсэн,

- Үгүй ээ! гэж тэр хэлээд,

- Чиний ирээдүйн эхнэр чинь одоо гурван настай юм байна. Чи түүнтэй арван долоо хүрэхээр нь суух болно гэлээ.

Арван дөрвөн жил хүлээх ны! Уэй Ку цөхөрсөн хэдий ч настай хүний хэлсэн үнэн үгэнд эргэлzsэнгүй. Тэрээр тунигтайгаар буцаж алхлаа. Ингэхдээ тэрээр настай хүний хажууд шатан дээр нэгэн цүнх байхыг олж харлаа. Түүний амсар нь нээлттэй байсан бөгөөд улаан өнгийн уастай давхарласан дамар байх шиг байв.

- Энэ утсыг юунд хэрэглэдэг юм бэ? гэж тэр асуув.

Дахиад л настай хүн Уэйг мартсан мэт номондоо шимтлээ. Тэрээр дээш харан, цухалдангуй дуугаар хариуллаа.

- Энэ утсаар би гэрлэх хувьтай төрсөн хүмүүсийн хөлийг нь нийлүүлж уядаг юм. Намайг тэдний хөлийг хамтад нь бооход тэд эхнэр нөхөр болшоодог. Тэд мянган бээрийн алсад байх, нэг нь баян нөгөө нь ядуу, тэдгээр гэр бүлүүд бие биенээ үзэн яддаг байх нь хамаагүй. Тэд товлосон хугацаанд гэрлэсэн байх ёстой.

- Ингээд миний хөлөнд утас уях уу? Нөгөө үзүүрт нь хэн байхыг би харж чадах уу? гэж Уэй Ку асуув.

- Тэр чинь турван настай хүүхэд гэж би чамд хэлсэн шүү дээ. Гэхдээ тэр эндээс холгүй. Одоо үүр цайчихлаа. Нааш ир, би чамд түүнийг харуулья. Тэгэх юм бол чи намайг шаналгахаа болино гэж настай хүн хэлэв.

Уэй Кугийн найз нь ирсэнгүй. Тэр тухайн оролдлого бүтэлгүй болно гэдгийг мэджээ. Настай хүн цүнхээ аваад Уэй Кут дагуулан хүн цугларч буй зах уруу авч явлаа. Тэдэнтэй зэрэгцэн ноорхой хувцастай, нэг нүд нь сохор тариачин эмэгтэй явж байв. Тэр эмэгтэй зарах ногоогоо овоолсон тэрэг түрж явлаа. Тэрээр нуруун дээрээ уранхай даавуунд ороож боосон бөөн юм авч явав. Тэр нь хоёр юм уу, турван настай халтайсан хүүхэд байлаа.

Настай хүн тэр хүүхэд үрүү заагаад,

- Энэ бол чиний сүйт бүсгүй гэж хэлэв. Уэй Кугийн сэтгэл жигшил зэвүүшлээр дүүрэн,

- Хэрвээ би түүнийг албал асуудал төгсгол болно биз гэж тэр хэллээ.

- Энэ охин бол чинээлэг бөгөөд өндөр албан тушаалтай болох хувьтай, энэ талаар чи юу ч хийж чадахгүй гэж хэлээд тэр хүн алга болов.

Уэй Кугэртээ ирлээ. Түүний сэтгэл санаа үймэрч, энэхүү доромжлон гутаасан хос болох хүнээс зутгахаар шийдлээ. Эцэст нь тэрээр хурц хутга авч нэгэн зарцыг дуудаж ирүүлээд,

- Маргааш чи надтай хамт зах уруу явах болно. Тэнд очоод би чамд нэгэн бяцхан охиныг зааж өгнө. Тэр бол муу ёрын сүнс юм. Хэрвээ чи түүнийг энэ хутгаар миний өмнөөс алах юм бол би чамайг арван зоосоор шагнах болно гэв.

Энзийхээ үгэнд итгээд дараагийн одер нь зарц нөгөө хутгыг ханцуулан түүнийг дагаж зах орлоо. Уэй Ку түүнд охиныг зааж өгөөд өөрийнхөө захиалсан аймшигт хэргийн гэрч болохыг хүсэлгүй гэр лүүгээ буцаал явав. Зарц нэг нүйтэй наймаачин эмэгтэй үрүү очоод хутгаа гарган хүүхдийг араас нь дүрэхээр завдав. Гэтэл бяцхан охин эгдүүцэн түүн үрүү том харах үед зарц энгийн л нэг хүүхдээс өөр юу ч биш байсанд итгэж чадсангүй. Тэрээр зориуд түүнийг онилоохо болж хутганаахаа ирээр хөмсөгний нь дээгүүр халт ганцхан удаа зүсээд хүмүүсийн дунд орж алга боллоо. Уэй Куд очоод охиныг алсан гэж хэлж, шагналаа авав. Уэй Ку өөрийнхөө хийсэн гэмт хэрэгт гэмшин

удаан гэгч нь шаналсан боловч эцэст нь тэрээр хэргийг бүхэлд нь өөрийхөө оюун санаанаас авч хаяж чадсан билээ.

Тэрээр олон удаа эхнэр олж авах оролдлого хийсэн боловч бүтэлгүйтсээр байв. Эцсийн эцэст олон жилийн дараа Уэй Кут Хсянг-чоугийн засаг даргын туслах хийж байх үед түүний хувьд асуудал шийдэгдсэн юм. Засаг дарга Уэй Кугийн ажилд маш их сэтгэл өндөр байсан бөгөөд түүнийг гэр бүлгүй гэдгийг нь мэдээл өөрийнхөө охиньг түүнтэй гэрлүүлэхээр шийдэв. Уэй Ку ч гэсэн энэ бүхний эцэст түүний олон жилийн ганцаардал дуусгавар болох нь гэж ихэд баярлав. Засаг даргын охин арван долоон настай хамгаас үзэсгэлэнтэй хөөрхөн бүсгүй байсан юм.

Залуухан сүйт бүсгүйн үс нь сайхан засалттай байсан бөгөөд түүнийгээ уран хийцтэй, үнэт чулуу болон өдөөр чимэглэсэн хаттууруудаар тогтоодог байжээ. Эдгээр хаттууруудын нэг нь түүний чамархай дээр байрладаг бөгөөд, харин тэр хаттуурны толгой яг түүний хөмсөгний чанх дээр байрлаж, духыг нь тагладаг байлаа. Энэ гоёлоо тэрээр хэзээ ч авдаггүй байв. Бүр угаахдаа ч, унтахдаа ч авдаггүй байлаа. Хэсэг хугацааны дараа энэ нь Уэй Кугийн сонирхлыг татаж шалтгааныг нь асуухад хүргэв.

- Энэ гоёл миний духан дээрх муухай сорвийг тагладаг юм. Нэгэн өдөр намайг жаахан байхад асрагч маань зах дээр авч явж байтал нэгэн галзуу хүн намайг хутгалахаар завдсан юм гэж түүний үзэсгэлэнт эхнэр тайлбарлав.

- Харин чи ноорхой хувцсанд боодлтой байсан уу? гэж мэл гайхсан Уэй Ку дуу алдахад түүний эхнэр нь ч бас гайхав.

- Чи үүнийг яаж мэддэг юм бэ? гэж тэр асуув.

- Хүлээж бай. Эхлээд чи надад хэлээтэх. Чамайг хүүхэд байхад чиний аав маш ядуу байсан уу? гэж Уэй Ку хэлэв.

- Хсянг-чоугийн засаг дарга миний жинхэнэ аав биш. Миний эцэг эх ч гэсэн чинийхтэй адил намайг жаахан байхад нас барчихсан. Намайг долоон настай байхад миний авга ах болох одоогийн засаг дарга намайг охиноо болгон үрчилж авсан юм. Тэр хүртэл хөгшин асрагч маань намайг халамжилдаг байсан гэж түүний эхнэр хариулав.

- Чиний асрагчийн нэг нүд нь сохор байсан уу? гэж Уэй Ку асуугаад, тэрээр эхнэртээ настай хүнтэй сарны гэрэлд уулзсан бөгөөд зах дээр түүнийг алахаар завдсан тухайгаа бүгдийг нь ярьж өгөв. Түүний эхнэр энэ тухай сонсоод маш их гайхсан ч түүний хийхээр завдсан гэмт хэргийг нь өршөөсөн бөгөөд тэд урт удаан, аз жаргалтай хамтын амьдралынхаа хугацаанд энэ талаар хэзээ ч дахин дурсаагүй билээ.



Үнэ цэнэтэй гурван боодол

Нэгэн удаа Ниу хэмэх нэртэй ядуу окоутан нийслэл хот орж шалгалт өгөхөөр яваадаа тосгоны дэн буудалд хоногложээ. Өвөл ид дундаа орж байсан учир маш хүйтэн байв. Бүүдгэр тэнгэрээс цас тасралтгүй орсоор байлаа. Ниу дэн буудалд дулаахан, ая тухтай байгаадаа баяртай байв. Тэрээр оройныхоо хоолонд зориулж халуун шөл, банс захиалангаа модны нүүрс түлж байгаа зуухны өмнө өөрийгөө ээн сууж байлаа. Хоолоо хүлээж суухдаа тэрээр аяга халуун будааны дарс ууж дотроо халааж байв. Удалгүй бие нь дулаацаж, царай нь улаа бутарч аятайхан болов.

Өвлийн богино өлөр бараг дуусч байх үед нэгэн хүн хаалга тогшин бүдчин орж ирсэн нь Ниугаас ч ядуу хүн байлаа. Түүний хувцас нь нимгэн ноорхой даавуу байсан богоөд тэр нь энэхүү ширүүн цаг агаараас халхлахааргүй байсан юм. Даарснаас болоод түүний хацар нь цайрч, хөдөлгөөн нь удааширан байв. Уруул нь ярьж чадахааргүй хөшиж байсан боловч мэдээжийн хэрэг зуухны дулаанаас хуваалцахыг хүсн Ниугийн өмнө навтас хийн суув.

Ниу түүнд зай гаргаж өгөв. Тэр хүн улаа бутарсан модны нүүрсний өөдөөс тэмүүлэн гарса сунгасан ба аажмаар бүлээцэж эхлэв.

Буудлын эзэн Ниуд хамгийн сайхан үнэрээр хамар цоргиулсан уур савсуулан оройн хоолыг нь авч ирж өгөөд шинээр ирсэн ноорхой хүнээс түүнд юугаар тусалж чадахыгаа асуув.

- Аяга цай, шалан дээр шөнийг өнгөрөөх зай хэрэгтэй байна гэж тэр хүн хэлэв. Эзэн цай авч ирэхээр гарч одлоо.

Ниу энэхүү ядуу хүнийг оровдлон байлаа. Тэрээр түүнд өөрийнхөө хоолыг албаар өгч, эзнийг буцаж ирэхэд нь дахиад хоол захиалав. Гадны хүн шөл, бансыг тэр даруйд нь ховдоглон идсэн тул Ниу түүнд дахин гурилтай хоол захиалав.

- Надад танд төлөх мөнгө байхгүй гэж тэр хүн хэлэв. Гэвч Ниут эдгээрийг хүлээж авах ёстой гэж шаардсан ба шөл болох хугацаанд таван аяга гурилтай хоол идчихэв. Амрахаар хэвтэх үед Ниу гадны хүнийг унтуулахаар өөрийнхөө орыг өгөх гэсэн боловч тэр хүн түүнийг хүлээж авсангүй. Тэр орны хөлд шалан дээр хэвтээд тэр даруйдаа унтав. Идсэн оройнхoo хоолонд сэтгэл ханаснаа батлах мэт тэрээр шөнөжингөө бух шиг хурхирч байлаа.

Үүр цайж эхлэхэд Ниуг хэн нэгэн хүн мөрнөөс нь зөвлөхөн татаж сэрээв. Энэ бол гадны хүн байсан бөгөөд тэрээр түүнийг хайр гэрэлтсэн нүдээр харж байлаа.

- Хоёулаа гарья. Чамд хэлэх зүйл байна гэж хэлэв.

Ниу гайхширан гутлаа өмсөөд түүний араас даган буудлаас гарав. Хүйтэн саарал гэрэлд гадны хүн түүн үүрүү эргэж хараад ингэж хэллээ.

- Би бол хүн биш, доод өртөнцөөс ирсэн элч байна гэв. Ниугийн аиж байгааг харсан тэрээр:

- Битгий санаа зов, би чиний төлөө ирээгүй. Харин очигдөр орой гаргасан чиний сайхан сэтгэлд маш их талархаж байна. Хэрвээ чи надад бийр, бэх, жижигхэн цаас түр зуур өгөх юм бол би чамд хариуд нь ямар нэгэн зүйл өгье гэв.

Ниу тэдгээр зүйлсийг буудлаас авч ирж өгөхөд гадны хүн түүнийг жаахан холхон бай гэж хэлээд нэгэн модны доор очиж суув. Тэр ханцуйнаасаа жижиг ном гаргаж ирээд хуруугаараа эргүүлж эхлэв. Зогсочийн цаасны өөдөс дээр хэлэн үг хуулж харагдав. Дараа нь түүнийгээ нугалан боолоо. Үүнийгээ тэр гурван удаа давтаад, боодлуудаа нэг, хоёр, гурав гэж дугаарлав. Тэр Ниуд дараах зүйлийг хэлээд тэдгээрийг өгөв. “Амьдралын аар саархан бэрхшээлүүдтэй тулгарахлаа эдгээр боодлуудын талаар битгий бодоорой. Харин томоохон бэрхшээлтэй тулгарч, ирээдүй чинь бүрхэг байвал хүж асаагаад эдгээрийн нэгийг нь онгойлгоорой. Нэг удаа зөвхөн нэгийг нь л нээх бөгөөд нэг, хоёр, гурав гэсэн зөв дарааллаар нээж байгаагаа сайтар нягталж байгаарай. Би одоо явах ёстой. Баяртай. Танд дахин талархлаа илэрхийльс.” Ингээд хэдхэн алхаад алга болчхов.

Ниу өөрийнхөө номтой цүнхэнд нөгөө боодлуудыг далдхан хийв. Үнэн хэрэг дээрээ тэр гадны найзынхаа хэлсэн зүйл тийм ч их итгээгүй бөгөөд энэ хэргийн талаар удалгүй бүр мөсөн мартав. Тэрээр нийслэл үүрүү явж шалгалтаа хүлээж байлаа. Харин нийслэлд хооллож байрлах нь тосгоны дэн будалд байхаас илүү үнэтэй хэцүү хэрэг байлаа. Удалгүй Ниу маш бага мөнгөтэй үлдсэнээ мэдэн, хоолныхоо мөнгийг

хасч бараг л өлсгөлөнгийн байдалд байх болов. Тэр бичээч хийж бага зэрэг мөнгө олж байсан ч энэ нь түүний шалгалтандaa бэлтгэхдээ нь саад болж байсан бөгөөд удалгүй аргаа барав.

Ингээд тэр цунхэндээ хийсэн боодлуудынхаа талаар саналаа. Тэгээд жаахан хүж худалдаж аваад түүнийгээ шатаав. Дараа нь зааж өгснийх нь дагуу нэг гэсэн дугаартай боодлыг гаргаж ирээд задлав. "Яваад Бодь сүмийн үүдний гадна талд суу" гэсэн утгэй цаасны өөдөс байв.

Бодь сүм нь арван бээрийн газарт байлаа. Хүйтэн, нойтон шамартатай муухай өдөр байсан учир Ниуд ядуухан оромжноосоо гарахад хэцүү байлаа. Гэсэн хэдий ч сүүлчийн хэдэн зоосоороо илжиг худалдаж аваад сүмийг зорилоо. Түүн үрүү нэгэн лам хүрч ирэхэд тэр үүдний гадна талд хөлдүү газар дээр арай ядан сууж байлаа.

- Цаг агаар ийм муухай байхад энд суугаад та юу хийж байгаа юм бэ? Хэрэв та удаан суух юм бол хөлдөж үхэх бөгөөд бил нарт төвөг удах болно гэж нөгөө лам түүнийг аашлав.

- Би оюутан хүн. Миний хүсч байгаа юм гэвэл танай сүмийн шатан дээр энэ шөнийг өнгөроох зөвшөөрөл авах гэсэн юм. Би өглөө болохоор яваал өгнө гэж Ниу хэлэв.

- Өө, учлаарай. Би таныг оюутан гэж мэдсэнгүй. Хэрвээ та ороод ирэх юм бол бил таныг нэг шөнийг энд өнгөрүүлэхэд унтах газар, хоол ундаар хангаж чадна гэж нөгөө лам хэлэв.

Лам сүм дэх өөрийнхөө байранд Ниутийн нэрийг асуугаад хоол өгч урт удаан яриа өрнүүлэв. Ингэж байхдаа тэрээр:

- Та Чин-Янгийн нас барсан шүүгч Ниутай ямар нэгэн байдлаар холбоотой биш биз? гэж асуув.

- Тэр чинь миний авга ах гэж Ниу гайхсан байдалтайгаар хариулав.

Нөгөө лам түүнээс шүүгчийн нэр, хувийн үйл хэргийнх нь талаар хэдэн асуулт асуув. Ниу бүгдээрэнд нь хариулахад тэрээр сэтгэл хангалуун байлаа. Дараа нь тэр:

- Чиний авга ах чинь энэ сүмийн өглөгийн эзэн байсан юм. Бидэнд мөнгө өгөхөөс гадна саяхан болсон бэрхшээлүүдийн үеэр 3000 зоос хадгалуулахаар надад орхисон юм. Түүнийг нас бараахад би тэр мөнгийг яах вэ гэдгийт мэдэхгүй байлаа. Харин та түүнийг авч явж болох юм гэж тайлбарлав.

Одоо мэдээжийн хэрэг Ниу баян эр боллоо. Нийслэлд сайхан сууц худалдаж авч, зарц, морь, тэрэг бүх юмтай сайхан амьдрах болов. Одоо тэр эд зүйлээр хангалуун байсан ч шүүгчийн алба хаших том хүсэлтэй

байв. Үүнийг зөвхөн шалгалт өгч байж л хийж чадах байлаа. Айх нийслэл үрүү зорьж ирсэн шалгалтандaa унасан ба гурван жилийн дараа дахиад л шалгалтууддаа унасан байна. Гурав дахь удаагаа шалгалтандaa бэлтгэж байсан боловч амжилт гаргана гэсэн итгэл найдварт тун бага байлаа. Тэр амьдралынхаа мөрөөдөлд хэзээ ч хүрч чадахгүй нь хэмээн бодож тун их гуниглаж байлаа.

Дараа нь нэг өдөр өөрийхөө судаллаг номуудыг янзалж байгаад шалан дээр үнгэгдсэн хоёр цаасан боодол унахыг харсан ба доод өртөнцөөс ирсэн өлсөж үхэхээ шахсан элчийн талаар гэнэт санав. Хоёр гэсэн дугаартай боодлыг аваад хүсэл мөрөөдлөө билүүлэхэд нь тусалж чадах болов уу хэмээн гайхширав. Нөгөө сүнсний зааврыг санан дахин хүж асааж хоёр дахь боодлыг задлав.

Тэр “Яваад баруун зах дээрх Чангийн зоогийн газарт орж суу” гэсэн бичигтэй цаасны өөдсийг гаргаж ирэв.

Ниу Чангийн зоогийн газрыг амархан олов. Тэр шатны дээд талд сууж цай захиалав. Түүний ард талд нэгэн өрөөг тусгаарласан хөшиг байлаа. Тэр өрөөнд хоёр хүн ярилцаж байв. Ниутэдний яриаг сонсохоос зайлсхийсэнгүй.

- Би таны өгсөн сэдвээр жижигхэн шүлэг зохиож өөрийгөө зугацуулж байлаа. Үүнийг сонс доо... гэж нэгдүгээр хүн хэлээд өөрийнхөө зохиолыг бахархангуйгаар дуржигнуулж эхлэв.

- Тийм ч муугүй болжээ гэж түүнийг уншиж дуусахад нөгөө хүн хэлэв.

- Гэхдээ би чамайг үүний чинь төлөө шалгалтаяа өгсөнд тооцохгүй л юм шиг байна. Чи хэд хэдэн буруу мөрүүдийг ашиглажээ... гээд нэгдүгээр хүний шүлгэндээ гаргасан алдаануудыг тоочиж эхлэв.

Нөгөө яруу найрагч энэ шүүмжлэлд бага зэрэг ундуушан өөрийнхийгөө буцааж авахаар шийдлээ.

- Би зөвхөн миний өгсөн зохион бичлэгийн сэдвүүд нь маш хялбархан нотлогдох болно гэдгээс л айж байна. Мэдээж хэрэг бүтгээрээ ишлэлүүд бөгөөд бүр хамгийн залхуу өрсөлдөгч ч хэний бүтээлзээс авсан байна вэ гэдгийг мэдэх болно. Жишээ болгоод эхнийхийг нь аваад үз дээ... Эхний зохион бичлэгийн сэдвийг гаргах өгүүлбэрийг цээжээр уншилаа. Дараа нь тэр хоёр дахь хүнээр ишлэлийг тодорхойлуулахын тулд завсарлав. Харамсалтай нь тэр хүн тодорхойлж чадсангүй. Тэр ханиалгаж, түгччиж, мөн сэдвийг өөрчлөхийг хичээсэн боловч нэгдүгээр хүн хойшлуулсангүй. Тэрээр өгүүлбэрүүдийг ар араас нь уншиж байсан ч түүний нохөр алийг нь ч таньж чадсангүй. Эцэст

нь хоёулаа хөхөрч унав. “Өөрсдийнхөө зохиосон шалгалтанд бил суух хэрэггүй юм байна. Бидний хэн нь ч түүнийг давахгүй юм байна” гэж тэд бие үрүүгээ хашгирав.

Ниу хязгааргүй баяртай байлаа. Удалгүй тэр дараагийн албан ёсны шалгалтан дээр ирж болох асуултуудын талаар нарийн мэдээллүүдийг сэм сонсож авав. Тэр онцгой сайн ой санамжтай байсан бөгөөд гэртээ хариад сонссон уг бүрээ хуулж авлаа. Ингээд тэр шалгалтандaa бэлтгээд, цаг нь ирэхэд зааланд орохоосоо өмнө бүх хариултыг өөрийнхөө толгойд боловсруулсан байлаа. Ингээд шалгалтаа онцгой сайн өгч, өндөр албан тушаалд дэвшиж, үнэхээр их баярласан билээ.

Албан хаагчийнхаа хувьд Ниу нэр хүнд сайтай байлаа. Тусlamж хэрэгтэй буюу уй гашуу, зовлонд автсан хэн бүхэнд түүний сайхан сэтгэл домог болж байлаа. Ажлаа хийж хaa ч явж байсан нөгөө гурав дахь үнэ цэнэтэй боодлыг байнга биедээ авч явдаг байлаа. Харин түүний зовлон үүгээр дууссан мэт санагдаж, түүнийг нээх хэрэг хэзээ ч гарахгүй байх хэмээн бодож байлаа.

Гэвч тийм ч их нас дээр гараагүй боловч тэр овдож эхлэв. Эмч нар ар араасаа цувран мөнгийг нь барж эм бичиж өгсөөр, сүмд түүний төлөө залбирал үйлдэж байсан боловч ямар ч нелөөгүй мэт санагдаж байв. Эцсийн эцэст Ниу нөгөө гурав дахь боодлыг нээх нь түүний цорын ганц найдлага юм байна гэж шийдэв. Тэр хүж асааж гурав дахь боодлыг задлан “Гэрээслэлээ бич” гэсэн үүгэй цаасны өөдөс гаргаж ирэв.

Ниу түүний цаг нь болжээ гэдгийг ухаарав. Ингээд яаралгүйгээр, гомдол мэдүүлэлгүйгээр ажил хэргээ цэгцэлж, гэр булийнхэн болон найз нөхөдтэйгөө салах ёс хийгээд тайвнаар насан эцэслэсэн ба бугд түүнийг гашуудан үдсэн юм.



Загасны нухаши болох шахсан хүн

Манай эриний 759 дүгээр оны намрын нэг өлөр шүүгчдийн танхимын ажилтнууд үдийнхээ хоолыг хүлээнгээ амарч байлаа. Хоёр хүн гаднах талбай дээр шатар тоглон сууж байв. Тэд үүдэнд үйлчлэгч хүрч ирж байхыг харлаа.

“Сайн байна, Чанг Пи” гэж хоёр хүний нэг нь үйлчлэгчид хэлээд нөгөө хүний үдийнхээ хоолонд зориулж худалдаж авсан загасны талаар зөвшөөрч толгойгоо дохив. Тэр нь Чанг Пигийн заламайгаар нь утсаар оссорлон авч яваа гайхамшигтай сайхан булуу цагаан загас байсан юм. Нөгөө шатар тоглогч нөхөр лүүгээ эргэж “Түүний хэрчим бүр нь нэг аравнаа тав эсвэл хоёр кг орчим байх болно!” гэж хэлэв.

Нөгөөх нь инээмсэглээд толгой дохив. Урдаас нь ирж буй зарцыг хараад ихэд тайхсан янзтай хэлэв. “Энэ загас веерт нь ю тохиохыг мэдэж байгаа юм шиг харагдаж байна. Нүднээс нь нулимыс урсаж, мөн ам нь залбирах мэт хөдөлж байх юм!”

Тэр залбирч буй загасыг харуулахаар гаднаас хүмүүсийг дуудлаа. Нэг цэргэг тавагнаас тоор жимс авч идэж байхад оөр хоёр нь шоо хаян тоглож суув. Ингээд бүгд тэдэнтэй ярилцах мэт харагдаж загас хамгийн хачирхалтай зүйл мөн гэдэгт бүгд санал нийлэв. Үйлчлэгч Чанг Пи тэдний утгагүй зүйлийг сонсон инээмсэглэсээр худалдан авсан үнэт зүйлээ тогоочид хүргэхээр гал тогоо уруу орлоо.

Энэ удаад үүдний өреөний хажуутгийн жижигхэн нээлттэй өреөнөөс гарсан урт гэгчийн санаа алдаа дуу дахиад л ажилтнуудын анхаарлыг сарниулав. Энэ өреөнд шүүгчийн туслах Хсюх Уэй хэвтэж байлаа. Хэдэн долоо хоногийн өмнө тэр гэнэт халуурч долоо хоногийн турш ухаангүй байв. Эцэст нь орон дээрээ цонхиийж сульдан хэвтэж байлаа. Түүнийг эргэхээр очсон хүмүүс түүнийг үхэх нь болжээ хэмээн бодож

байв. Тэнд жинхэнэ амыдрал байгаагүй бөгөөд зүрх нь бага зэрэг бүлээхэн байсан учир түүнийг оршуулах асуудал байсангүй. Тэрээр тэнд хориод хоногийн турш хэвтэж байгаа билээ. Харин одоо түүнээс энэхүү санаа алдах дуу гарсан юм. Хамтран ажиллагсад нь тэр өрөө үрүү гүйлдэв. Түүнийг орон дээр эв эрүүл сууж байхыг харсан тэдний нүднээс баярын нулимын хацрыг нь даган урсаж байв.

- Би та нараас хэдий хугацаагаар хол байв? гэж өвчтэй байсан хүн асуулаа.

- Хорь гаруй хоног гэсэн хариу сонсогдов.

- Та нар загасны нухаш идэж байсан уу? гэсэн дараагийн асуулт нь тэдний цочирдуулав.

- Бид дөнгөж саяхан жаахныг идэх гэж байлаа гэж тэд хариулав.

- Гэвч чи яж мэдэв?

- Ганцхан минут хүлэээ. Үйлчлэгч Чанг Пиг тэр загасыг худалдаж ав гэж явуулсан уу? гэхэд,

- Тэгсэн гэж тэд хариулаад урыл байгаагүйгээрээ гайхширав.

Хсюх Уэй үйлчлэгч үрүү эргэж,

- Чи том булуу цагаан барьсан загасчин ЧАО КАН уруу очиход тэр түүнийг зэгсэнд нуугаад жижиг булуу цагаан авахыг санал болгосон. Харин чи нөгөө том загасыг авч ирсэн. Чамайг энэ байшинд бушаж ирэхэд энэ хоёр хүн шатар тоглож, харин энэ хоёр хүн шоо тоглож байсан. Тэр залуу тоор идэж, чи тэдэнд хэрхэн ЧАО КАН том булуу загасыг нуухыг оролдсоныг ярьж өгөхөд тэд түүнийг зодох хэрэгтэй гэж тушаасан билээ. Дараа нь тэр булуу загасыг чи тогоочид аваачиж өгөхөд тэр баярлан түүнийг алсан. Энэ бүхэн үнэн, тийм биз дээ?

- Яг юу тохиолдсон хийгээд, Хсюх Уэйний дүрсэлснийг бүгдээрээ зөвшөөрч байлаа.

- Харин энэ бүгдийг чи яж мэдсэн юм бэ? гэж тэд түүнээс асуув.

- Тэр булуу цагаан чинь би байсан юм гэж Хсюх Уэй хэлэв.

Ингээд тэрээр өөрийнхөө талаар тэдэнд ярьж өгөхөөр болов.

- Эхлээд би өвдсөн. Дараа нь хүчтэй халуурсан. Халуунаас ангижрахын тулд би ямар нэгэн юм хийх хэрэгтэй гэж бодоод таягаа аваад гадуур явахаар гарсан юм.

Өвдсөнөөсөө хойш тэрээр орноосоо огтхон ч босоогүй билээ. Түүнийг сонч байсан хүмүүсийн нүүрнээс гайхширал ажигласан тэрээр үргэлжлүүлэн ярилаа.

Энэ зүүд байгаагүй л юм шиг санагдаж байна. Одоо ч зүүд байгаагүй гэж бодож байна. Би яг л торноосоо гарсан шувуу шиг баярлан хотоос

гарч толгодыг зорилоо. Толгодоор алхсанаасаа болоод ядрахдаа би түүнээс бууж голын эргийг дагаж явав. Ус нь цэнгэг байсан ба нарны гэрэлд гялалzan байлаа. Эцэст нь би гол өргөссөнөөс үүссэн цүнхээлд хүрч ирлээ. Энд ус нь дөлгөөн бөгөөд гүнзгий, сэруүхэн бөгөөд сэтгэл татам байв. Би биеz барьж чадсангүй, эцэст нь хувисаа тайлаад шумбан орлоо. Хэдийвээр би сайн сэлдэг байсан ч, хүүхэд байснаасаа хойш сэлж байгаагүй билээ. Гэвч усанд шумбан доошлох тусам би үүнийг л хүлээж байсан мэт санагдаж байлаа. Би маш хялбархан сэлж чадах загас биш байсандaa харамсаж эхэллээ. “Би зөвхөн загас болчихдог ч болоосой!” гэж өөртөө хэлэв. Хажуугаар сэлж байсан загас надад “Энэ чинь чиний үнэхээр хүсч байгаа зүйл чинь юм бол үүнийг хялбархан гүйцэлдүүлж болно” гэж тэр даруй хэлэв. Тэр загас цааш сэлэн одсон бөгөөд удалгүй нэгэн сонин амьтан гарч ирэв. Тэр загасан толгойтой боловч хүн биетэй байлаа. Тэр хэдэн тохой өндөр байсан бөгөөд аварга том тожмой луу унасан байлаа. Хэдэн арван загас түүний араас даган сэлж, тэр амьтан надад голын эзний тунхаглалын талаар хэлж өгсөн юм. Тэрээр газрын болоод усны амьтал ер нь өөр өөр туулах замтай гэж хэлсэн. Гэвч би газраас залхаад усанд эрх чөлөө хайхыг хүссэнээс хойш миний хүсэл биелэгдэж, би алтан булуу цагаан хэлбэртэй болсон. Харин би давалгааг цалгиулж, завийг хөмөрч хохирол учруулах, мөн өгөөш залгиж өөрийнхөө аюулгүй байдалд эрсдэл учруулах зэрэг аль алинаас нь болгоомжлох ёстой байв. Эдгээрийг хийснээр би өөрийнхөө төрөлд шившиг тарих болно.

Би өөрийгөө үзэсгэлэнтэй алтан булуу загасын хэлбэртэй байна гэдгээ мэдэв. Би усыг хялбархан бөгөөд уян налархайгаар хурдан туулсан юм. Би давалгаан дотор болон гадна талд тоглож, эсвэл гол, нуураар явах дуртай байсан учраас тэнүүчлэн, гүнд нь шумбан орж байлаа. Зөвхөн би л гэр шигээ онцгой нэгэн цүнхээлтэй болсоос хойш орой болгон буцаж ирэх ёстой байв.

Гэнэт нэгэн өдөр би өлсөж эхлэв. Идэх юм юу ч олж чадсангүй. Би урсгал даган нэгэн завийг дагаж эхэллээ. Ингээд усанд дотор өгөөшөө тавин байгаа загасчин ЧАО Кант харсан юм. Би түүний үнэрийг авав. Тэр маш амттай байлаа. Хэдийвээр би өгөөшийг авч болохгүй гэдгийг тодорхой санаж байсан ч яагаад ч юм түүнийг үнэрлэж байгаагаа мэдлээ. Ингээд би өөртөө “Би чинь загас биш хүн шүү дээ, би зөвхөн одоо л булуу цагааны хэлбэртэй байгаа гэж хэллээ. Өгөөшний дунд дэгээ нуугдаж байгаа гэдгийг би сайтар мэдэж байсан болохоор ЧАО Канын өгөөшийг залгиж болохгүйгээ лавтайяа ойлгож байв. Ингээд

би цааш сэлэв. Гэвч удалгүй хэзээ ч байгаагүйгээрээ өлсөж байлаа. Би оортөө учирлаж эхлэв. “Хараач ийшээ! Чи бол албан хаагч, чи зөвхөн загас болж л тоглож байна. Чи дэгээг үмхчихэж болох юм гэж санаж байна. Чao Кан намайг алахгүй!” гэж хэлсэн боловч,

“Чao Кан намайг энэ ордонд буцаагаад аваад ирэх юм чинь гэж итгээд би тэр өгөөш үрүү дахин сэлж ирээд түүнийг, дэгээг бүтгийг залгичихсан. Үнэн хэрэг дээрээ маш ухаантай загасчин Чao Кан намайг эрэг үрүү чирхэд би түүн үрүү хашхирсан боловч тэр намайг сонсоогүй юм шиг байсан. Миний заламайгаар, хацарнаас, утсаар осорслож ногөө узүүрийг нь хэсэг зэгнээс уясан юм.

Дараа нь үйлчлэгч Чанг Пи ирээд,

- Ажилтнууд том загас идэхийг хүсч байна гэж хэлсэн.

- Би ямар ч том загас бариагүй гэж Чao Кан худлаа хэлсэн.

- Чамд тав орчим кг буюу түүн шиг жинтэй жижиг загас өгье гэхэд

- Надад томыг өгөх ёстой байсан шуу дээ, жижгийг яаж хэрэглэх юм бэ? гэж Чанг Пи хэлээд зэгс үрүү шагайж намайг олж хараад өргөж авсан.

- Би шүүгчийн туслах байна гэж Чанг Пид би хэлэв. Би ердөө л хялбархан сэлэхийн тулд тэр үед булуу цагаан болж хувираад байсан юм. Би дарга чинь байхад чи яагаад надад хундэтгэлтэй хандахгүй байгаа юм бэ? гэж би асуув.

Харин Чанг Пи очүүхэн ч ойшиосонгүй. Тэр намайг энд буцааж авч ирэхээр болсонд би хашгирч, уурласан боловч тэр нал уруу огтхон ч хараагүй. Тэдний хашаанд орж ирэхэд би та хоёрыг шатар тоглоод сууж байхыг чинь харсан. Би хоолойныхоо чадлаар хашгирсан боловч надад хариу хэлээгүй. Зөвхөн та хоёрын нэг нь ногөө үрүүгээ хараад “Тэр ногрийн хэрчим бүр нь нэг аравны тав эсвэл хоёр кг орчим байх болно!” гэж хэлсэн. Дараа нь би шоогоор тоглож байсан хоёрыг болон бас тоор идэж байсан өөр нэгнийг харсан. Та нар бүгдээрээ л миний хэмжээг хараад баярлацааж байсан. Чанг Пи та нарт Чao Кан хэрхэн намайг нууж, оронд нь жижиг загас өгөхийг оролдсон талаар ярж өгсөн ба та нар түүнийг зод гэж тушаасан билээ.

Цохөрсөндоө би та нар луу хашгирч, “Нөхөд өө, би та нартай цуг ажилладаг хүн байна. Та нарт яаж намайг алах сэтгэл төрөв” гэж хэлээд цурхиран уйлсан боловч энэ бүхэн тусыг олоогүй. Та нар намайг тогоочид өгөхэд тэр намайг вандан дээрээ тавиад хутгаа авсан. Хэдийгээр намайг өршөөхийг би хичээгүйлэн гүйсан боловч хутгадоош бууж миний толгой өнхрен унасан. Би ганцхан дэвхэрч хөрвөөгөөд л

өөрийнхөө биед эргэн орлоо. Ингээд би энд байна гэж ярилаа.

Загасны ам хэрхэн хөдөлж байсныг тэд анзаарснаа, ЧАО Кан түүнийг хэзээ зөөсөн, Чанг Пи түүнийг хэрхэн өргөж авч ирсэн, ажилтнууд шатар болоод шоо тоглож байсан, тогооч гал тогоондоо байсныг бүгдээрээ санаж байв. Тэдний хэн нь ч дуу авиа сонсоогүй байх юм.

Харин тэд нарын хэн нь ч үлдсэн амьдралдаа дахин загасны нухшинд гар хүрээгүй билээ.



Сүнснүүдийн жихүүдэс

Сүнснүүд цагийг амьд хүмүүсээс илүү хялбархан олон аргаар өнгөрүүлдэг. Тэд нарыг хоол хүнсээр хангахад тийм ч их хүчин чармайлт хэрэгтүй. Тэдэнд аялал олон төвөг авчирдагтүй бөгөөд байр суурин нь асуудал биш учир тэд тэрхэн зуур зохицдог. Аливаа гүн харанхуй, эл хуль, бага зэрэг агааргүй жиндүү суурин буюу оромж эсвэл булшны довцог ч тэдэнд хангалттай байдал.

Тэд амьд хүмүүсийн ертөнцөөр гүйж, завгүй байхдаа өөрсдийнхөө газарт байраа олон суурышдаг. Зуу зуун жилийн өмнө нэгэн хүн сүнснүүдийн оронд зочилж ирснийхээ дараа энэхүү туухийг ярьж өгсөн юм. Тэрээр далайн наймаачин байсан бөгөөд ял өөр шигээ хүмүүсийн алилаар хатуу зүрхтэй байсан ба далайгаар аялсан олон газруудынхаа талаар маш их сонирхлог байжээ.

Түүний бүхий л аяллуудаас хамгаас сонин хачин нь байсан энэхүү далайн аяллын туршид түүний тэвшин завь бас гэр нь байдаг Шантунг боомтоос гурван долоо хоног холдажээ. Хэдэн өдрийн турш том дарвуулуд нь тасралтгүй үзээх далайн сэвшиээ салхины өмнө чахран гяхтнаж, хүчлэн байв. Гэтэл гэнэт далайн хүй салхи дэгдэв. Дээд тэнгэрийг алга болгосон мэт оволзсон их далай, хөөрөн буй усны түрлэгийн ертөнцөд завь замдаа худалдаачин болоод түүний zaluurчин хоёрын аль аль нь хэр хол яваад байгаагаа мэдэх хүртэл эргэлдэн шидэгдэж байв. Шуургыг намдахад тэд зөвхөн зүт чигээ будэг бадаг тааварлаж хурдан эрэг дээр очиосой хэмээн найдлаа.

Хэдэн өдрийн дараа аятайхан меч ирлээ. Ажиглалтын байрнаас “Газар!” гэж хашгирч байгаа сонсогдсан. Худалдаачин хараагаа тогтоогоод тэнгэрийн хаяны цэнхэр зурvasыг ажиглав. Онгоцыг ойртож ирэхэд илүү тодорхой болох байлаа. Алсын бараа горьдлого төрүүлж байв. Тэнд ой мод байх ёстой аятайхан ногоон толгол,

бараавтар хөндий байлаа. Тэд нэгэн өргөн голын адаг уруу чиглэн явж байгаа нь одоо тодорхой боллоо. Эцэст нь толгодын хормойн эсрэг талд хотын хэрэмний хурэн дурс байхыг олж хараад худалдаачны зурх догдлон байлаа.

Багийн гишүүн болгон “Энэ газрыг юу гэдэг юм бол?” гэж бие биенээсээ асуув. Хэн нь ч энэ газрыг урьд нь хараагүй байлаа. Харин цагаан үст хөгшин далайчин:

- Тавин жил далайгаар аялахдаа энд нэг ч ирж байгаагүй юм байна. Бид бухний сонсож мэдэж байсан ад зэтгэрүүдийн орон гэдэг л энэ байх ёстой гэж би бодож байна хэмээн хэлэв.

Багийн гишүүд энэ үгийг сонсоод жихүүцэж, хүн болгон худалдаачнаас булааж явахыг гүйв. Харин худалдаачин инээд алдан,

- Энэ чинь настай хөгшин хүний л яриа байна шүү дээ! Тэдгээр толгод, хотын хана буюу толгодын хажууд байгаа сүүмэлзсэн хонинууд ч бас надад хангальтай гээд тэр газардах тушаал өглөө.

Ойролцоо голын уснаас завийг услахыг нэг хэсэгт нь даалгаад худалдаачин дөрвөн хүнийг дагуулан хотын зүт явлаа. Тэд эрэг дээрээс буурцааг болоод тутартын талбай дундуур явсан жимийг олов. Эдгээр талбайнууд Хятадад байдаг шиг тэгшхэн, ногоон байлаа. Удалгүй тэд замын ойролцоо гаапуудаж байгаа нэгэн настай хүн дээр ирэв. Худалдаачин түүнтэй зэлдгээр мэндэлсэн боловч тэр хүн тоосонгүй. Түүнийг дулий байх гэж бодоод эргэн тойронд нь тахианууд газар тоншин буй бөөн овоохойнууд уруу цааш хөдлөв. Овоохойнуудын нэгнээс мөрөн дээрээ хүрэв тавьсан нэгэн zaluu гарч ирээд тэд нар луу ирж яваа харагдav. Тэд түүнд зам тавьж өгөхөд тэдэн үрүү хялайж ч харалгүйгээр шулухан яваад өгөв. “Тэр лав сохор байж таараа” гэж нэг нь хэлэв. “Гэхдээ сохор гэхэд ямар сайн явж байна!”

Харин тэд цаашаа явж, эрэгтэй эмэгтэй хүмүүс, хүүхдүүдтэй тааралдсан боловч ямар ч хариу байсангүй. Тэд эдгээр хүмүүсийг дулий, эсвэл сохор юм байна гэж ойлгож байв. Тэд зүгээр л гадны хүмүүсийг хүлээж авдаггүй юм болов уу гэж бие биендээ ярж байлаа. Настай далайчны тааварласан нь үнэн байх нь. Тэд сүнснүүдийн оронд ирсэн байлаа.

Одоо тэдний өмнө хотын хана сүндэрлэн, тэдний зам хаалга уруу нь чиглэж байлаа. Хятадад байдаг шиг тэнд мөн настай хаалгач байв. Одоо тэд мэддэг болсон тул явна гэсэн газраараа ямар ч саадгүй явж байлаа. Хаалгачийг өнгөрөн таван гадны хүн хот уруу алхан оров. Энэ нь өргөн гудамжтай, байшин барилга нь цэгтэй, нам гүмхэн талбайтай,

хүн их цугларсан захтай аятайхан газар байлаа. Худалдаачин түүний дагуулууд Хятадын ямар нэгэн хотод явж байгаа мэт бодож байж болох юм. Гэвч үнэн хэрэг дээрээ тэднийг өчүүхэн ч гэсэн анхаарахгүй байв. Хүн ихтэй гудамжинд мөргөлдөж, түлхэлцэх вий гэж хулээж байсан тэд хүн хэлбэртэй манан будан дундуур өнгөрөн явж байгаагаа мэдэв.

Хотын төвийн задгай газар луу орж явсан тэд нарын өмнө нэгэн сүр жавхлантай барилга байхыг харлаа. Түүний нүүрэн талд нь гялалзсан шар өнгийн вааран өргөн дээврийг нь тулсан гүн улаан өнгөтэй сийлбэр баганатай байв. Энэ нь тус газрын захирагчийн ордон байж болохоор байв. Юу ч айлгаж сүрдүүлсэнгүй. Худалдаачин нөхдийнхөө хамтаар тансаг үүдэн дээр байгаа хамгаалагч нарыг өнгөрөн, жиргэж буй тортой шувуу бүхий засмал замаар явж, усан оргилуур болон нүд булаам цэцэгс бүхий гантиг чулуун талбайг гатлан орлоо.

Нэгэн том сүрлэг танхимаас дуу хөгжим, инээд хөөр сонсогдож, дотор нь найр наадам ид дундаа явж байв. Танхимын сайдууд тансаг аяга таваг, дарсны гоё сав суулга тавьсан урт ширээний ард сууцгаасан байв. Харин танхимын голд хэсэг бүжигчин охид хоргой ханцуйгаа найгуулан байлаа. Хамгийн дээд талын ширээний төвийн суудал сүр жавхлантайяа хувцасласан, бүр хөнгөн бөгөөд инээд хөөр болсон энэ мөчид ч сүр жавхлантай царайтай нэгэн хүн сууж байлаа. Яг л ойд туссан нарны гэрэл сүүдрийг нэвтрэн өнгөрч байгаа мэт худалдаачин бүжигчдийн хоорондуур биш, тэднийг нэвт явж хаанд хэдхэн алхмын зйтгэлийг зогсов. Хятадад луугийн хаан ширээний өмнө мөргөж байсан шиг шалан дээр сунаж мөргөн босоод цог жавхлант хаанд хамгийн хүндэтгэлтэйгээр мэдчиллээ. Гэвч цог жавхлант хаан түүний албатуудын адилаар худалдаачны байгааг мэдсэн шинжгүй байлаа. Хаан болоод түүний бүх албатууд бараг л зүгээр нэг сайтар зохион байгуулсан хүүхэлдэйн үзүүлбэр мэт байв. Тэд бүр идэж, хөхрөлдөж, дуулж, бүжиглэх гэх мэт язн бүрийн үйлийг хийж байсан юм. Худалдаачин өөрийнхөө сониуч занг тогтоон барьж чадахгүй байв. Хааны гэр бүлийг бүр ойроос ажиглах энэхүү хамгийн хачирхалтай завшааныг албаар бий болгосон мэт санагдаж байлаа. Тэрээр шууд ширээ үрүү явж, дээгүүр нь гарч цог жавхлант хааны чанх нүүр лүү нь ширтэн харав. Гэвч тэрээр хэдхэн хормын турш л цоо ширтэж чадав. Хаан гэнэт сандал дээрээ хажуулдан нуран унаж түүний барьж байсан дарсны хундага шалан дээр хагарав.

Агшин зуур бүх юм замбараагүй байдалд орж дагалдагсад хааныг суудлаас нь болгоомжтой босгон хажуугийн өрөөнд оруулав. Танхимын

эмчийг түүн үрүү илгээхэд ч тэрээр үйл явдлын газар луу яаран явж хааныг үзээд бүхний санааг амраан,

- Ноцтой хэрэг биш байна. Цог жавхлант хаан зүгээр л ухаан алдсан байна. Харин би шалтгааныг нь олсонгүй. Энд ямар нэгэн учир битүүлэг зүйл байх шиг байна. Танхимын шидтэнийг дууд! гэж хэлэв.

Тэрхэн зуур өвчтоний ороонд нэгэн хундтэй өвгөн орж ирэхэд түүний өмссөн хар өнгийн номрөг нь ер бусын бэлгэдэл бүхий хаттамалтай байв. Эхлээд хааныг үзээд дараа нь хааныхаа төлөө санаа зовон чимээгүйхэн ажиглан зогсож байсан сайдууд уруу анхаарлаа хандуулж,

- Цог жавхлант хаан удахгүй эдгэрэх болно. Түүний өвчний шалтгаан нь нэн даруй арилах болно. Цог жавхлант хаан амьд хүний амьсгаанд автжээ гэлээ.

- Амьд хүний амьсгаа! гэж сайдууд гайхангуй давтлаа.

- Гэвч хаана? Бидний энэ оронд яаж байж болох вэ?

- Амьд хүн бидний дунд байна. Тэр манай оронд тохиолдоор хүрч иржээ. Энэ нь тоглоом ч биш дээ. Харин тэр цог жавхлант хаанд бүр хэтэрхий ойртжээ. Иймээс түүний ухаан балартсан байна. Түүнтэй сайхан хандаж, манай орныг орхихыг хүсье гэж ил шидтэн хэлэв.

Хэн ч танхимын шидтэний үгийг асууж лавласангүй. Тэр даруйдаа найр наадам хамгийн чадвартай хөгжимчид, бүжигчин охидыг тоглуулсан тусдаа танхимд боллоо. Хааны ордны зохион байгуулагч цангинаасан дуугаар хоосон агаарт хандаж уг хэлэв. “Эрхэм зочин амьд хүн ээ!” гэж тэрээр хэлээд, “Сүнсний орныхон бид та бүхний зочилж байгаа явдалд талархлаа илэрхийлье. Та нарт зориулан бэлтгэсэн бидний найр наадамд оролцно уу хэмээн урьж байна. Цадталаа идэж усны чинь дараа танхимын гадаа та нарыг морь тэрэг хүлээж байх болно. Тэд та нарыг өөрийн чинь завь уруу найдвартай хүргэж өгөх болно” гэв.

Худалдаачин ба түүний дагуулууд цаашид түгшүүр төрүүлэхийг хүссэнгүй. Цадталаа илэж ууж, энэ зуур танхимын шидтэнгүүд тэд нарын буцах аюулгүй байдлын талаар бурхнаас гүйж залбирч байсан бол сайдууд хоол хүнс, дарс багассаар байгааг харан гайхсаар байв. Гэсэн хэдий ч тэд найрлагчдыг ойлгохгүй байв. Идэж ууж дууссаныхаа дараа амласан ёсоор танхимын гадаа тэрэг байхыг аялагчид олж харав. Тэднийг аятайхан зөөлхөн аюулгүй авч явж, эрэг үрүү буцааж авч ирэв. Өөрийнхөө тэрэгний судал дээрээс худалдаачин гялалзсан алтан гулдмайг дээр дээрээс нь давхарласан лакалсан хайрцаг байхыг олж

харсан ба тэр хайрцгийг тэвшин завин дээрээ буцааж авч ирсэн болно. Харин эргээс холдоодо тэр хайрцааг гэнэт хөнгөроод байгааг мэдэрчээ. Түүнийг дахин онгойлготол алт байна гэж бодож байсан гулдмайнуд нь юу ч биш, харин шар өнгийн цаас буюу оршуулган дээр шатаадаг байсан цаасан мөнгө байлаа. Сүүлчийн удаа нүдээ том болгон хараадад тэнд морь ч, хамгаалалтын бүлэг ч, хүмүүс байгаа ямар нэгэн шинж тэмдэг олж харсангүй. Зөвхөн уул нурууд, тал хөндий, далайд цутгаж буй голууд л байлаа.

Эргийн хүчтэй салхи үзээг байлаа. Тэвшин завь дарвуулаа дэлгэж сааталгүйгээр Шантунг боомтод буцаж ирлээ. Худалдаачин өөрийн түүхээ хaa сайгүй ярьж өгсөн билээ. Харин тэр өдрөөс хойш өнөөг хүртэл хэн ч тэнгэрийн хаяан дахь сүнсний орны уул толгодыг дахин хараагүй билээ.

Гэхдээ энэ нь амыг хүмүүсийн нутагт сүнсийг тэр цагаас хойш үзээгүй хэмээн хэлэх гэсэн хэрэг биш билээ. Харин тэдэнтэй янз бүрийн аргаар тулгарч байсан юм. Тэдний зарим нь харагдаж асуудал болдог байсан байна. Жишээлбэл өглөө эрт зах уруу алхаж явахдаа сүнстэй тааралдсан Сунг Тинг-по гэдэг хүн байсан юм. Сунг тэрнээс:

- Чи хэн билээ? гэж асуухад,
- Би бол сүns гэж тэр хариулжээ.

Сунг Тинг-по нь эрэлхэг зоригтой залуу эр байсан бөгөөд сүнс түүнийг

- Хэн бэ? хэмээн асуухад тэрээр:
- Би ч гэсэн сүns хэмээн хариулжээ.
- Чи хаашаа явж байгаа юм бэ? гэж сүns асуув.
- Зах уруу гэж Сунг хариулав.

- Тэгэхээр би ч гэсэн гэж сүns хэлээд хамтдаа нэг бээр газар цааш алхлаа. Дараа нь өөрсдийнхөө явж байгаагаа удаан байна гэж сүns гомдоллож эхэлсэн ба ээлжлэн бие биенийгээ үүрч явахыг санал болгов. Эхлээд Сунг Тинг-по үүрүүлэхээр болов. Харин сүns түүнийг хэдхэн алхам үүрээд явахдаа,

- Чи чинь ямар хүнд юм бэ! Чи сүns гэхэд маш хүнд байна гэхэд,
- За яахав чи харна аа гэж Сунг тайлбарлав.
- Сүns байлгүйгээр би маш их удсан ба миний бие хөнгөрөх цаг хугацаа байсангүй.

Энэ нь сүns сэтгэл хангалиун байх юм шиг санагдав. Удалгүй тэр

үүрүүлэхээр болсон ба сүнс ердоө ч жин дарахгүй байсныг олж мэдэв.

Тэд үүрч, үүрүүлсээр л явлаа. Яваандаа Сунг Тинг-по:

- Би бүр шинэхэн сүнс учир их зүйл мэдэхгүй. Сүнс бидний хамгийн их айdag зүйл нь юу байх вэ?

- Сүнсний айdag ганцхан л зүйл байдаг. Тэр бол амьд хүн хэн нэгнийг нулимах явдал юм гэсэн хариу сонсов. Тэд горхи дээр ирээд тус тусдаа туулж гарахаар болов. Сүнс усан дээр дуу чимээ гаргалгүйгээр эхлээд гарваад явчхав. Харин Сунг Тинг-по явах гэж хичээхдээ сүнсний сэжгийг төрүүлэхүйц аймшигтай их ус үсчүүлэв.

- Яагаад чи ийм чимээ шуугиан гаргаж байгаа юм бэ? гэж тэр гэнэт асуув.

- Би үнэндээ яаж гатлахаа маш бага мэдэж байлаа л даа гэж Сунг хэлэв.

- Шинэ сүнс минь маш их зүйлийг сурч мэдэх хэрэгтэй юм байна даа гэв.

Тэд нарыг захал орж ирэхэд үүр хаяар ч байлаа. Яг энэ үед ал ээтгэр Сунг Тинг-погийн нуруун дээр байлаа. Харин түүнийг буух гэж оролдоход нь Сунг түүнийг чанга zuурав. Тэр чарлаж, орь дуу болсон ч тэр түүнийг явуулсангүй. Гараараа түүнийг маш бөх zuурч аван газарт буулгав. Харин сүнс зах дээр зарагдахаа хүлээж байгаа янз бүрийн амьтдыг харж байв. Тэр газарт буугаал хоньолж хувирav. Түүнд гүйгээд алга болох болон ойролцоо хашаанд ороод алга болчих санаа байсангүй. Юут сурч мэдсэнээ санаж Сунг Тинг-по хонин дээр нулимав. Ингэснээр тэр сүнсний хэлбэртээ орж чадахгүй байсан юм. Дараа нь түүнийг хүзүүгээр нь хөтлөн махны худалдаачин дээр авч ирэв. Худалдаачин түүнд мянга таван zuun төгрөг бэлнээр ямар ч эргэлзээгүйгээр өглөө. Энэ нь магадгүй сүнсийг мянга таван zuun төгрөгөөр буюу бэлэн мөнгөөр худалдаалсан цорын ганц тохиолдол байж ч болох юм.

Өөр нэгэн сүнсийг барьж авсан хүн бол Ло Та-лин бөгөөд түүний даалгавар арай өөр арга замаар хийгдсэн юм. Ло тариачин байсан бөгөөд Сунг Тинг-по шиг авхаалжтай байгаагүй боловч өндер, хүрэн бор царайтай тун их хүчтэй нэгэн байлаа. Тэрээр жинхнээсээ яг л морь шиг хүчтэй байсан билээ. Нэг найзынх нь морь нь доголон болоход тэр түүнийг хоёр гар дээрээ өргөн жүчээнд нь аваачжээ.

Тэрээр догшин авиртай хүн байсан бөгөөд түүнд хэн ч сайхан

хандаж байсангүй. Тэр хүнийг ч, бут чөтгөрийг ч айлгадаг гэж сайрхдаг байлаа. Түүний харамсдаг цорын ганц зүйл нь ядуу байсан явдал нь юм. Тэр хэн нэгэнд ухаангүй дурлаж, эхнэр авах байсан боловч түүнд бэлэг авч хуримандаа зориулах мөнгө байсангүй. Нэгэн өдөр тэр найз нартаа өөрийнхөө адайр зангаар тариачны ажил бол ялаас өөрүүгүй бөгөөд гар дээрээ нэг ч мөнгөгүй байсаар байгаад авсандаа орох болох нь гэж гомдоллож байв. Тэд түүний хэлж байгааг тэсэхээ болж эцст нь нэг нь гарч ирээд,

- Чи дандаа л өөрийгөө бага олж байна гэж гоншигнож, мөн их эр зоригтой, аймшигтүй гэж сайрхаж байх юм. Хүнийг ч, бут чөтгөрийг ч айлгадаг гэж хэлдэг. За тэгвэл чи сүнснээс айх юм уу? гэлээ. Ло Та-лин хөхөрч унав.

- Би нуруу шигээ ханхар сүнсийг харахыг хүсч байна гэж тохуурхан хэлэв.

- Тэгвэл чамд мөнгө олох аз завшаантай нэгэн арга байгаа юм байна гэж нөхөд нь хэлэв.

- Хэн тэгээд тэр азыг надад өгөх юм бэ? гэж Ло асуув.

- Хөгшин баян Уанг. Хэрвээ чи бургасан байрыг эргэж байдаг тэр нэгэн зүйлээс ангижруулах юм бол... гэж түүний найз нар нь хариуллаа. Бусад нь энэхүү зоримог зөвлөмжийг сонсоод уулга алдав. Хөгшин Уанг бургасан байрандаа дахин амьдарч болох их хэмжээний мөнгийг өгнө гэдэг нь үнэн үт байлаа. Тэр нь евслэг бургасан төгөлд босгосон сайхан харш байсан юм. Хэдэн жил эзгүй байсан түүнийг Уанг худалдаж авчээ. Тэрээр түүнийг засварлаад гэр бүлийнхнийгээ нүүлгэж авчирчээ. Дараа өглөө түүний хоёр зарц нь жигтэйхэн учир битүүлгээр нас барсан байлаа. Уанг шууд л өөрийнхөө хуучин байшинд нүүж орсон бөгөөд бургасан байраа түрээслүүлэхээр зар тавьсан юм. Гурван ч хүн ээлж ээлжээр түрээслсэн боловч нүүж ирснийхээ дараа өглөө нь бүгдээрээ үхчихсэн байдаг байв.

Ло Та-лин энэ бүхнийг мэддэг байлаа. Харин баян Уанг түүнийг энэхүү сүнсээс ангижруулсан хэнд ч гэсэн шагнал өгч болох юм гэсэн болол нь түүний нүдийг гялалзуулж байв. Тэрээр шууд Уангл санал тавихаар түүний байшингийн орчимд очив. Уангийн зарц нар эзэнтэй нь уулзхаар ирсэн бүдүүлэг нөхрийг буцаахыг оролдсон боловч Ло Та-лингийг том булчин шөрмөсөө зангидахад тэд тэмцэлдэхээ болив.

Уанг Логийн саналыг баяртайгаар хүлээн авлаа.

- Хэрвээчи бургасан байрыг энэхүү сүнсээс ангижруулах юм бол зуун алтан зоос өгөх болно гэж амлав. Логийн нүд хэзээ ч байгаагүйгээрээ

гялалзан байв.

- Надад нэг захын хажууд жижигхэн байшин байдал гэж Уанг нэмж хэлэв. Би түүнийгээ чиний сүйнд өгөх болно.

Ло магнайгаа хагартал баярлав. Дараа нь түүний санаанд жаахан сэжиг төрж,

- Би таныг угээсээ бушахгүй гэдгийг яаж мэдэх юм бэ? гэж асуув.

Уанг инээгээд,

- За тэгвэл гэрээ хийшгээе гэж хэлээд тэрээр зарц нартаа цаас, бийр, бэх авч ирэхийт тушааж, дараах гэрээг хийхээр болов. "Бургасан байранд ирж, харшигийг байнга эргэж байдал ямар нэгэн ад зэтгэр, сүнс, эсвэл буг чөтгөрөөс цэвэрлэх ажлын хариуд Уанг Хсин-хунг би Ло Та-лиинд зуун зоосыг захын ойролцоох илжигний гудамжинд байрлах байшингийн хамт өгөх болно гэдгээ үүгээр баталгаажуулж байна." Уанг баримтанд гарын үсгээ зураад Ло Та-лиинд өгөв. Ло гялс гүйлгэн харсан боловч эргэлзэнгүйгээр толгойгоо сэжлэн түүнийг цоо ширтэж, эрхий хуруугаа бэхтэй хавтанд дүрээд цаасны яг голд нь тамга дарж орхив.

Бүр орой болсон хойино Ло бэлтгэлээ хийв. Энэ нь түүнд хялбар байлаа. Тэрээр хэдэн том лаа, хагас килограмм саримс мөн хэдэн лонх дарс худалдаж авав. Тэрээр саримсыг нухаад дарстайгаа холин бага зэрэг уув. Дараа нь лааныхаа нэгийг асаагаад бургасан байрны гадаах үдний цуургыг мултлан авч орлоо.

Бургасан төгөл хүргэл түүнийг олон хүмүүс дагаж ирэв. Тэд үүдээр орохыг нь харж байхдаа гүнзгий санаа алдаж байхыг нь сонсов. Гэтэл нэг хүн:

- Ло Та-линий төлөвлөгөөг би сайн мэдэж байна. Тэр бид нарыг гэр лүүгээ буцаж явахыг хүлээж дараа нь нууцаар энэ үүдээр гарч ирнэ. Тэр төгөл дунд шөнийн турш нуутдаад дараа нь өглөө болоход нууцаар эргэж орох болно. Тэгээд бид ирээд шөнө дунд хөөн гаргасан сүнснүүдийн бүхэл бүтгэн армиийн сүүлийг машгих байгааг олж харах болно гэв.

- Энэ тохиолдолд түүнийг өглөө болтол гаралаагүй гэдгийг нь мэдэх ёстой гэж өөр нэгэн хэлээд үүдийг гаднаас нь цуургадав.

Ло Та-лин түүний ард үүдийг цуургадаж байгааг сонсон цухалдав. Түүний лааны гэрэл (Тэнд тэнгэрийн гэрэл байсангүй) хашаан дотор түүний эргэн тойронд цагираг бий боллоо. Цэцгийн мандлыг зэрлэг ургамал хөндлөн гулд сүлжсэн байлаа. Ногоо чулуу дэвсээн замын дундуур цухуйж байв. Дотор талын үүдэнд ороонги соёг ургаж битүү дарсан байв. Тэдгээрийг Ло тасдан авч хаялав. Харшийн дотор талд

өрөө болгонд зузаан тоос шороо тогтсон байв. Түүнийг хөдлөх бүрд нь тоос босч амьсалахад хэцүү байсан ба алхам бүрт нь аалзны тор нүүрэнд нь наалдаж байлаа. Энэ бол аймшигийн газар байв. Гэвч эцсийн эцэст Ло Та-лин юунаас ч айлгүйгээр шороо тоос ч үгүй аалзны шүлс ч үгүй нэгэн өрөөнд орж ирэв. Өрөөнд хэн нэгэн хүн амьдардаг гэсэн шинж тэмдэг байсангүй. Харин тэнд нэг хананых нь дэргэд сүүлчийн түрээслэгч орхисон байж болох хөшиг, цагаан хэрэглэл бүхий ор байв. Ло Та-лин тэр орон дээр сууж лаагаа үлээн хүлээж байв. Тэрээр хэвтээгүй, нүдээ анилгүй чимээгүй хүлээн суусаар л байв.

Шөнийн харанхуй, чив чимээгүй үед өрөөний гадна талд их чимээ гарч, хаалга дэлгэгдэн онгойж сүns орж ирлээ. Тэр өрөөн дотуур энд тэндгүй гүйж байв. Харанхуйд Ло түүнийг сайн ялгаж чадахгүй байлаа. Тэрээр бараан өнгийн хувцас өмссөн ба түүний нүүр гар нь хувцаснаас нь ялгарахаартгүй харагдаж байв. Нүдээ бүлгтийлгэн сүнсийг өөрийнхөө орны дэргэл иртэл хүлээж байв. Дараа нь тэр үсрэн босч том алхаад бахь мэт гараараа түүний гарыг хөйслэгч барьж авав. Сүns зогсоод мултрахаар тэмцсэн боловч тусыг олсонгүй. Гарыг нь хоёр хажууд нь хүлсэн учир юу ю ч хийж чадахгүй байлаа.

Хүн сүns хоёр нүүр нүүрээ харан зогсож байв. Тэгээд сүns Ло Та-линий нүүр лүү үлээж эхлэв. Түүний амьсгаа нь мөс шиг хүйтэн, бүр аймшигтай хүйтэн байв. Ло хажуу тийш нүүрээ буруулав. Харин сүns түүний хүзүү үрүү нь үлээхэд тэсвэрлэшгүйгээр өвдөж эхлэв. Яг л хутга дүрэж байгаа мэт байлаа. Эцэст нь Ло тэсвэрлэж чадсангүй, арай ядан толгойгоо эргүүлж, сүнсний өөдөөс хараад түүн үрүү үлээж эхэллээ.

Одоо Логийн өөрийнх нь амьсгаа хагас килограмм сармисаар үнэртэхэд сүns түүнийг тэсвэрлэж чадахгүй болов. Сүns толгойгоо хажуу тийш болгов. Толгойгоо тэгшлэх бүрд тэрээр сармисны огиудас хүрэм муухай үнэртэй тулгарч байлаа. Ло амьсгалж чадахгүй болтлоо үлээсээр байв. Одоо сүнсний эзлж ирж Логийн нүүр лүү үлээв. Нэг нь ногөө үрүүгээ үлээсэн тэдний хооронд жигтэй тулаан үргэлжлэв.

Өвчин авчирсан урт шөнө төгсгөл болож гадаа хаа нэгтэйгээс тахиан дуу сонсов. Энэ нь Ло Та-линий хүсэн хүлээж байсан мөч юм. Тахиан дуутай зэрэгцэн алдчих вий хэмээн зовниж тэрээр сүнсний гарыг урьлынхаасаа илүү чангаар базан авав. Харин сүns арилж чадсангүй, харин агшиж эхлэв. Логийн гарт агшаар байлаа. Тэрээр одоо Логийн нүүр лүү үлээж чадахаартгүй болов. Ло түүний атганд сүнсний бие нь чангараасаар байгааг мэдэрч гайхаж байв.

Үүр туяархад Ло Та-линий найз нар бургасан төгөлд цугларч

өглөөний гэгээ ороход тэд цуургыг мултлан авч харшид орж ирэв. Юут олж харах бол гэж айсан тэд цэцэрлэг болон шороо тоосонд дарагдан өөрөөнүүдийн дундуур явж байлаа. Тэд эцсийн эцэст өөрөөний дунд Ло гэмтээгүй зогсож байхыг хараад ихэд тайвширлаа. Тэрээр гартаа мол барьсан харагдав. Тэднийг орж ирэхэд Ло сүнсийг тавьж явуулахад шалан дээр унаж тачигнан дуугарав. Тэд үүнийг сонирхон харж байлаа. Энэ нь эргний шариллийн хайрцаагны хэсэг мод байв. “Энэ та нарын сүнс байна. Үүнийг шатаачих. Тэгээд л боллоо” гэж Ло хэлэв.

Тэд модыг авч яваад шатаачхав. Түүнийг шатаж байхад хэн ч хажуугаар нь явахын аргагүй муухай үнэр гарч байв. Хөгшин баян Уанг цаг алдалгүй амлалтгаа биелүүлж Лод зуун зоос нэг байшин өгөв. Харин Ло эхнэр авч илжигний гудамжинда суурьшив. Гэхдээ үлдсэн амьдралынх нь туршид Ло салхи гарах болгонд гэмтсэн хүзүү нь өвддог байсан бөгөөд тэрээр түүнийгээ хэзээ ч эмчилж чадаагүй билээ.

Сүнстэй таарсан хэн бүр түүнээс айхгүй байх нь чухал. Зөвхөн эрчүүдийн айдаг тэдэнд хүч өгдөг юм. Үүний жишээ болгож Яангчоу дахь найзындаа нэгэн удаа зочилсон Цао гэлэг хүний талаар өгүүлье.

Зун ил дундаа орж байлаа. Цао найзынхаа амгалан бөгөөд саруулхан номын санд сэтгэл автав.

- Энэ ямар аятайхан газар вэ. Надал ороо энд цонхных нь дэргэд тавихыг зөвшөөрөх болов уу гэж тэр хэлэв.

- Энэ өдрийн турш та миний даруухан номын санг ашиглаж бололгүй яхав. Гэхдээ би энэ өрөөг унтах зориулалтаар танд зөвшөөрч чадахгүй болов уу гэж айж байна гэж түүний эзэн нь хэлэв. Тэр ямар нэгэн шалтгаан хэлэх хүсэлгүй байсан боловч эцэст нь Цао түүгээр хэлүүлэхээр болов.

- Манай номын сан гүйдэлтэй гэж хэлж байгаадаа би хүлцэл очье гэлээ.

- Гүйдэлтэй! Юу гүйдэг гэж? хэмээн Цао гайхав.

- Хэдэн жилийн өмнө өөрийгөө энэ модноос дүүжилж үхсэн үйлчлэгчийн сүнс гэж хэлээд эзэн дээш заав.

Харин энэхүү онц сонирхолтой мэдээг сонсоод Цао номын санд унтахыг улам ихээр хүсэхэд эзэн нь зөвшөөрч цонхны дэргэд ор тавьж өгөв. Арай гэж номоо тавиал эргэтэл сүнс гарч ирэв. Цао хаалга уруу харан хэвтэж байлаа. Хаалга болоод хаалганы хажуу талын босоо модны завсар хуудас цааснаас нимгэнгүй дүрс гарч ирэв. Цаогийн

баярласан харцны өмнө тэрээр дэлгэгдэж нэгэн бүсгүйн дүрсэнд хувирав. Өрөөний төвд очоод эмэгтэй Цао уруу харан зог туссан нь зүтгээр нэг болхицуу байдал байсангүй. Түүний толгой огцом хөдөлж амаа ангайлган хэлээ дүүжлэгдсэн хүний маягтайгаар доош унжуулав.

- Энэ чинь сонин заль мэх байна шүү. Дахиад хийгээтэх дээ гэж Цао хэлэв.

Тэр Цаог айлгаж чадсангүй. Сүнс хэсэг зуур хөдөлгөөнгүй зогсож дараа нь толгойгоо аваад номын сангийн ширээн дээр тавьчхав.

- Толгойтой байхад чинь би чамаас айгаагүй юм чинь чи юунд түүнийг авч намайг айлгах гэж оролдов гэж Цао тайвнаар хэлэв. Сүнс харсаар байтал үзүүлбэрээсээ сульдаж алга болов. Өглөө нь Цао босод эзэндээ юу тохиолдсоныг бүгдийг ярьж өгөв. Эзэн бага зэрэг тутшингүй инээмсэглэж номын сангаас ороо авахыг гүйсан боловч Цао ороо тэнд нь үлдээхийг дахин хүсэв.

Тэр шөнө дунд болоход сүнс түүний өмнө дахин гарч ирэв. Удалгүй өрөөний голд хэвэнд ороод нөгөө хүн хэвтэж байхыг хараад сүнс шалан дээр үсчин жигшиングүйгээр,

- Оө нөгөө зөрүүд эр чинь байна гэж хэлээд тэр даруйдаа алга болов.

Мөн бүх төрлийн хууль зөрчигчдөд өөрийн гэсэн үнэнч шударга байдлыг эрхэмлэдэг сүнснүүдээс айх шалтгаан байдаг.

Чанг-чиутийн баян гэр бүлийн нэгэн гишүүн хатагтайд түүний нас барсан нөхөр нь оншгой эд хөрөнгө үлдээжээ. Тэрээр буянтай эмэгтэй байсан бөгөөд дахин хүнтэй суугаагүй учир найз нөхдөдоо хүндлэгддэг байлаа. Гэхдээ тэрээр үхсэн нөхрийнхөө ах дүү, ялангуяа тэд нарын эхнэрүүдийнх нь илгээсэн элч нарын сэтгэлийг татаж чадлаггүй байв. Тэд нар бэлэвсэн эмэгтэйн хувцас, түүний хэд хэдэн зарц нартай нь өрсөлдөхүйц байж чадлаггүй байсан юм. Ийм учраас эдгээр сэтгэл хангалаун биш байдал нь бэлэвсэн эхнэрийн эд зүйлсэд хүрэх хуйвалдааныг гаргахад хүргэжээ. Тэд түүний талаар хортой яриа гаргав. Хорон уг хэл нь сэлэмнээс ч хурц гэлгийг хүн бүхэн мэдэх бөгөөд эцсийн эцэст орон нутгийн шүүх дээр бэлэвсэн эхнэр энэ нутгийг орхисон нэгэн эртэй холбогдсон гэх хэргээр дуудагдав.

Ку гэдэг нэйтэй шүүгчийг мэдэх хүргэл бүх юм сайхан байлаа. Ку бол авилгайд автсан шүүгч байв. Түүнд бэлэвсэн эхнэрийн ах дүү нарынх нь эхнэрүүд (тэд хэзээ ч болоогүй юмыг нотолж чадахгүй байх

байлаа) их хэмжээний авилгал өгсөн учир бэлэвсэн эхнэр шүүхээр орж ирэхдээ түүний тайлбар ямар ч найдлагагүй гэдгийг мэдэж байв. Харин Кугийн хувь бол бүсгүйг буруутгасан хүмүүсээс авсан авилгалынхаа хариул түүнийг буруутгана гэсэн барьцаанд орсон байлаа. Ямар ч гарах гаршгүйгээ мэдээд бэлэвсэн эхнэр шүүхийн танхимд зогсож байхдаа ханцуйнаасаа хутга гаргаж ирээд өөрийгөө дурж, шүүгчийн холний дэргээд үхэтгийн унав.

Тэрхэрэг болсон даруйдаал шуугиантарьжөндер албан тушаалтнууд тодруулга хийж эхэлсэн ба Ку болон түүний албатууд ихээхэн хэмжээний авилгал авсан гэдгийг илрүүлэв. Ку ажлаасаа халагдсан бөгөөд хууль бусаар олж авсан орлогыг нь хурааж авсан байна. Харин тэр түүнийг ая тухтай байлгахад хүрэлшэхүйцээд хогшилтой Сүчоу дахь гэртээ буцаж ирлээ.

Энэхүү сэтгэл шаналгасан хэрэг явдал болж өнгөрснөөс хойш хэдэн жилийн дараа Яанг гэдэг нэртэй нэгэн худалдаачин Чанг-чиутаар дайрч өнгөрөх завшаан тохиосон юм.

Орой болж байлаа. Тэр нэгэн аятайхан дэн буудалд толгой хоргодохоор болов. Харин дэн буудлыг нөгөө бэлэвсэн эхнэрийг шүүх дээр өөрийгөө хороосны дараа зарагдсан түүний харшид байгуулсан байв. Мэдээж хэрэг худалдаачин Яанг энэ талаар юу ч мэдэж байгаагүй. Тэр шөнийг өнгөрөөх өрөө олдоогүйд сэтгэл гонсгор байсан юм.

- Надад унтах газар хаа нэгтээ олдох нь уу гэж дэн буудлын эзнээс асуув.

- Манайд байгаа өрөө бүхэн хүнтэй байгаа. Чи унтах чадахааргүй нэгхэн газар л бий гэсэн хариу сонсогдов.

- Тэр чинь ямар өрөө юм бэ? Яагаад би унтах чадахгүй гэж? хэмээн Яанг асуув.

- Би тэр өрөөг хэдэн жилийн өмнө хаачихсан юм гэж буудлын эзэн хэлээд,

- Тэр өрөөнд унтсан зочин бүхэн гүйдэлтэй байна хэмээн гомдоллодог байсан юм гэв.

- За яахав энэ л түүний шалтгаан нь юм бол би тэр өрөөг чинь авьяя. Би гомдол гаргахгүй гэж амлай гэж Яанг инээмсэглэн хэлэв. Ингээд буудын эзэн түүнд унтах хооллох газар өгөхөөр болжээ.

Тэр өрөө дажгүй тохилог байсан бөгөөд орных нь өмнө нэгэн эмэгтэй зогсоод түүнийг сэрэх хүртэл бага зэрэг унтсан байлаа. Тэр цонхийсон царайтай байсан бөгөөд түүний хувцас гаран дээр нь цус байлаа. Энэ бол сүнс байсан юм.

Эмэгтэй түүн дээгүүр үсчин байсан боловч Яанг өөртөө битгий ай гэж хэлэв.

- Та Сүчоугаас ирсэн хүн үү? гэж эмэгтэй түүнд хандан нарийхан хоолойгоор асуув. Яанг:

- Тийм гэж хариулахад,

- Би бол буруу хэрэг хийгээгүй ч хэлмэгдсэн хүн. Та хусвэл миний өшөөг авч болно. Танд ямар ч гэм хор учрахгүй гэж тэр эмэгтэй үргэлжлүүлэн хэлэв.

- Би чинь шүүгч биш, худалдаачин хүн. Чиний хийсэн буруу хэргийн чинь өшөөг би хэрхэн авч чадах билээ гэж Яанг гайхан хэлэв.

- Буцаж явахдаа та намайг аваад яв. Энэ бол миний хүсэх юм. Хэрвээ та ингэх юм бол зовсны чинь төлөө би шагнах болно гэж сүns хэлэв.

- Би чамд үйлчлэхд бэлэн. Харин чамайг яж авч явахыг надад хэлээд өгөөч гэж Яанг хэлэв.

Сүns түүнд зааварчилгаа өгөв. Буцаж явахаар болохдоо намайг дуудаарай. Завиндаа суусан ч байсан, гүүрний доогуур эсвэл дээгүүр явж байсан ч хамаагүй намайг чимээгүйхэн дуудаарай. Таныг Сүчоуд хүрэхэд би таныг шүүгч байсан Кугийн байранд хүрч ирээсэй гэж хүсч байна. Ирэхдээ шүхэр авчраарай. Би шүхрэн дор нутгахаа болно. Энэ бол таны хийх ёстой бүх зүйл. Учир нь би энэ өрөөг срдөө орхиж байгаагүй. Түүний зүүн урд булангийн хананд эрдэнэсийн зүйлстэй хайрцаг байдаг юм. Надад сайхан сэтгэл гаргасны чинь төлөө би танд түүнийг өгөхийг хүсч байна гэж хэлэв.

Ингээд сүns алга болжээ. Яанг эргэн унтахаар хэвтэв. Өглөө нь тэр сүnsний зааж өгсөн тэр хананы хэсгийг бага зэрэг ховхолж үзэв. Тэнд үнэхэр хамгийн үнэтэй сувдаар дүүрсэн жижигхэн хайрцаг байлаа.

Яанг сүnsний зааврыг үг үсэгчлэн дагав. Гэр лүүгээ явах замдаа тэр нам дуугаар эмэгтэйг дуудлаа. Завинд сууж байхдаа, түүнийг хөдлөхөд, гүүрээр болон гүүрэн доогуур гарч байхдаа түүнийг дахин дахин дуудаж байв. Ингээд Сүчоуд хүрч ирээд шүхэр худалдаж авсан бөгөөд шүүгч байсан Кугийн гэрт шулуухан яваад ирэв. Энэ нь Ку хэдэн зочноо зугацуулахаар явуулын жүжигчдийг урьсан байсан өдөр таарав. Тиймээс Яанг цэцэрлэгт нь мэдэгдэлгүй орж чадсан юм.

Хэсэг хугацаанд Яанг хоёр хошин дайчны марзаганахыг, мөн зочид хөгжилдэж байгааг харж зогсов. Гэтэл аймшигтай дуу гарч хөгжилдэж байсан хүмүүс цус харан алмайрав. Энэ бол Ку байлаа. Тэрэр ганцхан минутын өмнө нохөдтэйгээ ууж идэж, хөөрөн баясч байсан юм. Түүний хөл чичигнэн зогсож байсан ба цонхийн цайсан царайнаас нь нүд нь

унах шахсан харагдав. Түүний чичигнээсн гарасы дарсны хундага унав. Тэрээр эцэст нь гарас өргөн урагш зааж,

- Түүнийг гаргаач, түүнийг гаргаач, тэр эмэгтэйг гаргаач! Түүний хувцсан дээр нь цус, гарг нь хутга байна. Би түүнийг мэднэ. Түүнийг гаргаач! гэж тэрээр хяхтнан хашхирч байв. Гэхдээ хэн ч, бүр тэрхүү аймшигийг ажиглаж зогссон худалдаачин Яанг ч юу ч олж харсангүй. Ку сандал уруугаа чичигнэн унаж байв. Тэрээр хатуу дарс уун ухаан санаа нь эргэн ирсэн боловч үдэшлэг дуусч, удалгүй зочид явцгаав.

Тэр шөнө Ку өөрийнхөө унтилагын өрөөнд өөрийгөө дүүжилж амиа хорлосон билээ. Ингээд Чанг-чиу дахь дэн буудлын өрөө гүйдэлгүй болсон юм.



Замын ид шидтэнүүд

Буддын шашны санваартнууд толгойныхоо үсийг хусчихдаг байв. Гэхдээ Хятадын уран зургаас чи бясалгал хийн сууж байгаа, шашиналаг байдал нь түүний ноорхой хувцас, толгой дээрх хааш яиш харагдах их үстэй нь зохицолдоогүй байдал хүнийг харж болно. Тэрээр мөн гэгээнтэн байж болох боловч Таогийн шашиントын итгэн сүсгэллгээр зам мөрөө буюу эртний мэргэн Лао Цугийн Таог дагадаг байна. Олон ийм эрчүүд өөрсдийгөө ариусган шидэт өвс идэх буюу зарим нэг нууц үрэл эсвэл амьдралыг уртасгагчийг санаанаасаа зохиож, энгийн хүний бисийн хязгаараас давсан өөрсдийн чадлыг нэмэгдүүлж чадна гэж итгэдэг байлаа. Магадгүй тэдний зарим нь ингэж хийдэг байсан байх. Ямартаа ч гэсэн жирийн хүмүүс тэд нарыг газар дэлхий дээрх хамгийн чадварлаг ил шилдэн гэж итгэж, тэдний талаар хүрэлцээтэй түүхийг сонссон байдал билээ.

Жишээлбэл унтах талаар асуудал байдаг байв. Нойр нь бие болоод сэтгэлийг хүчтэй болгодог хэмээн үздэг Таогийн шашинтанд Чен Туан тэр урлагийг төгөлдөржүүлэхээр өөрийгөө бэлдэжээ. Тэрээр найман зуун жил унтаж дэлхийн дээд амжилтыг тогтоосон билээ. Гэхдээ тэр ийм удаан хугацаагаар дандаа тайван амгалан байсангүй. Тэр Тай Хуа-шан гэдэг уулан дээр, буйд газар амьдарч байв. Нэг одор тэр уулиаас бууж явваа харагдав. Хэдийгээр хэдэн сар өнгөрсөн ч тэр эргэж ирсэнгүй. Тэр уулан дээр амьдарч байсан өөр бусад гэгээнтнүүд түүнийг хaa нэгтээ амьдрахаар явсан ба тэдний бясалгал дээр бушаж ирсэн гэж ярьдаг байлаа.

Өвөл дохж байлаа. Хүйтнийг давахын тулд бэлтгэсэн түлээ модны нөөц багасч эхлэв. Нэгэн хүний модны хашаан дахь овоолго нь дусах өдөр ирлээ. Тэрээр нэгэн урт нарийхан гуалинг шүүрч аваад татлаа.

Гэтэл тэр хүний хөлөөс зуурсан байгаагаа мэдэв. Айсандaa оройд нь байсан үлдсэн гуалингуудыг авч зайлувлав. Дараа нь чанга гэгч нь инээв. Харсан чинь Чен Туан өндийж суугаад, нүдээ нухлан биес цэхлэн сахлаа цэвэрлэж байв.

Өөр нэг өдөр оройхон тийшээ нэгэн тариачин тэр уулын доод бэлд өвс бэлтгэхээр гар хадуураар хадаж байв. Тэр доош урсдаг нэгэн горхины хатсан хавцал байдаг газарт амрахаар ирсэн ба тэнд нэгэн цогцос байхыг хараав. “Хөөрхий муу хүн” гэж тариачин гуниглан бодоод ойроос харахаар тонгойв. Цогцос дээр хунгарласан хөрсөнд өвс, зэрлэг ургамал ургасан бөгөөд хөлнийх нь хооронд болжмор өөрийнхөө үүрийг засссан байлаа. Тариачин түүнийг өрөвлөж эхлэв. Тэр тэрэг авчраад цогцсыг аваачиж аятайхан оршуулахаар шийдэв. Гэтэл энэ мөчил Чен Туан сэрлээ. Тэрээр нүдээ том нээгээд,

- Би үнэхээр сайхан дут хийчихлээ. Надал саад болсон хүн чинь хэн сэн билээ? гэхэл уулын агуу их ухаантан байна гэж тариачин түүнийг танилаа. Тэрээр маш энгийнээр эзний амралтыг балласандaa хүлцэл очоод, хадуур луугаа буцаж ирэв. Энэ зуур Чен Туан өглөөнийхөө цайнд орохоор аажуухан алхан оджээ.

Лиу Кен бол Сүнг-Шан уулан дээр амьдардаг Таогийн шашинд өөрийгөө зориулсан хүн байлаа. Тэнд тэр олон гайхамшигтай хүчийг авсан юм. Түүний илрүүлсэн нээлтүүдийн нэг нь залуу наасны нууцыг олсон явдал юм. Зуу гаран настай байхдаа яг л арван таван настай хүү шиг харагддаг байсан гэж ярьдаг байлаа.

Тэр зөвхөн өөрөө л ашиг тусыг нь хүртсэнгүй. Нэг удаа Енг-чuan хотод тахал гарч, бүр амбан захирагчийн гэр бүлийнхнийг ч өрөвдсөнгүй. Гэхдээ амбан захирагч зам мөрдөө их анхаарал тавьдаг байсан ба Лиу Кенийг ойролцоо явж байна гэдгийг сонсоод түүнээс тусламж эрэв. Лиу Кен тэр даруй түүнд хачин сонин үсэг бүхий хэсэг цаасыг өгчээ. Энэ бол амбан захирагч шөнө өөрийнхөө оршин суугаа байрны хаалган дээр тогтоох ёстой нэгэн тарни байсан юм. Тэгээд өглөө болоход түүний гэр бүлийн гишүүдээс хэнд нь ч тэрхүү айдас авчирсан өвчний ул мөр илрээгүй байна.

Харин удалгүй Енг-чuan амбан захирагчаа сольсон юм. Чанг гэдэг нэртэй шинэ албан хаагч урьд өмнөх захирагчаас шал өөр хүн байв. Түүнд Лиу Кений хэргийн талаар доод тушаалтнууд нь ярихад тэр огт тоолгүй тохуурхдаг байв. Тэд нарыг үүх түүхээ яриад салахгүй болохоор

нь Чанг уурладаг байлаа. Нэгэн өдөр тэр гайхамшигтай энэ хүнийг авчуулахаар шийдсэн ба элчээр баривчилж авчуулахаар болов. Энэ тухай мэдээ хот даяар маш хурдан тархжээ. Элч нар амбан захирагчийн өргөөнөө явваад эгдүүцсэн хүмүүс гудамжийт хаасан байхыг мэдэв. Тэд үүрэг даалгавраа биелүүлэх очижхэн ч сэтгэлгүй байсаар бушаж ирэв. Гэвч амбан захирагчийг юу ч айлгасангүй. Тэр цэрэг явуулж хүмүүсийг тарааж Лиу Кенийг шүүх дээр авчирч байцаахаар явуулав.

Эцэст нь Лиу Кен хөл нүүгэн, уранхай ноорхой хувцастай амбан захирагчийн алтаар бүрсэн сандлын доод талд зогсож байв. Шүүх бүхнээс ангижирсан боловч хайхрамжгүйгээр ажиглаж байсан цэргүүдийг хүчтэй дээд албан тушаалтынхаа өмнөөс эсэргүүцэн хүзүүгээрээ дэнчин тавихгүй байхыг сануулсан байлаа. Амбан захирагч доош тонгойж хангинасан дугаар Лиу Кен үрүү хандан,

- Та ид шидтэн үү? гэж хангиналаа. Лиу Кенийн хариулт баархал ч, хүндэтгэл ч үзүүлсэнгүй, тайвнаар,

- Тийм гэж хариулав.

- Үхэгдийн өртонцоос чи сүнсийг авчирч чадах уу? гэж амбан захирагч үргэлжлүүлэв.

- Би чадна гэхэд амбан захирагч баярлав. Энэ нь үнэхээр хялбархан байлаа. Энэ хуурамч этгээд түүний урхинд шуудхан оров. Урьдынхаасаа ч илүү чангаар тэрээр хашгиран,

- Тэгвэл надад хэсэг сүнсийг одоо энэхүү шүүх дээр харуулаатах. Тэгэхгүй бол чи хуурамч этгээд болон луйварчныхаа хувьд шийтгэл амсах болно гэлээ.

Лиу Кен түүнийг яллахаар аль хэдийнээ бэлтгээд байсан багаж зэвсгийн байгаа тал уруу гүйлгэн харав. Шагайг нь шаходг банснууд болон түүнийг зодох хүнд хулсан саваа зэрэг байлаа. Ингээд тэр гэгээнтний нүүрэн дээр бага зэрэг инээмсэглэл тодорч байгааг ажиглан гайхаж байсан амбан захирагч уруу эргэж харав.

Үүнээс хялбархан зүйл гэж байхгүй хэмээн Лиу Кен зөвлөөр хэлэв. Тэрээр бийр, савтай бэх цаас авчрахыг хүсэв. Хамгаалагч түүнд эдгээрийг дамжуулахад цаасан дээр хэдхэн мөр чадамгай бичив. Ингээд түүнийг зуух уруу аваачиж делөнд хүргэв. Туурайн дэвсэлт болон хуягны хангинах чимээ шүүхийн танхимд дуулдахад, цаасны сүүлчийн хэсэг нь харлаж байлаа. Шүүхийн хана дэлгэгдэн нээгдэж, морьтой сэлэм жадаар зэвсэглэсэн дөрөв, таван зуун хүнтэй агуу их цэрэг орж ирэв. Тэд нарын эгнээ яргадж тэдний хамгаалж байсан хоёр хоригдол өвдөглон суусан тэрэг гарч ирлээ.

Лиу хоригдлуудыг тэрэгнээс гаргаж амбан захирагчид аваачихыг тушаав. Нэг нь настай эрэгтэй хүн байсан бөгөөд ногөөх нь эхнэр нь байх нь тодорхой байлаа. Настай эрэгтэй хүн толгойгоо өндийлгэж амбан захирагч уруу хандан хүчтэй, үл сайшаасан өнгөөр дараах зүйлийг хэлэв.

- Хүү маань бидэнд ийм гутамшиг авчирч байгаа гэж бодож болох нь ээ! Бидний үхлээр эцэг эхдээ хүлээсэн чиний үүрэг дуусгавар болно гэж чи бодохгүй байна уу? Эсвэл өөрийнхөө тулгаж буй яланд биднийг оролцуулгүйгээр гэгээнтэнд доромжлол хүлээлгэх үү? Яаж чи үхсэн эцэг эх биднийхээ нүүрийг харах гэж зориг гаргаж чадаж байна аа?

Үнсэн царайтай амбан захирагч суудлаасаа яаран бууж Лиу Кений өмнө уйлан хайллан өвдөг сөхрөн унав. Тэр түүний эцэг эхийг нь суллаж нийгүүлсэл үзүүлэхийг түүнээс царайчлан гүйлаа.

Лиу Кен тушаал өгсөн ба амбан захирагч гэгээнтэн болон хамгаалагч нар аюулгүй, хоосон шүүхийг харав. Нөгөө хана хаагдаж хэзээ ч байгаагүйгээрээ хатуу бөгөөд нүсэр болсон байлаа. Ингээд зам мөрөө дагадаг хүмүүсийн хүчинд эргэлзэн аз туршсан зүйлийг амбан захирагч Чанг дахин хэзээ ч хийгээгүй билээ.

Эрх мэдэлтнүүдийн өөдөөс боссон өөр нэгэн ид шидтэн бол Таогийн шашинтан Уэйн наймдугаар сарын гүнтний талаар цуврал хошин шогийг бүхэлд нь тоглосон Цо Цу гэдэг хүн байлаа. Энэ бүхэн Цо Цут төв замын дагуу алхаж явахдаа том сагтай юм үүрсэн зөөгчдийн цувааг харсан тэр нэгэн өдөр эхэлсэн юм.

- Энэ сагснуудал та нар юу авч яваа юм бэ? гэж тэр асуув.

- Уэйн гүнтэнд зориулсан жүржнүүдийг гэж түрүүнд нь явсан ачаа зөөгч хариулав.

- Жүрж ээ! гэж Цо Цу уулга алдав.

- Гүнтэнд ямар сайхан байх бол oo! Харин очижүүхэн та нарт ямар хүнд байгаа бол! Замын багахан хэсэгт та нарт туслахыг зөвшөөрнө үү. Ингэж хэлээл түрүүнд нь явсан зөөгчийн сагсыг авч өргөн өөрийнхөө нуруун дээр тавилаа. Тэрээр хагас бээр хэртэй яваад түүнийгээ эхний зөөгчид буцаан өгч хоёр дахь хүний ачааг авав. Энэ мэтчилэнгээр цувааны дагуу явж байлаа. Одоо зөөгч бүр ачаагаа буцааж авахдаа урьл өмнөхөөсөө хөнгөрсөн байхыг мэдсэн ба амарснаас ийм юм болсон гэж эсвэл ямар нэгэн ид шидээр Таогийн шашинтан өөртөө ашиг гаргав уу гэж гайхацааж байв. Цо Цут цувааны төгсгөлд ирээд буцаж

явах болоход тэд гүнтний ордонд хүрсэн байсан бөгөөд агуулахад нь жүржнүүдээ хүргэж өгөв.

Нэг хоёр хоногийн дараа зочилж буй язгууртнуудал зориулж жижиг цайиллага хийв. Бүх тансаг идээ будаа бүхий тавагнуудыг тарааж өгөхдөө үйлчлэгч нар шүүслэг алтан жимс бүхий мөнгөн царуудыг авч ирсэн ба гүнтэн зочиддоо хандан, “Нөхөд өө, энэ бол ховорхон амттан, өмнө зүтгээс авч ирсэн шинэхэн чихэрлэг амтат жүржнүүд билээ” гэв.

Гэрэлтсэн алтан жимснүүдийг хараад зочдын шүлс ч астарч байв. Харин эхний зочин мөнгөн хуттаар зустэл цочирдон алмайрав. Нөгөө хорхой хүрэм хальсны дотор талд хоосон агаараас өөр юу ч байсангүй. Тэрээр инээмсэглэн буй гүнтний өөдөөс сэжиглэнгүй харж ямар гэгчийн хорон санаа, доромжлолыг муу ёрлож байгаа бол хэмээн айн гайхаж байлаа. Санаандгүй хийсэн зүйлийнхээ талаар өөрийнхөө хажууд байгаа хүнийг хараад мөн ийм маягтай байгааг анзаарав.

- Хариуцагч нар аа, үүнийг гэрчилгээ! хэмээн гүнтэн ширээн дээр байгаа бүх мөнгөн аяга тавгийг харшилдуулсан дуугаар хүнгэнэв.

- Зохион байгуулагч аа!

Гүнтэн зохион байгуулагч болон түүний хариуцагч нарыг хараан зүхэж, зохион байгуулагч нь агуулахын даамлыг болон түүний хариуцагч нарыг харааж, агуулахын даамал зөөгч нарын ахлагчийг хайж түүний хариуцагч нарыг хараан зүхэв. Ирүүлсэн бүхэл бүтэн ачааны жүрж нь бүгдээрээ юу ч үгүй хоосон хальс байв.

За яахав мэдээж хэрэг, Цо Цүхэсэг хугацаанд өргөж явсны дараагаар ачаа нь хөнгөрсон талаар тайлбарлаж болох юм гэж зөөгч нарын ахлагч ойлгоод агуулахын даамалд, даамал зохион байгуулагчид, зохион байгуулагч гүнтэнд энэ бүхнийг Цо Цүхийсэн гэж хэлэв. Ингээд ердөө ч цаг алдалгүйгээр гүн Цо Цут баривчлан, улсын шоронгийн жижигхэн өрөөнд шидэж орхив.

- Тэр миний мөнгөөр хангалттай идэж уусан түүнийг цаашид тэээгээд байх шаардлага байхгүй гэж гүнтэн хэлэв.

Ингээд Цо Цут доройтуулан туйлдуулж үхүүлэхээр болсон ба гүн түүний талаар бүхнийг маргав. Ингээд нэг жилийн дараа урьл нь ирж байсан зочдын идэг нь түүн дээр дахин ирж, нөгөө Таогийн шашиналтанд ямар ял тулгасан талаар асуухад тэр сая нөгөө хэргийн талаар саналаа.

- Нээрээ түүний бисийг гаргаж хаяж шатаах цаг нь болсон хэмээн гүнтэн хэллээ. Ингээд тэрээр тушаал өгч, үүнийгээ хийлгүүлэхээр болов.

Гэвч тэд торыг өргөж шоронгийн өрөөний хаалгыг онгойлгоход Цо

Цутийн нүд нь бясалгаль автан, харин ч урьд өмнө байгаагүйгээрээ улаа бутарсан царайтай, баттай мариалсан харагдав.

Тэд арайхийн зориг гарган гүнтэнд мэдээлэв. Гэхдээ тэр юманд учиртай ханддаг хүн байсан бөгөөд энэ нь түүний шийтгэсэн энгийн биш гэмт хэрэгтэн байсан гэдгийг ойлгов. Тэрээр Цо Цуг суллах тушаал өгөөд түүнийг хоолонд урив. Хоолны дараагаар Цо Цу алсад явах гэж байгаагаа мэдэгдээд гүнтэнтэй хамт аяга тагш юм ухаар санал болгов. Тэр аяга дарс аваад, сээрэв авчрахыг хүсэв. Сэрээгээрээ дарсны голд хөндлөн зураас татахад дарс тэг дундуураа хуваагдан, тусдаа хоёр хэсэг боллоо. Цо Цу өөрийнхөө хэсгийг уугаад, нэг тал нь дарсаар дүүрэн байгаа аягатайгаа гүнд өгөв. Гэтэл гүнтэн энэ нь хортой зүйл байж магадгүй гэж бодоол уусангүй. Тэгэхэд нь Цо Цу баясталантайгаар тэр хэсэг дарсыг уугаад хоосон хундагыг дээш шидэв. Хундага тэр даруйдаа унасангүй. Харин шувуу шиг дээш дүүлэн, өрөөний таазнаас доохнуур агаарт тогтох байлаа. Хүн болгон гайхан харж байв. Тэднийг эргэн доош харахад Цо Цу алга болсон байв.

Үэйн хүмүүсийн дунд энэхүү гайхамшигийн талаар тархаж эхэлсэн ба гүнтэн шинэ гай барцал гарах талаар бодож, сэтгэл нь таагүй байв. Тэрээр Цо Цуг суллаж, өршөөсөндөө харамсаж байсан ба түүнийг дахин баривчилж авахыг тушаалаа. Цэргүүд түүнийг хөдөө гадаа, хаа сайгүй эрж байлаа. Ингээд толгодын хажуу тал дээр хэсэг цэрэг түүнтэй тулгарав. Тэд нарыг ирж явахыг хараад Цо толгодын орой уруу гүйж одов. Яг түүний дэргэд хонин сүрэг бэлчиж байлаа. Цэргүүд түүнийг гүйж байгааг хараад хөөж эхлэв. Гэтэл гэнэт Таогийн шашинтан харагдахгүй болсон байв.

- Агаарт алга болчихлоо гэж цэргүүдийн ахлагч гутрангүй өгүүлэв. Уруулаа цорвойлгон багшран буй хонийг ажиглан хартал түүнд урам зорж орж ирэв. Сүргийн хоньчин наранд зүүрмэглэн хэвтэж байгаа чулуу уруу хүрч очин ахлагчийг түүн үрүү хандахад тэр хүн босч ирэв.

- Танай сүрэгт хэчинэн хонь байдаг вэ?
- Жаран ес, эрхэм ээ.
- Чи итгэлтэй байна уу? гэж ахмад асуув.
- Итгэлтэй юу гэж үү? Мэдээж би итгэлтэй байлгүй яахав. Эзэн нүдэл, сэгсгэр, цагираган эвэрт, хавтгай хамарт... байна.
- Би бүх сүргийг чинь мэдэх гээгүй гэж ахмад хашиграв.
- Харин бил хонь чинь жаран ес үү, дал байна уу? гэдгийг мэдэх гэсэн юм гэв.

Ингээд тэрээр өөрийнхөө хүмүүсийг хонин сүргийг тоол гэж тушаав.

Харамсалтай нь хонь тоологдохоор зогсож өгөхгүй буюу бөөгнөрч өгөхгүй байв. Цөхрөнгөө барсан тэр хагарсан тарвас мэт марсайтлаа инээн, харж байсан хоньчин уруу гүйж ирэв. Хоньчин сүрэг үрүүгээ ганцхан хараад л гайхлаа.

- Та үнэн хэлжээ, ахмад аа гэж тэр хэлэв.
 - Далан хонь байна урилгагүй ирсэн этгээд чинь хэн сэн билээ?
 - Хэн гэдгийг нь би маш сайн мэдэж байна гэж ахмад хэлэв. Тэр эргэж сүрэг үрүү хандаад,
 - Ноён Таогийн шашинтан би таныг над дээр хурч ир гэж тушааж байна. Миний эзэн гүнтэн таныг уттан авахаар хүлээж байна хэмээн тэр хэлэв.
- Сүргийн дунд нэгэн хонь өвсөн дээр сөхрөн,
- Би үнэхээр энэнд чинь итгэж болох юм уу? гэж майлж байв.
- Цэргүүд:
- Тэр энд байна гэж хэлэв. Тэд яг түүний араас очих гэтэл сүргийн хонь бүр доош сөхөрч,
 - Би үнэхээр энэнд чинь итгэж болох юм уу? гэж майлалдав.
- Бүх сүргийг барихыг хүсээгүйгээс тэр Цо Цуг аль нь вэ гэдэгт итгэлтэй байгаагүй учир даалгавраа аргагүйн эрхэнд биселүүлж чадаагүй бөгөөд цэргүүдээ аван буцаж явлаа.



Илжигний дэн буудал

Чао гэдэг нэртэй улс даяар аялсан нэгэн худалдаачин байдаг байв. Тэр хаана хамгийн сайн дэн буудал байдгийг мэддэг байлаа. Гэвч нэгэн өдөр зүүн нийслэл үрүү танил биш замаар явж байгаад шинэ газар ирэв. Шөнө болж байсан учраас талбай дээр байгаа хэсэг тариачдаас ойролцоо сайн дэн буудал байдаг эсэхийг асуув.

- Үүгээр явсан аялагчид толгодын цаанаа байгаа “Модон гүүрний дэн буудал”-д байнга буудалладаг. Бас тэд тэндээс илжиг худалдаж авдаг юм гэж түүнд хэлж өгөв.

- Намайг авч явдаг энэ эртний амьтан хөгширч байна. Би түүнийг худалдаал шинийг авч болох л юм. Тэдэнд сайн илжиг байдаг уу? гэж Чao асуув.

- Мужийн хамгийн сайн илжигнүүд. Тэр дэн буудлыг Гуравдагч хатагтай гэдэг нэртэй нэгэн бэлэвсэн эмэгтэй эрхэлдэг. Тэр маш баян болохоор санаа зоволгүйгээр илжигнүүдээ байнга маш хямдхан худалддаг гэсэн хариу сонсгодов.

- Түүний илжигнүүд хаанахын юм бол? гэж Чao асуулаа. Тариачид дүлгэнэсэн царайтай харагдав.

- Одоо бид танд түүнийг хэлж чадахгүй нь. Түүнээс асуугаарай. Харин бид мэдэхгүй гэж тэд хэллээ.

Тэд нарын өөрсдийнх нь аж ахуйгаас бээрээс холгуй зайдтай орших газарт юу болж байгааг хөдөөний хүмүүс бага мэдэх буюу санаа бага тавыж байдгийг ойлгосон Чao толгоодор даван өөрийнхөө аяллыг үргэлжлүүлэв. Зааж өгсний дагуу цэвэрхэн бөгөөд цэгитгэй, сэтгэл татсан нэгэн дэн буудалд ирэв. Гаднаа цэцэглэж буй бут соөгнүүдийн дунд аятайхан харагдах сандлууд, мөн “Модон гүүрний дэн буудал” гэж зарлан тунхагласан том самбартай байв. Унаж ирсэн илжигнээсээ

буугаад дотогш оров. Гуравдагч хатагтай зургаа юм уу, долоон зочныг дарсаар дайлж байв.

Гуравдагч хатагтай аятайхан, жавхаалаг гуч орчим насны эмэгтэй байлаа. Тэрээр түүнийг эзлдгээр уттан авч,

- Таныгунаж ирсэн илжгээ болон ачааныхаа илжгийг арын жүчээнд хийж санаа тавих байх гэж бодож байна. Уучлаарай би тэднийг харж хандаж байх агтачгүй хүн. Мөн надад ямар ч үйлчлэгч зарц нар байдаггүй гэж хэлэв.

Чао илжигнуудээ жүчээ үрүү хотолж явахдаа, “Хэрвээ түүнийг зарц нартаа төлөх мөнгөгүй баян хүн гэх юм бол гайхах юм алга. Гэтэл бүгдийг өөрөө хийдэг үүн шиг дэгжин дэн буултыг авч явдаг ямар чадвартай эмэгтэй байдаг билээ энэ чинь. Хэн нэгэн хүн түүнийг эхнэрээ болгож авдаггүй нь л зөвхөн гайхал төрүүлж байна. Гэхдээ тэр дахин гэрлэхээс татгалздаг үнэнч бэлэвсэн эхнэрүүдийн нэг байж болох юм” гэж өөртөө хэлэв.

Чао түүний адилар аялж буй худалдаачид болох нөгөө зочилтой нийлж суув. Яг энэ үед тахианы хэрчсэн зөвлөхөн мах, голоос барьсан шинэхэн загас, хамгийн сайн цагаан будаа бүхий сайхан хоолоор үйлчилж байлаа. Дараа нь бэлэвсэн эмэгтэй аяга тавгаа угааж, зочид түүний ширээн дээр тавьсан савтай дарснаас уушгаан цагийг өнгөрүүлж байв. Чао чихэрлэг махыг амтархан зажилж, бусадтай үүх түүх ярилшан байлаа. Тэрээр архи уудаггүй хүн байсан учраас дарсанд хүрсэнгүй.

Удалгүй унтаж амрах цаг болов. Гэрэл унтарч хөлчүүрхсэн зочид тэр даруйдаа унтацаагаа. Чаод Гуравдагч хатагтайн өөрийных нь өөрөөг тусгаарласан хүлс, зэгсэн хананы хажуугийн цэвэрхэн тухтай орыг өгсөн байлаа. Тэрээр бэлэвсэн эхнэрийн онцгой чадварыг эргэлзэнгүй бодон зүүрмэглэн хэвтэж байв. Нөгөөх зочдын зөвлөн хурхиран түүнээс алгуурхан холдож байтал түүнийг гэнэт хүчтэй чимээ цочоон сэрээв. Тэр хүчтэй дуу чимээ нь ямар нэгэн хүнд юм газар дээгүүр явж буй мэт нийжигнэсэн дуу чимээ байлаа. Тэр нь бэлэвсэн эхнэрийн унтаж байгаа тэр өрөөнөөс гарч байв.

Чао эхлээл хулгайч нар орж ирээд түүнд гэм хор учруулж байна гэж бодов. Чимээгүйхэн босч хулсан хананд нэвт харж болох нэгэн завсар байхыг олж үзэв. Тэрээр бэлэвсэн эхнэр ганцаараа байхыг хараад санаа нь амрав. Нөгөө чимээ өрөөний дундуур тэр эмэгтэйн чирч яваа хүнд хайрцагнаас гарсан байлаа. Эмэгтэй өвдэглөн суусан харагдав. Хайрцагнаас бэлэвсэн эмэгтэй алгын чинээ жижигхэн модон хүнийг гаргаж ирж байв. Түүнийгээ өрөөний шалан дээр тавив. Энэ үед Чао

жигтэйхэн сониучирхан ажиглалтаа үргэлжлүүлж байлаа. Дараа нь эмэгтэй хайрцагнаас модон шар, мөн анжис гаргаж ирэв. Тэд мөн л жижигхэн модон хүмүүсийн адил хэмжээтэй байв.

Гуравдагч хатагтай шарыг өчүүхэн жижиг анжсанд хөллөсөн ба ногөө жижигхэн хүнийг ард нь суулгав. Дараа нь эмэгтэй түүн дээгүүр ус цацлаа. Чаогийн гайхшран харж байхад жижигхэн хүн хөдөлж эхэлсэн бөгөөд цаг алдалгүй өрөөний шалтыг анжсаар цэвэрхэн хагалав. Одоо Гуравдагч хатагтай үргэлжлүүлж сагсыг жижигхэн модон хүний гарти нь бариулахад хагалсан талбай дээр үр суулгаж эхэллээ. Үр хөрсөнд хүрмэгц буудай ногоорон соёоллоо. Одоо түрүү нь гүйцжээ тариа бэлэн болсон байна. Гуравдагч хатагтай өөрийнхөө үр тариаг хурааж аваад өрөөнийхөө буланд өвдөглөн суугаад, тариан түрүүг цайруулж, шигшиж, нунтаглаад гурил болгож байв. Гурилаараа бялуу бэлдээд зуухандаа хийж жигнэв. Ажлаа гүйцэтгэж дуусгасныхаа дараа тайван гэгч нь орондоо орж унтлаа. Чao ч мөн тусгаарласан хананы цаана өөрийнхөө хэсэгт очиж унтжээ.

Өглөө болоход зочид босч мөн угаажарчин, өглөөнийхөө цайгуухаар цугларцгаав. Цайн дээр буудайгаар хийсэн шинэхэн бялуу илэцгээлээ. Харин Чаотүүндөгсөн хэсгийг идэх болдоггүй байсан учраас ханцуйндаа түүнийг нуугаад өрөөнөөс гарав. Харсан зүйлсээ бодоод түүний сэтгэл тавгүй байлаа. Тэрээр илжигнүүдээ жүчээнээс авчирч явахаар бэлтгэв. Явахынхаа өмнө өглөөнийхөө ундыг ууж байгаа бусад зочдыг цонхиоор сэм харав. Түүнийг харсаар байтал тэд дараалан сандал дээрээсээ гэнэт нуран унаж шалан дээр өнхөрч харагдав. Тэдний хувцас нь арзгар үс болон хувирч, сүүл болон урт үстэй чих гарч ирж, удалгүй дэн буудал орилолдон буй илжигнүүдээр дүүрлээ. Гуравдагч хатагтай саваа мод барин орж ирээд тэднийг арын жүчээ үрүү туун оруулав.

Чao өөрийнхөө амьтдыг хурдан шогшуулж, яаравчлуулан тэр газраас холдлов. Тэрээр зүүн нийслэлийг хүрээл юу тохиолдсон талаар хэнд ч үг цухуйлгасангүй. Харин ажил хэргээ зохицуулаад гэр лүүгээ буцах бэлтгэлээ хийв. Түүний бэлтгэсэн зүйлийн нэг нь Гуравдагч хатагтайн хийсэн буудайн бялуутай ижил хэмжээ, хэлбэртэй буудайн бялуунуудыг худалдаж авах явдал байсан бөгөөд тэдгээртэй цут ногөө “Модон гүүрний дэн буудал”-д өглөөний цайнаас авч үлдсэн бялуугаа цут хийв.

Тэр гэр лүүгээ харих замдаа дахиал ногөө дэн буудалд буудаллалаа. Энэ удаад тэрээр цорын ганц зочин нь байлаа. Гуравдагч хатагтай урьдын адил түүнийг зэлдэгээр утгаж, сайхан хоол хийж өгөв. Дараа

нь тэд хоёулхнаа дэн буудалд байсан учир эмэгтэй түүнтэй цуг сууж ярилцав. Гэвч дарсаа тэрээр Чаод уулгаж чадсангүй.

Цаг явахын хэрээр тэд амарч унтахаар болов. Түүний хүлээж байсанчлан нөгөө хайрцгийг чирч нээх дуу гарах хүргэл Чао орон дээрээ хэвтэлгүй байлаа. Энэ удаад тэрээр инээмсэглэн буруу харан унтахаар хэвтэв. Өглөө нөгөө бэлэвсэн эхнэр түүнд өглөөнийн ундан дээр цай, буудайн бялуу авчирч өгөв. Харин Чао өөрөө авчирсан бялуунуудаа аль хэдийн ширээн дээр тавьсан байсан ба эмэгтэйд:

- Би эд нарыг зүүн нийслэлээс худалдаж авчирсан. Тэд оншгой сайн. Та нэгийг идэж үзэхгүй гэж үү? Тэгвэл та өөрийнхөө хийсэн бялуунуудыг өнөө орой ирэх зочиддоо хадгалж болно шүү дээ гэж хэлэв.

Гуравдагч хатагтай бага зэрэг сэтгэл гонсгор байсан ч татгалзсангүй. Чао энэ агшинд зориулж найдвартай хадгалсан өөрийнх нь хийсэн нөгөө нэг бялуут түүнд өгөв. Тэрээр өөрийнхөө хийснийг гэж танилгүй түүнд талархаад идэж эхлэв. Удалгүй гурваас дөрөв хазсаны дараа тэр шалан дээр өнхөрч илжиг болж хувирлаа.

Өөрийнхөө хийсэн зүйлийг амжилттай болсонд баярласан Чао илжигний хөл үрүү нь өшиглөж босгон шалгав. Тэр том, хүчтэй, мөн дуулгавартай царайтай амьтан байлаа. Тэрээр түүнийг унахаар болов. Нуруун дээр нь гарч унахынхаа өмнө Чао Гуравдагч хатагтай хайрцгийг онгичиж жижигхэн модон хүүхэлдэйнүүдийг гаргав. Тэрээр багийг хөллөөд, усаар шүршив. Гэсэн хэдий ч ажиллуулж чадсангүй. Тиймээс тэднийг дахин хортой үр тариагаа баталгаатай тарихааргүй болгохын тулд шатааж орхив.

Чаогийн шинэ илжиг дөрвөн жилийн туршид түүнд гойд сайн үйлчилсэн билээ. Нэг өдөр тэрээр Чанган хотын гудамжаар явж байв. Түүний өөдөөс явсан нэгэн настай хүн түүнийг зогсоогоод илжгийг нь шинжин харлаа. Дараа нь тэрээр алгаа ташиж баяр хөөр болон хашиграад,

- Нөгөө “Модон гүүрний дэн буудал”-ын бэлэвсэн эхнэр Гуравдагч хатагтай яг мөн байна. Тийм үү? Би чамайг сайн байгааг чинь харж байгаад маш их баяртай байна. Харин чи хэрхэн хувирав?

Дараа нь нөгөө настай хүн худалдаачин Чао уруу хандаж,

- Тэр маш их хор хөнөөл учруулсан билээ. Түүнийг урхиндаа оруулахын тулд таны хийсэн арга замын чинь төлөө би танд баяр хүргэх ёстой. Харин та түүнийг өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд унаж, зодож, ханталттай шийтгэжээ. Одоо түүнийг тавьж явуулна уу

ГЭЛЭЭ.

Чао илжигнээс буув. Настай хүн ханцуйнаасаа нэгэн хутга гаргаж ирээд илжигний хэвллийн тус газарыг нь зүстэл дотроос нь нөгөө “Модон гүүрний дэн буудал”-ын бэлэвсэн эхнэр үсрэн гарч ирэв. Тэр нүүрээ гараараа таглан гүйн одлоо. Харин худалдаачин Чао Гуравдагч хатагтайг хэзээ ч дахин хараагүй, түүний талаар сонсоогүй билээ.



Аюулт байшин

Их сургуулиуд бий болохос өмнө оюутнууд эрдэм мэдлэг олохын тулд пийпаа хөгжим, сэлмээ барин Хягадын уудам эзэнт гүрнийг хөндлөн гулд туулж хэсүүчилдэг байлаа. Ташаандaa сэлэм агсаж, номтой богц үүрсэн залуу хүн хажуугийн замаар нь онтөрөхийг харсан далангаа засч буй тариачин төдийлөн гайхдагтүй байв. Магадгүй нэгэн хүү хойноос нь пийпааг нь барид явж байж ч магад, учир нь эзнийх нь хичээлд хөгжим нэлээд чухал зүйл билээ. Эсвэл зарц хөлслөх боломжгүй ядуу оюутан өөрөө ачаагаа барид явж байж ч магадгүй, хөгжмөөс өөр ачаа ихгүй белгэе. Тэрхүү оюутан эртний нэгэн дайны талбар, эсвэл нэгэн яруу найрагчийн даянчлан сууж байсан газрыг зорин явж буй нь тэр байж мэдэх юм.

Яг ийм нэгэн залуу оюутан Аньянаны өмнөд хязгаарыг зорин тоост замыг туulan явж байжээ. Гэгээ тасарч эхэлсэн тул тэрээр шөнийг өнгөрөөчихмөөр дэн буудал, эс бөгөөс сүм хийд олоход хамаг анхаарлаа хандуулав. Тэр яваас тариачдын боогнорсон уршиунд дээр ирлээ. Нэгнийх нь гадаа өндөр настай эмэгтэй даавуу давхарлан нааж гутлын ул хийж сууна.

- Эх минь, энэ хавьд ганц хоночихмоор дэн буудал байхгүй биз? хэмээн тэр найрсаар асуулаа.

- Арван Милийн Дэн Буудлаас наана юм байхгүй дээ гэсэн хариу өгөв.

- Тэр нь хэр хол вэ?

- Аньянанаас арван миль, энэ замыг дагаад явбал зургаан миль.

Оюутан урд нь сунах замыг харлаа. Дэн буудал уруу очсоор байтал харанхуй болчихно, тэгээд ч зургаан миль тоост замыг дахин туулна гэдэг бол таатай сонголт биш. Харин урагшaa харан зогсохдоо замын зүүн талд, нэг сүм харвалтын зайд аялагчдал зориулсан амралтын

байр шиг байшин байхыг олж харлаа. Байшин хэдийгээр хэмхэрсэн, урт удаан хугацаанд ашиглагдаагүй мэт байсан боловч хүйтэн шөнө нөмөр болмоор харагдсан тул оюутан цаашаа явснаас тэнд хонөө хэмээн эмэгтэйд хэлэв. Гэтэл эмэгтэйн нүдэнд айдас тодрохыг хараад ихэд гайхлаа. Тэрээр харшаа буруулан, гэрээс нь гарч ирсэн охин нь гэмээр залуу эмэгтэй үрүү аврал эрэх мэт харна. Энэ хооронд тариан талбайгаас эрчүүд буцаж ирэн, тагдгар нэг нь ойртож ирээд оюутан уруу тоомжиргүй харснаа юу болж байгааг асуув.

- Залуу ноёнтон байшинд буудаллана гэнэ ээ.

- Чи тэнд унтаж болохгүй гэж тэр эр ширүүн хэлэв.

Оюутан ийм будүүлэг харьцаанд ундуушан байшинд хонохгүй байхыг тушаах тэр хэн юм бэ? гэв.

- Тэнд хэн ч унтдагтүй юм гэж эр хэлэв. Оюутан дахин асууж, уур нь дүрэлзэж сурхий маргаан дэгдэх гэж байтал эмэгтэй гарaa өргөн болиулав. Тэр хоёр тийшээ айсан байдалтай харан байж сөөнгө хоолойгоор хэтгэрий чанга гэмээр шивгэнэлээ.

- Гурван жил дараалан гурван хүн тэр байшинд хоносон юм. Нэг нь ч өглөөг үзээгүй юм гэлээ.

- Тиймэрхүү алуурчдын тухай яриануудыг... оюутан ярьж эхэлтэл,

- Алуурчид биш ээ. Хүн ердөөсөө биш гэж тэр эм гуаглах мэт дуугарав.

Хөгшин эмэгтэйчүүдийн яриаг сонсоод инээх хэрэггүй гэдгийг тэр мэддэг хэдий ч айлгүй, итгэлтэйгээр тэр яриаг нь таслан хариулав.

- Тэгвэл тэр сүнснүүд байсан бол тэдний цугларах цаг байж. За явья, танай оройн хоолыг хуваалцахыг минь зөвшөөрнө үү, дараа нь би та нарт төвөг удахгүй.

Бүгд амандаа бүвтнан, толгой сэгсэрч байсан боловч оройн хоолон дээр маргаан дахин үүсэлгүй өнгөрлөө. Хоол илэж дууссаны дараа оюутан хэдэн зоос эмэгтэйд өгөн, ачаагаа авч гэр бүлд тавтай сайхан амрахыг хүсэв. Хэн ч хариу дуугарсангүй, бүгд л хүнд уур амьсгалтай үдлээ.

Байшиинг тойруулж барьсан хашлагын будаг нь хуурсан, чулуун шатны завсродаар нь хогийн ургамал ургасан байна. Дотроо тас харанхуй, бүх юм нь өгөршсөндөө хөгц үнэртэнэ. Оюутан богцноосоо дэнлүү, номоо гаргав. Дэнлүүгээ асаан, хиртэй олбогоор бүтээсэн тавцангийн өнцөг дээр суугаад номоо уншиж эхлэв.

Хэдэн цаг өнгөрлөө. Ядарч байсан боловч тэр анхаарлаа номондоо төвлөрүүлсэн хэвээр байлаа. Дээврийн ваарыг сүлхан тарчигнуулах

салхинаас өөр чимээ үл сонстоно.

Тэгж байтал гадаах зам дээр хэн нэгэн алхах чимээ гарлаа. Оюутан сууж байгаа газраасаа сараалжийн завсраар байшин уруу ойртох зам одлын гэрэлд бүдэг бадаг гэрэлтэхийт харж байв. Зам дээр бүхлээрээ хар хувцастай хүн ирж зогслоо. Бүдүүн хоолойгоор байшингийн эзэнг дуудав. Оюутны сууж байгаа өрөөн дотроос хоёр дахь хоолой:

- Энд байна! хэмээн хариулав.
- Байшинд хэн байна вэ? гэж хар хувцастай хүн асуув.
- Оюутан гэж эзэн хариулаад,

Тэр ном уншиж байна, арай унтаагүй байна гэжээ.

Хар хувцастай хүн буцаж эргээд цааш одохыг оюутан хараад номоо үргэлжлүүлэн уншилаа. Төд удалгүй дахин хэн нэгэн алхах чимээ сонсогдов. Улаан бүрх малгайтай хүн байшингийн урд ирж зогсоод эзнийг дуудлаа.

- Энд байна! хэмээн нөгөө л хоолой оюутны байгаа өрөөнөөс хариулав.

- Байшинд хэн байна вэ? гэж улаан бүрх малгайтай хүн асуув.
- Оюутан гэж эзэн хариулаад,
- Тэр ном уншиж байна, арай унтаагүй байна гэжээ.

Өөр яриа өрнөсөнгүй, улаан бүрх малгайтай хүн мөн л буцаад одов. Оюутан дахин чимээ чагнатаал хэн ч нэмж ирсэнгүй. Тиймээс тэр босон гарч өөрөө зам дээр зогсов. Тэрээр хар хувцастай, улаан бүрх малгайтай хүмүүстэй адиллаар байшингийн эзнийг дуудав.

- Энд байна! хэмээн эзэн хариулав.

- Байшинд хэн байна вэ? хэмээн оюутан асуулаа.
- Оюутан гэж эзэн хариулаад, тэр ном уншиж байна, арай унтаагүй байна гэв.

- Хар хувцастай хүн хэн бэ?
- Тэр бол хойд зүгийн хар гахай байсан.
- Улаан бүрх малгайтай хүн хэн бэ?
- Тэр бол баруун зүтийн улаан азарган тахиа байсан.
- Чи өөрөө хэн бэ?
- Би Хөгшин хилэнц байна.

Оюутан хүссэнээ мэдэв. Тэр дэнлүү ном уруугаа буцаж ирэн шөнийн үлдсэн хугацааг номоо уншиж өнгөрөөв. Дахиж түүнд хэн ч саад болсонгүй.

Гадаа үүр цайж эхэлмэгц өчигдрийн тагдгар тариачин эр бүдүүн саваа барин зам даган яаравчлан ирж харагдав. Байшингийн дэргэд

иэрээд хурдаа сааруулав. Тэр шатаар болгоомжтой гаран яйжийсан хаалгыг түлхэн онгойлголоо. Оюутан тавцангийн өнцөг дээр бүтэн бүлээн, номоо амтархан уншиж суугааг хараад түүний айdas баяр хөөр, гайхлаар солигдов. Тариачин түүний мөрөн дээгүүр гарaa тавин ёслол төгөлдөр гэр лүүтээ оглооний цайн дээр аваачих гэлээ. Гэвч оюутан

- Эхлээд гэр бүл, хөршүүдээ дууд гэв.

Бүгд цутларсны дараагаар оюутан нөгөө байшин уруу бүгдийг нь дагуулж очин эрэл хайгуул хийлгэв. Тэд ялзарч өгөршсөн халхавчийг авч хаян цаанаас нь хэдэн футурт хаттууртай бомбөр шиг том хилэнцийг оллоо. Хортой хаттуур нь оюутныг онилсон боловч тэр сэлмээ гарган бэлдсэн байсан бөгөөд ганц шаламгай цохилтоор хаттуурын үзүүрийг тасдаж, толгойг бисенээс нь салтал цавчиж орхив. Хүмүүсийн санаа уужран уулга алдав. Оюутан тэдэн үрүү эргэн харж,

- Та нар Хар гахайгаа хаана байлгадаг вэ? гэж асуув.

- Байшингийн хойд талын саравчинд гэсэн хариу авлаа. Тэд түүнийг хэлсэн газар луугаа дагуулж очтол тэнд урьд өмнө харж байгаагүй том хар гахай байж байна. Түүнийг ойртоход гахай толгойгоо өндийлгэж, нүдэнд нь буг чөтгөрийн гал асч байгаа нь андашгүй байв. Оюутны сэлэм дахин гялсхийж, хар гахайн толгой гайхсан хүмүүсийн хөл үрүү өнхөрлөө.

- Улаан азарган тахиагаа та нар хаана байлгадаг вэ? гэж тэр асуув.

- Байшингийн баруун талын саравчинд гэсэн хариу авлаа. Тэд түүнийг хэлсэн газар луугаа дагуулж очтол тэнд аварга том улаан залаатай, аймшигт савартай азарган тахиа байж байв. Гурав дахь удаагаа оюутны сэлэм гялсхийн дараагаар сэлмээ цэвэрлэн, хуйнд нь хийж ташаандаа зүүлээ.

Түүнээс хойш Аньяаны өмнөд хэсэгт байдаг байшинд нэг ч аянчны амар тайван байдал алдагдаагүй гэнэ.



Борооны эзэд

Эгэл хүмүүс бил ямар ч цаг агаар байсан эвлэрэхээс өөр арга байдаггүй нь хорвоогийн жам билээ. Мөн ямар цаг агаар тогтохыг эртнээс мэдэн сээрэмжлэх боломж ч байдаггүй. Гэвч тэртээ нэг цагт эгэл хүн борооны эздийг ажлаа хийж байхтай нь тааралдаж, бас нэг хүн тэдэнд тусалж хүртэл үзсэн гэнэ. Гэвч үр дүн нь бүгд сайн сайхан байгаагүй ажээ.

Тэр нь тариачин Ли Юнд тохиосон завшаан байсан ба тэр улаан буудайн ургацаа аварч чадсан гэдэг. Тэр албан даалгавраар нэлээд зйтай хот уруу явах үед болсон явдал ажээ. Буцах замдаа тэр нэгэн хуучин хийдэд ганцаараа хоножээ. Шөнө дунд хийдийн зузаан хаалгыг хэн нэгэн чангаар балбах чимээнээр тэр сэрлээ.

- Хаалгаа онгойлго! Аянганы тэргийг эзэлдэхээр бил ирлээ гэж гадаа хэн нэг хашигирав.

- Хэн авах гэсэн юм бэ? гэх хариу хийд дотроос сонстов.

- Чие-сиугийн хаан.

Чие-сиу гэдэг нь Ли Юнгийн тарианы талбай байдаг газрын нэр тул тэр цаашаа юу болохыг улам анхааралтай чагнаж эхлэв.

- Тэр түүгээр яах гэсэн юм бол? гэж нөгөө дуу хийд дотроос асуулаа.

- Улаан буудайн ургацанд хэрэглэх гэсэн юм гэж гаднаас хариулав.

Удаан хутацаанд чимээ аниргүй болох хооронд Ли Юн өөрийнх нь улаан буудайн ургаа аюулд нэрвэгдэх нь байна гэж бодохоос айн дагжиж байв. Тэгснээ дотроос,

- Манай хаан тэргийг яг одоо хэрэглэж байна, түр хүлээх хэрэгтэй байна гэж хэлж байна гэв.

Энэ удаад илүү удаанаар чимээ анир тасрав. Тэгснээ гадаа нэгэн нийжигнэх чимээ гарлаа. Ли Юн гадагшaa цухуйн хартал тав зургаан

сүнс лаа барин том тэргийг Чие-сиүгийн элч үрүү түрж яваа харагдав. Цувааны сүүлд хэдэн хүн хурцаар гялалзах даршнуудыг нийлүүлж хийсэн аварга том тут барьж яваа харагдах юм. Тэд тугийг элчийн урд авчрахад тэр даргийг чанга дуугаар тоолов. Арван найман ширхэг байна. Сэтгэл ханамжтай толгой дохиод цувааг дагуулаад явчихлаа.

Чимээ тасрангуут нь Ли Юн шөнийн харанхуй уруу яaran гүйж арайхийж Чие-сиү хүрэх замыг олов. Хэдийгээр үүр цайгаагүй байсан ч тэр бүх хөршүүдийнхээ хаалтыг балбаж,

- Аянгын сүнснүүд бидний улаан буудайт хулгайлхаар ирж байна! Хурдан тариалангийн талбай уруугаа гарч ирцгээ! хэмээн хашхирч сэрээв.

Гэвч хөршүүд нь түүнийг шоолон инээлдэж ор луугаа орцгоочхов. Ли Юн талбай уруугаа гүйн гарч улайран ажиллахдаа ургашаа хурааж чадлаа. Ажлаа дуусах үед аль хэдийн өдөр болсон байв. Тэр эхнэр хүүхдээ дагуулан тосгон бүтнээрээ харагддаг өндөрлөг үрүү гаралаад тэнгэр лүү санаа зовнин харна. Гэтэл хэдхэн минутны дараа том утаа боогнорсон мэт үүл уулын цаанаас гарч ирлээ. Хэдхэн мөчийн дотор үүл тэнгэрийг бүрхчихэв. Аадар бороо цутгаж, цахилгаан цахиж, Ли Юн нийт арван найман удаа цахилгаан цахихыг харлаа.

Аадар бороо намдахад бүх ургац сүйрсэн байлаа. Чие-сиүгийн хүмүүс Ли Юнд уурлаж эхлэв. Түүнийг сээрэмжлүүлэн хэлэхэд өөрснөө үл тоомсорлон инээлдэж байснаа мартан, хөршүүдээ баллан өөрөө баяжих гэж чөтгөрүүдтэй орооцолдсон хэмээн цуу яриа гаргав. Уур нь дүрэлзээр түүнийг шүүхэд татлаа. Гэвч тэр болсон явдлыг шүүхэд нэгд нэгэнгүй ярж өгсөнд Ли Юнд борооны эздийн ажлаа хийж байгааг харах аз л тохиосон гэдгийг шүүх ойлгож түүнийг гэмгүй хэмээн суллав.

Нэгэн удаа бороо оруулахад тусалсан хүний нэрбас Ли байлаа, харин тэр бол ядуу тариачин биш, дайчин Ли Чин байсан бөгөөд сүүлдээ Вэй-ийн гүн болсон байна. Тэр залуу байсан тул ан хийх туйлын дуртай байжээ. Жил болгон тэрээр Лин уул уруу явж нэгэн хөндийд орших жижигхэн тосгонд буудалладаг байв. Тосгонд нэгэн настай хүн түүнд их сайн хандаж, найрсаар угтан авч зочилдог байсан ба жилээс жилд тэдний нохөрлөл бэжжих болов.

Өдөржингөө явсны эцэст тосгон уруугаа буцахаар завдаж байтал хажуугийнх нь дов дээр сайхан буга байхыг олж харав. Мориндоо ухасхийж мордон хөөн давхилаа. Тэр буга довны өндөрлөгийг даган салхи мэт хурдан зугтав. Ли Чингийн цус хөөрөн хойноос нь давхисан

боловч морь нь ядарч эхэлээ. Дов аажмаар ой модтой өргөн тал болон хувирав. Бутыг мод уруу орохоос нь өмнө гүйцэж чадалгүй алдчихлаа. Дов уруугаа гэгээтэй боловч ой модонд хэдийнээ харанхуй болсон байлаа. Ли Чин ой модноос гарах гэж явтал улам гүн үрүү нь шигдээд байгаагаа төл удалгүй ухаарлаа. Тэр яхын аргагүй төөрчихжээ.

Тэр мориноосоо буун эргэн тойрныг ажтал модны мөчруүдийн саарал сүнс харанхуйд хөдлөх мэт, анир чимээгүй байдлыг хааяа нэг шар шувуу эсвэл сармагчны гашуудах мэт дуу эвдэх аймшигтай газар байлаа. Тэр юуг олох гээд байгаагаа ч мэдэлгүй морио хөтөн явав.

Энэ алслагдсан ойд хүн амьдарч байна гэдэгт итгэхээргүй байлаа. Гэтэл ойн цоорхойд зөвлөн гэрэл харагдav. Тэр гэрлийг чиглэн ойн цоорхойгоор гарлаа. Харанхуйд шагаарах том хашлагаар хүрээлгэдсэн том байшин байж байх юм. Аварга том хаалга нь улаан өнгөтэй ба хүрэл дэнлүүний гэрэлд гялалзана. Ли Чин хаалгыг балбав. Хэн ч хариулахгүй удаж байгаад хаалга нээгдэж зарц гарч ирэв.

- Би дов хавиар ан хийж яваад энэ ойд төөрчихлөө. Намайг энд нэг хонуулаач гэж Ли Чин гүйв.

- Миний хоёр эзэн хоёулаа эзгүй байгаа. Ганц хөгшин эмэгтэй л байна. Тэр таныг энд хонохыг зөвшөөрөхгүй л болов уу.

- Миний хүндэтгэлийг түүнд илэрхийлээд хонож болох уу асуугаад өгөөч гэлээ. Зарц бушаж ирэн,

- Манай эзэгтэй эхлээд дургүй байсан боловч та төөрчихсон, харанхуй болчихсон учраас таныг хүлээж авах боллоо. Намайг дагаад явна уу.

Тэр Ли Чинг том танхим уруу дагуулж очин, тэнд нь шивэгчин бүсгүй эзэгтэй ирж байгааг зарлав. Эзэгтэй нь тавь эргэм настай, энгийн боловч дэгжин хувцасласан, язгууртан гаралтай гэдэг нь илт байлаа. Ли түүнд мэхийн ёсолж, эмэгтэй ч хариу мэндэллээ.

- Манай хүүхдүүд гэртээ байхгүй байхад би таныг зочилно гэдэг үнэхээр ёс бус хэрэг. Гэхдээ та харанхуйд энэ ойгоос өөрөө гарах замаа олж чадна гэж бодохгүй байна гэж тэр хэлэв. Тэгснээ,

- Манай хүүхдүүд удахгүй эргэж ирнэ. Ирэхдээ асар их чимээ гаргадаг тул та бүү сандраарай гэж нэмж хэлээд, түүнд хоол өгөхийг даалгав. Хоол тансаг сайхан байсан боловч ихэвчлэн төрөл бүрийн загаснаас бүрдэж байв. Дараа нь зарц нар дэр хөнжил авчирсан нь бүгд зөвлөн, цэвэрхэн, сайхан үнэртэй байлаа. Тэд энэ удаад гарч явахдаа хаалгыг нь гаднаас нь түгжив.

Хэдий их ядарч байсан ч Ли Чин хэвтэнгүүтээ унтаж чадсангүй. Энэ

алслагдсан ойн гүнд амьдарч буй эдгээр хүмүүс хэн болохыг гайхан бодлогошров. Яагаад хүүхдүүд нь их чимээ гаргадаг юм бол? Мөн энэ харанхуй шөнө хаанаас ирэх юм бол? Яагаад түнийг гаднаас нь түгжих болов? Бас нэг юм түүнийг их гайхшуулав! Яагаад тэд загаснаас өөр юм иддэггүй мэт байв?

Хaalга айхтар чангараар балбах чимээ гарахад тэр орон дээрээ суусан хэвээрээ байж байв.

Хашааны гаднаас архирсан хоолойгоор хэн нэг нь:

- Тэнгэрийн зарлигаар аллах эзэн долоон зуун милийн радиуст бороо аваач. Бороо үүр цайхад зогсож, алдаа болон хэрцгийлэл гарахгүй байх ёстой гэж хашхирав. Үүний дараа эзэгтэй:

- Би одоо яана аа? Хүүхдүүдийн минь хэн нь ч гэртээ байдагтүй, хойноос нь дуудья гэхэд цаг алга. Энэ даалгаврыг зарц нараас хэн нь ч биелүүлж чадахгүй, бороо оруулсангүй гээд би яллуулах нь дээ. Ээ, би яах вэ? Гэж хэлэх нь сонсгодов. Дараагаар нь зарц:

- Зочноороот туслуулж болохгүй болуу? Энгийн хүнээс илүү чадалтай харагдсан шүү дээ гэж хэлэв.

Эзэгтэй ч энэ саналыг баяртай хүлээж авав. Тэр Ли Чингийн хаалгыг тогшоод,

- Ноёнтоон, та сэргүүн байна уу? Би тантай нэг юм ярих гэсэн юм гэж асуув.

Ли Чин босоод түүнтэй уулзахад эзэгтэй:

- Энэ бол эгэл хүмүүсийн гэр биш, луу нарын ордон юм. (Тэгээд л эд нар дан загас иддэг юм байна л даа гэж Ли Чин бодов) Луу бил бороо орууллаг гэдгийг та сайн мэдэх байх. Би бороо оруулах зарлиг саяхан авлаа. Гэтэл миний ууган хүү Дорнод Тэнгист хуриманд оролцож байгаа, бага хүү мааны эмэгтэй дүүгээ гэр лүү нь хүргэж өгч байгаа. Хоёулаа эндээс хэдэн мянган милийн цаана байгаа тул тэд цагтаа ирэх боломжгүй байна. Энэ яаралтай асуудал дээр та тусалж чадах сан болов уу? Уг нь их удаан биш л дээ гэж ярихад,

- Даанч би ердөө л эгэл хүн шүү дээ. Би морь муугүй уналаг боловч үүл унаж үзээгүй юм байна. Гэхдээ таны зочломтгой зангиж хариуд би тусалмаар байна. Та надад юу хийхийг заагаад өгвөл би хүчээ дайчлан хичээгээ гэлээ.

Тэд цоохор морь гаргаж ирэв. Эзэгтэй борооны савыг авчрахыг тушаав. Тэр сав нь жижигхэн байсанд Ли Чин гайхав. Эзэгтэй савыг эмээлд ганзагалж өгөв.

- Та миний хэлснээр хийвэл хэцүү юм байхгүй. Та жолоо, дөрөөг

оролдох шаардлагагүй. Зүгээр л моринд замыг нь даатгачих. Гэхдээ түүнийг зогсох болгонд нь савнаас нэг дусал бороо дэл үрүү нь дусах хэрэгтэй. Ганц дуслаас ихийг дусааж болохгүй шүү, маш болгоомжтой байгаарай гэж тэр хэлэв.

Ингээд Ли Чин моринд нь мордож даалгаврыг билүүлэхээр явлаа. Цоохор морь агаарт хөөрөн, улам өндөр лүү өгсөн давхив. Эхлээд тэр өнхөрч унахаасаа айн сандарсан боловч сүүл үрүүгээ морь чулуу мэт хатуужилтай болохыг ухаарав. Үүлэн дээгүүр давхиж байгаадаа итгэхэд бэрх байв, гэтэл үнэхээр л салхи сум шиг хажуугаар нь ислэрэн өнгөрч, доор нь цахилгаан цахиж, аянга ниргэж байв. Морь зогсон янцгаасанд Ли Чин зааврыг нь даган сав уруу хуруугаа дурж, нэг дуслыг цоохор мориныхоо дэл рүү дусаав. Энэ хэдэн удаа давтагдаж, хийх тутамд нь доорх үүл нь нээгдэж байлаа.

Тэгж байтал морь Ли Чингийн танил газар зогслоо. Тэр нь түүний ан хийхдээ очдог уулын тосгон байлаа.

“Энэ тосгоны хүмүүс надад их сайн хандсаар ирсэн” гэж тэр өөртөө хэлээд “Тэд намайг маш сайхан хүлээж авдаг, гэтэл би ачийг нь хариулах аргаа ер олоогүй яваа билээ. Сүүлийн хэдэн долоо хоног ган болж, тариа хатаж байгаа, харин би энд гартаа бороотой сууж байдаг. Би тэдний тариаг сайн услахаар ихээхэн шиг бороо явуулна аа” гэж шийдлээ.

Энэ удаал тэр нэг биш, хорин дусал бороо морины дэл үрүү дусаалаа. Энэ газар нь зогсох сүүлчийн газар байж таарав. Морь шууд ой доторх байшин уруу давхиж очихол эзэгтэй түүнийг хүлээж байлаа. Тэр нулимыс дуслуулж байсанд гайхав. Ли Чин мориноосоо буухад эзэгтэй түүн үрүү.

- Та яагаад миний хэлснээр хийсэнгүй вэ? Би таныг ганц дусал ус дэл үрүү дусаагарай гэтэл та бүхэл бүтэн хорийг дусаачихлаа шүү дээ! Борооны савны ганц дусал гэдэг бол дэлхийд нэг фут бороо авчирдаг болохоор л би танд ганц дуслыг дусаа гэж хэлсэн юм. Тэр хөөрхий тосгон уруу шөнө дунд хорин фут орчихлоо шүү дээ! Оршин суугчдын нэг нь ч амьд гарч чадаагүй байх даа! гэлээ.

Түүний нулимыс дахин асгарав. Буруу харан мөрөн дээрээ байгаа алчуурыг авахад нуруугаар нь дүүрэн улаан шарх байлаа.

- Би наян удаа саваадуулах ял авсан. Хүү нар маань ч гэсэн үүргээ бислүүлээгүйнхээ төлөө ял эдэлнэ гэхэд Ли Чин өөрийнхөө сайн санааны үр дүнг хараад айдас нь хүрлээ. Түүний айхыг хараад эзэгтэй:

- Мэдээж та эгэл хүн болохоор бороо оруулах урлагийг ойлгоно гэж

бодох хэрэгтүй байсан юм. Би танд уурлах ёсгүй. Гэхдээ манай хүүхдүүд энд ирээд юу гэж хэлэх бол гэж би айж байна. Тэгэхээр та ингээд явсан нь дээр гэж хэлэв.

Тэр алгаа ташихад хоёр зарц бүстгүй орж ирэв. Нэг нь танхимын зүүн тал, нөгөө нь баруун талын хаалганаас орж ирлээ. Хоёулаа гайхамшигтай үзэсгэлэнтэй байв. Эзэгтэй хэлэхдээ:

- Ойн энэ гунд амьдарч байгаа бидэнд өмнөөс маань хийсэн ажлын шагнал болгоод өгчих юм байхгүй л дээ. Миний санал болгож чадах юм бол энэ хоёр охин л байна. Та аль нэгтиг нь эсвэл хоёуланг нь чавсан болно. Гэхдээ сонголтоо хийхдээ сайн бодоорой гэсэн юм.

Ли Чин хоёр охин уруу харлаа. Нэг нь түүн рүү инээмсэглэж, нэг нь ууртай янзтай харж байв. Тэр дотроо “Би анчин хүн, дайтах дуртай. Хэрэв би инээмсгэлж байгаа охиныг сонговол эзэгтэй намайг туулайн зүрхтэй гэж бодно” гэж бодоод эзэгтэйд ийн хэлэв:

- Би хоёуланг нь сонгое гэж бодохгүй байна. Баруун хаалгаар орж ирээд нал уруу ийм ууртай хараад байгаа охиныг би сонгое.

- Энэ таны сонголт гэж эмэгтэй зоолон инээмсэглэв. Охиныг түүн үрүү дагуулж авчраад, үдэхээсээ өмнө уут дүүрэн өө сэвгүй том сувд гарч нь атгуулав.

Ли Чин сүйт бүсгүйтэйгээ хамт мориндоо мордон байшиглаас хэдэн алхам холдоод эргэж хартал ямар ч ул мөргүй алга болсон байлаа. Үүр цайж, уулан дахь тосгон уруу явах замыг тэр амархан оллоо. Түүний аиж байснаар, тосгоныг хараахас жихүүдэс хүрмээр байдалтай болсон байв. Тосгон дүүрэн нуур болсноос зөвхөн уршиудын дээвэр л бохир усан дээгүүр цухийн харагдана. Гэхдээ энэ явдал болж байхад тэр савнаас хорин дуслыг удаанаар дусаажээ. Тэнгэр дуугарч, цахилгаан цахихад тосгоны хүмүүс анхааруулга авч дов уруу зугтаж амжсан байна. Тэл бүгд ийнхүү дов дээр гэрээ алдсандаа харамсан сууж байхад нь Ли иржээ.

Ли тэднийг чадах чинээгээрээ тайвшруулаад эзэгтэйн өгсөн сувдиг зархаар довоос буулаа. Сувдны далласан азаар тэр тосгоны хүмүүсийг газар нь хэвэндээ ортол нь тэжээж, дараагаар нь хуучин тосгоных нь оронд шинэ сайхан тосгон барьж өгч чаджээ.

Дараа нь Ли Чин Вэйгийн гүн генерал болсон ба дайчин үйлсээрээ мөнхийн алдар нэрийг олж авсан байна. Энэ нь танхимын баруун хаалгаар орж ирээд түүн үрүү ууртай харж байсан охиныг сонгосноос болжээ. “Төрийн сайдууд уулын зүүн зүгээс, генералууд баруун зүгээс төрөн гардаг” гэсэн яриа байдаг. Хэрэв Ли Чин танхимын зүүн

хаалгаар орж ирээд инээмсэглэн зогсож байсан охиныг сонгосон бол торийн сайд болох байсан ба хэрэв хөбууланг нь сонгосон бол нэгэн зэрэг генерал, сайд болох байжээ.



Aриун явдалт нагац эгч

Олон зуун жилийн өмнө шөнийн сарны гэрэлд налайсан хойт Хятадын цаст уудам хөндийд нэгэн настай хөгшин тариачин эмэгтэй царайлаг ялдамхан охиньхоо хамт аж төрөн суудаг байлаа. Тэрхүү эмэгтэйг ариун явдалт нагац эгч гэдэг байсан бөгөөд гаднаас нь харахад анзаарагдамгүй сайхан байшин нь ердийн нэг байшин биш харин үнэгний ичээ байв. Ариун явдалт нагац эгч үнэн хэрэгтээ ид шидэт үнэг байсан бөгөөд хүний дүрээр амьдардаг нь тэр ажгуу. Түүний үзэсглэлт охин болон Хар тавхайт нэрт хүү нь ч мөн л үнэгнүүд юм санжээ.

Гэтэл нэгэн удаа Хар тавхайт өөрийн болгоомжгүйгээс эвгүй байдалд орсон явдал тохиолдов. Учир нь тэрбээр тариачны үзэсглэлт эхнэрт дурлаж орхиод сахлаг улаан арьс, урт сүүлээ хувирган нэгэн сайхан баатар эр болон мөнөөх эмэгтэйг эргүүлж гарчээ. Гэвч үүнийг нь тариачин нохөр нь тааварлан сэжиглэж орхиж. Тариачин эр нумаа аван шүүдээр дээр дураих мөрийг мөшгин явсаар мань Хар тавхайтыг хүмүүн дурснээсээ үнэг дүрэндээ хувирч байх яг тэр мөчид олж очоод харваж орхилоо. Хар тавхайт суманд оногдон шархадсан өрөөсөн хөлөө чирсээр үүр лүүгээ зутгаж одов.

Ариун явдалт нагац эгч өөрийнх нь чадвар хүүгийнхээ хөлийг хараахан эдгээж чадахгүй гэдгийг сайтар ойлгож байлаа. Тийм учраас хүний дүрд хувиран бусдаас тусlamж авахаас өөр арга байсангүй.

Тиймээс гүйлгачин эмгэний дурд хувиран анагаах арга чадлаараа зартай Ин эмчийг зорилоо.

Ин эмч Ариун явдалт нагац эгчийн гадаад байдлыг төдийлэн ажиглаж өрөвдсөнгүй.

- Хүүгээ узуулэх гэж намайг авахаар ирэв үү? Сүүл нь болохоо

байсан уу? гэж эмч ёжтойхон өгүүлвэй.

Тэгээд эмч хүүгийн нь шархадсан холенд зориулан хамгийн шилдэг эмийн жор бичиж өглөө. Ин эмч ирээдүйд охинд нь хүнд хэцүү хувь тавилан ноогдохыг эмэгтэйд сануулан хэлээд Тао буюу Ариун зам мөрийг даган баримталбаас үүнээс зайлсхийж чадахыг анхааруулан зовлов.

Ариун явдалт нагац эгч уг зөвлөгөөг даган, охиноо дагуулан цасан дундуур туучин замд гарлаа. Хар тавхайтын хөл нэлээд илааршсан боловч доголсоор байсан ба явж чадахгүйд хүрсэн учраас түүнийг нэгэн сүмд орхисон байв. Өөрийн гэсэн орох оронтой болонгуутаа тэндээ Хар тавхайтыг аваачин гурвуул Ариун зам мөрийг даган баясна хэмээн тэд тооцоолжээ.

Тэр шөнө маш хүйтэн байв. Гэхдээ хэдий хүний дурстэй боловч тэд үнэтгүүд учраас нэг их айхгүй байсан хэрэг. Явган их явсандаа ядарсан хоёр биенээ нөмөрдөн сууж байгаад гэнэт тэртээ нэг хоёр километрийн цаана хоргодон сууж болмоор шигүү төгөл байхыг олж үзэж гэнэ. Гэтэл яг энэ үеэр маш хүчтэй шуурга дэгдэх нь тэр. Ээж охин хоёр үүнээс айж сандран бие үрүүгээ шигдэн байв. Шуурга өнгөрөхөд Ариун явдалт нагац нүдээ нээн харвал өмнө нь иж бүрэн зэвсэг агссан хоёр дайчин эр зогсож байх нь тэр.

- Диваажингийн хатан хаан Ариун явдалт нагац эгчийг өөр дээрээ ирүүлэхийг тушаалаа хэмээн тэд хэлэв.

- Диваажингийн хатан хаан гэнэ ээ. Түүнд өөр ямар нэгэн нэр бий юу хэмээн Ариун явдалт нагац эгч лавлахад,

- Тэр Тан гүрний үед Вү хатан гэдэг алдартай байсан билээ гэж дайчид хариу хүнгэнэлээ.

Үүнийг сонсоод Ариун явдалт нагац эгчийн нуруу уруу хүйт оргилоо. Вү гэдэг бол Тан гүрнийг захирагын тулдLuут сэнтийг төмөр ташуур далайн булааж авсан эмэгтэйн нэр билээ. Гэхдээ тэр хэдэн зуун жилийн өмнө нас барсан ажээ. Тэр аугаа их хүнийг дахин харах завшаан Ариун явдалт нагац эгчид одллоо гэж үү?

Дайчид өвс ногоо битүү урган, дээрээс нь модод сүүхийлцсэн зоргоор дагуулан явсаар ордны хаалгач эмэгтэй дээр очтол Ариун явдалт нагац эгчийн толгойд эргэлсэн, тайхсан үй түмэн бодол чихэлдэн байв. Ариун явдалт нагац эгч хэдий сандран будилж байсан боловч харин диваажингийн Хатан хаан их л эзлдэг зантай байв. Тэр өөрийн зовлон гунигийг сэтгэл харамгүй хувааллаа. Тухайн үедээ тэр улс орноо үнэн шударгаар залан жолоодохыг хичээж байсан хэмээн тэр

тангараглаад харин урвагч сайдуудын мэхэнд автсан гэж ярьж байв.

- Тэр бол хүйвалдаан, үймээний цаг үе байлаа. Гэхдээ одоо ч мартагдаж дээ. Би өөрийн чинь өмнө чимэг зүүлт ч үгүй зогсож байгаад ичиж байна хэмээн хатан хаан санаа алдлаа.

Нээрээ л Ариун явдалт нагац эгчийн ажигласнаар хатан хаан ямар ч гоёл чимэглэлтүй байх аж.

- Таны сүнс тэр дээрэмчдийг номхруулж дийлээгүй хэрэг үү?
Хэмээн Ариун явдалт нагац эгчийг асуухад,

- Тийм ээ чадаагүй юм аа. Хувь тавилан маань тийм зурагтай байлаа гэж Хатан хаан өгүүллээ. Тэгснээ нүд нь сэргэж,

- Харин одоо бол өөр өө. Хувь тавилан надад ээлтэй хандаж байгаа. Одоо би хорвоод дахин төрөх учиртай юм. Тэгээд улс орныг дахин удирдах болно. Гэхдээ энэ удаа эмэгтэй хүн биш, эрэгтэй хүн болж төрне. Тэгэхэд таны охин миний эхнэр болох учиртай юм хэмээн цааш нь ярилаа.

Ариун явдалт нагац эгч түүнийг гайхан харах зуур хатан хаан яриагаа үргэлжлүүллээ.

- Хоёулаа өнөөдрөөс хойш хорин найман жилийн дараа уулзацаая. Харин тэр болтол чи ид шидийн ухаанд суралцах хэрэгтэй гэж тэр ярив.

- Би Ариун зам мөрийг эрж явна. Харин ид шидийн ухаанд хаана очиж суралцах билээ? хэмээн Ариун явдалт нагац эгч лавлахуй, хатан хаан чи анхааралтай сонсож бай гээд хэлсэн нь:

УЛИАС СААТУУЛНА.

ХАРИН ӨНДӨГ БҮГДИЙГ ТАЙЛБАРЛАНА.

ХАЙГААД ХЭРЭГГҮЙ ӨӨРӨӨ ОЛДОНО.

ХАЙСАН Ч ЦАГИЙН ГАРЗ.

Ариун явдалт нагац эгч толгой дохин дээрх үгсийг сэтгэлдээ хоногшуулан зогслоо.

- Миний хэлснийг чи хэнд ч хэлэх ёсгүй шүү. Нэн ялангуяа миний заналт дайсан Өтөл өвгөнд дуулгав аа хэмээн Хатан хаан сүүлчийн удаа анхаарууллаа.

- Өтөл өвгөн гэж хэн бэ?

- Тэр бол Хан хааны хүү Ян...

Хатан хааныг үгээ хэлж амжаагүй байтал айсандaa хамаг ёсыг умартсан ордны шивэгчин хүүхэн хар хурдаараа гүйсээр орж ирлээ.

- Хаан хүү Ян зуун мянган дайчдын хамт довтлон ирээд байна гэж хөөрхий шивэгчин хашигллаа. Үүнийг сонссон хатан хааны царай

хувхай цайн, түргэхэн эргэж гарч одлоо.

- Намайг хүлээгээр хэмээн Ариун явдалт нагац түүний хойноос сандран гүйхдээ замдаа дайралсан сандлыг дайрч унагаав. Гэтэл тэнгэр ниргэх мэт чанга дуу нүргэлэн Ариун явдалт нагац эгч хүйтэн хөлс нь цутгачихсан амьтан хоосон булшны ёроолд цор ганцаар чичрэн хэвтэж байх нь тэр. Хатан хаан ч тэр, ордон нь ч тэр аль аль нь бараа сураггүй алга болсон байх агаад эргэн тойрон чимээгүй ой л сүүдийх аж.

Гагшүү түүний охин алга болсон байлаа. Энэ нь Ариун явдалт нагац эгч зүүдлээгүй гэдгийн нотолгоо байлаа. Тэр зүтгэсээр булшны нүхнээс арайхийн гарлаа. Тэгээд хажууханд байх том чулуун дээр авиран гарч нүүр лүүгээ хаттах өвс, өргөсөн дундуур зүтгэсээр дөрвөн мөр угсийг сийллээ.

УЛИАС СААТУУЛНА.

ХАРИН ӨНДӨГ БҮГДИЙГ ТАЙЛБАРЛАНА.

ХАЙГААД ХЭРЭГГҮЙ ӨӨРӨӨ ОЛДОНО.

ХАЙСАН Ч ЦАГИЙН ГАРЗ.

Хатан хааны эдгээр үгс Ариун явдалт нагац эгчийн бодол санаанд эргэлдээр байв. Түүний хамгийн эхлээд олох ёстой зүйл нь улиас аж. Гэвч хаанаас түүнийг хайх билээ. Хүү нь олон хоногийн өмнө сүмд үлдэж хоцорсон. Охин нь ч алга болсон нь түүний хувь тавилан хүнд хэцүү байх болно хэмээсэн эмчийн зөgnж хэлсэн явдал хэрэгжиж буйн дохио бололтой. Ариун явдалт нагац эгч энэ бүхнийг эргэцүүлэн бодоод дагжин чичирсэн боловч олон жилийн дараа тэр охин эхнэр нь болох учиртай хэмээсэн диваажингийн хатан хааны угийг дурсан саналаа. Одоо бодвол тэр охин нь тэр үйл явдлаа гүйцэтгэээр одсон бололтой.

Гэвч хувь заяа бүхнийг шийдэх тул Ариун явдалт нагац очиж ариун зам мөрийг дагая гэж бодсон Хугийн их ууланд очихоос өөр зам үлдсэнгүй. Ху ууланд тоо томшгүй олон сүм хийдүүд байх агаад ядуу, уранхай ноорхой хувцастай түм буман гэлэн ба гэлэнмаа нар байх ажээ. Үе үехэн хот сууринаас даянчид, албаны түшмэдүүд, наймаачид ихэнхдээ баян чинээлгээ эхнэрүүд ирж Ху ууланд эргэл мөргөл хийх ажгуу. Тэднийг ийн ирэхэд уулнаа амьдрагч үй түмэн үтээгүйчүүд тэднийг бүчин шавдаг байв.

Нэгэн өглөө баян худалдаачны эхнэр тойрон бүчсэн олныг тараах гэж цангинуулан углэж байхыг Ариун явдалт Нагац эгч олж сонсчээ.

- Би өнөөдөр мөнгө авчраагүй байхад та нар надаас юм горьдоод

яахав дээ. Миний нехөр ахмад бурхан Ян шиг бүхнээ хүнд тараагаад өгчихдог гэж бодоо юу? Тийм л юм бол та нар түүн дээр, өглөгч эхнэр дээр нь очихгүй юу гэж тэр эхнэр аashiж байв.

Түүнийг сонссон Ариун явдалт нагац эгч Ян гэдэг нь улиас гэсэн утгатайг гэнэт саналаа.

УЛИАС СААТУУЛНА...

Тэрээр нэн даруй явж, ойр орчимдоо алдартай тао шүтлэгт эмэгтэйг олж уулzan сураг чимээ сонсвол, хотын ойролцоо амьдран суудаг Төгөлдөр Ян гэгч үүдэн дээрээ ирсэн хэнийг боловч энэрэн асарч, өглөг өгдгөөрөө алдаршин Ахмад бурхан хэмээн хүндлэгдэг болсон байв.

Үүнийг сонссон Ариун явдалт нагац тэр дороо хотод байх Төгөлдөр Яны өргөө үрүү яаравчиллаа. Тэр Яны өргөөний үүдэнд хүрч очоод том үсгээр бичсэн зарлалыг олж үзэн гайхшиллаа. Тэнд улирал бүхний эхний өдөр өглөг өгөх ёслол болно. Бусад цагт ийм ёслол болохгүй гэж бичсэн байлаа.

Ариун явдалт нагац хаалгачийг олж уулzan тэрхүү сонин зарлалын учрыг шалгаалаа.

- Та ч сайн мэдэхгүй байх шиг байна. Эзэнтэн маань өдөр бүхэн өглөг буянаа хайрладаг байсан юм. Гэвч нэг сарын өмнө маш муу зүйл билэнд тохиолдож тэр ёсоо болиход хүрээд байгаа минь энэ. Нэг өдөр гаднаас нь харахад сайхан царайлсан нэг хүн ирээд эзэнтэй хамт өдөржин байгаад буцтал гэнэт түүний хамсаатан самуун таригч мөргөлчид шөнө делеөр уулгалан ирээд эзэнтний алт мөнгө, хамаг байдгийг цөлмөж орхиод арилж одсон доо. Тийм болохоор сайхан сэтгэлт эмэгтэй минь та эзэнтний хишигийг хүргэж, аягаа дүүргээ гэж байгаа бол дараагийн улирлын эхэн өдрийг хүлээх болох нь дээ хэмээн тэрхүү хаалгач хөврүүллээ.

Ариун явдалт нагац эгч ийнхүү “улиас”-ыг олоод авлаа. Гэхдээ нэг өдөр ч хойшлуулахыг хүссэнгүй. Тиймээс хаалгачтай ярилцан түүнтэй лотносох арга хайж байтал байшингаас нэгэн цуваа гаралд ирэх нь тэр. Лимбэчил, тут баригчдаар хүрээлүүлсэн хүмүүс мөрөн дээрээ сандал дамнан яваа агаад уг сандал дээр нь Төгөлдөр Ян өөрийн бисэр залран явж байх ажээ. Цуваа төдөлгүй хаалгаар гаран гудамж уруудан одлоо.

- Тэр хаашаа явж байгаа юм бэ? хэмээн Ариун явдалт нагац эгч лавлав.

- Тэр санскрит бичвэр залахаар явж байгаа юм хэмээн хаалгач хариуллаа.

- Танай эзэнтэн санскрит уншиж чадна гэж үү?

- Санскритийг хэн ч уншиж чадахгүй. Түүнийг хотод амыдарч байсан нэгэн хэлгүй, дүлий мөргөлчин үлдээсэн юм. Ном бүхэлдээ Энэтхэгийн алтан үсгээр бичигдсэн бөгөөд манай эзэн түүнд зориулж тусгай хайрцааг хийлгэсэн дээ гэж хаалгач өгүүлэв.

Энэ бол Ариун явдалт нагац эгчийн хувьд азтай явдал байлаа. Учир нь тэрбээр үнэгний амьдралаар олон жил амьдрахдаа олон эрдэмтэй үнэгтэй найзалж явсан бөгөөд тэдний нэгнээс Энэтхэг бичиг үсгэг тайлах эрдэмд суралцсан байлаа. Тэр энэ тухайгаа хаалгачид хэлэв. Гэхдээ үнэг байсан, үнэгнээс суралцсан гэдгээ хэлээгүй нь мэдээж. Хаалгач эхлээд үүнд нь огтхон ч итгээгүй боловч Ариун явдалт нагац эгч өөрийн багш байсан гээл Бодисадын хувилгааны тухай уран гоёор ярихад ялимгүй итгэж эхлэв. Тэгээд түүний тухай эзэндээ айлтгаж өгнө хэмээн ам өглөө.

Орой нь Төгөлдөр Ян санскрит бичвэрээ аван буцаж ирэхэд нь хаалгач түүнд энэхүү гайхалтай зочны талаар хэллээ. Ян түүнийг нь нэг их тоосонгүй бөгөөд ганц хоёр хоног юу болохыг нь харья гэж шийджээ. Гэвч дөнгөж гэртээ ортол эхнэр нь өдөр тохиолдсон гайхалтай явдлын талаар сонирхуулан ярьж гарлаа.

- Би цэцэрлэгтээ жимс сонирхож зогсож байгаад зүүн өмнө зүгээс нэгэн үзэсгэлэнт солонгорсон үүл хөвж ирэхийг харлаа. Гэтэл тэр үүлийн яг гол дунд нь алт, сувлан хажлагат суудал дээрээ цагаан заан хөлөглөсөн Бодисадын хувилгаан амгалан дүрээр заларч яваа нь харагдсан. Би ч Бодисадын хувилгаан мөн дүрээрээ надад харагдлаа гэдгийг ойлголоо. Тэгээд би газарт сунаж мөргөлөө. Дараа нь толгойгоо ондийлгэн хартал хувилгаан аль хэдийн явж одсон байлаа хэмээн тэр ярив.

Тэгсэн чинь Ариун явдалт нагац эгч өөр өөр дүрд хувирах ид шидээр баян юм санжээ. Солонгот үүлэн дээр цагаан заан унан хэдхэн минут зорчихд түүнд амархан байжээ.

Харин Төгөлдөр Ян эхнэрийн хамтаар Ариун явдалт нагац эгчийг хувилгаан хүн байна гэдэгт бүрэн итгэлээ. Тэгээд зүүн өмнөд зүг үрүү Төгөлдөр Ян хандаж Ариун явдалт нагац эгчийн нэрийг гурвантаа дуудсан даруй хаалгач нь түүнийг үүдэнд хүрэлцэн ирсэнийг дуулгалаа. Тэд нар эмэгтэйг хүндлэн утгаж, таван тансаг жимс ногоо тэргүүтэн ширээнд урин суулгалаа. Тийнхүү шайлсны дараа Төгөлдөр Ян хосгүй үнэтэй санскрит бичвэрийг хайрцаагаас нь гаргаж ирлээ. Тэрхүү бичвэр нь ховор нандин Зүрхэн тарни болохыг Ариун явдалт нагац

эгч андуутгүй таньж тухайн хуудаснаас түгдрэлгүй уншин Төгөлдөр Янд орчуулан хөлж өглөө. Төгөлдөр Ян ч үүнд нь баярлан бүх судрыг уншуулахын тулд Ариун явдалт нагац эгчийг гэртээ үлдэн амьдрахыг толгой мэхийлгэн хүслээ.

Тэр эхнэрийн хамт түүнд өдөрт ямар хоол, цай зооглохыг нь лавлахад Ариун явдалт нагац эгч инээд алдаж,

- Та бүхэн үүнд санаа зовох хэрэггүй. Би арван жилийг ганц өдөр шиг өнгөрүүлж чадна хэмээлээ.

“Энэ бол байж боломгүй зүйл” хэмээн Төгөлдөр Ян эхнэрийн хамт бодсон боловч түүний үгийг дагав. Түүнээс хойш нэгэн долоо хоног хэн ч Ариун явдалт нагац эгчийн дэргэд очсонгүй. Харин найм дахь өдөр нь Төгөлдөр Яны эхнэр түүн дээр очвол шаадах нь отгхон ч өлсөж ундаассан шинжгүй гялалзаж байхыг үзээд туйлын биширсэн болгое.

Гэвч үнэн хэрэгтээ Ариун явдалт нагац үнэг учраас хүмүүний хоол зохидогтгүй байсан хэрэг л дээ.

Ингэснээрээ Ариун явдалт нагац Төгөлдөр Янд амыд бурхан хэмээн хүндлэгдэж мөнөөх диваажингийн хатан хааны хэлсэн “УЛИАС СААТУУЛНА” хэмээх үг үнэн болох нь тэр ээ.



Өндөгөн төрөлт

Xягадын өөр нэг уулархаг нутагт сүмийн өмнө нэгэн бяцхан цөөрөм байдаг байв. Уг сүмийн сайхан сэтгэлт хөгшин гэсгүй лам ойролцоо тосгонд ном айлдах заллага аваад овоодой малгайгаа утаахаар шийдэн мөнөөх цөөрөм дээр очтол усны мандал дээр нэгэн өндөг хөвж яваа үзэгдэв гэнэ. Ламтан авч явсан сагсаа усанд хийн хоёр ч удаа оролдсоны эцэст өндгийг шуурдэн барьж авч л дээ. Тэр нь тахиных гэхээсээ илүү галууных байж мэдэхээр був бүтэн том өндөг байв.

Сонин л юм даа, энэ хавыл галуу тэжээдэг хүн лав байхгүй дээ. За яхав. Дотроо ангаахайтай болов уу үгүй болов уу. Харан байж болтэй. Ангаахайгүй бол идэж орхино биз. Үгүй бол Чу хөгшинд өгчихвэл таарна хэмээн гэсгүй дотроо боджээ.

Гэсгүй өндгийг нарны гэрэлд барьж үзвэл дотроо ангаахайтай бололтой байсанд хөгшин Чуд явуулж орхиод маргчихаж гэнэ.

Гэтэл долоо хоногийн хойно гэсгүйг бясалгал хийж сутуул Чу хөгшин ноцтой мэдээ авчран хайрлагж ирэв. Тэгтэл өндөг хагаран дотроос нь соёом хэрийн жал гарч ирсэн явдал тохиолджээ.

Тэрхүү жигтэйхэн амьтныг яахаа мэдэхээ байсан Чу хөгшин ийн ирээд гэсгүйгээс түүнийг буцааж авахыг хүсэв.

Ламтан уг хүсэлтийг хүлээж авсан ч эргэн тойрныхынг айлгахыг үл түвдэн энэ тухай хэнд ч ам ангайхгүй байх ам очгийг Чу хөгшиноос авчээ. Чөтөр шулам л ийм янзтай төрдөг байх гэж тэр боджээ. Тэр хүн дүрст бяцхан жаалыг сагсандаа авслаад сүмийн хамгийн алс цэнэрлэгт оршуулж орхиж гэнэ. Гэтэл гэсгүй тэндээс явахдаа эргээд хартал жаалхүүгийн толгой газар дороос шоволзон цухуйж харагдав. Өвгөн айсан сандарсандaa хүрзээрээ цохисон боловч халт цохин хүрз нь

бутраад унаачхаж. Харин жаалхүү нүдээ нээн, эсдгээр инээмсэглэв.

Гэсгүй нүдэнд нулиms хураад ирэв.

Хөөрхий минь. Хүн төрөл олсон амьтан юм бол үр хүссэн хосуудад заяахгүй явадаа. Гэвч чи буруу газраа л төрж дээ. Хүмүүсийг айлгахгүйн тулд чамайг далд оруулахаас өөр арга даанч алга даа.

Гэсгүй ийн өгүүлэх зуур жаалхүүгийн толгойг шороогоор түргэхэн булаад булшийг өндөрлөн дээрээс нь том чулуугаар даруулж орхив. Тэр явахдаа цэцэрлэгийн хашааг цоожлоод хэрэв бут чөтгөр үхлэгтүй юм аа гэхэд өлсгөлөнгөөр мажийх биз хэмээн боджээ.

Түүнээс хойшихиар авсан таван өдөр цэцэрлэгт үрүү хэн ч зүглэсэнгүй. Харин авсан зургаа дахь өдөр нь гэсгүй юу болсныг үзэхээр явж очлоо.

Түүний аиж байсанчлан булшны шороо, чулуу тал тал тийшээ шидэгдсэн байх агаад аль хэдийн гурав дөрвөн төө болтлоо ёсчихсөн мөнөөх хүү модны мөчир дээр нүүгэн, инээд алдан сууж байх ажээ. Тэгснээ өвгөнийг хараал ханцуйнаас нь барьж авахаар зүтгэлэх аж. Гэсгүйтгэн ч холийн хурд мэдэн зутгаж жаахан тайвширч аваад өөрийгөө эрүүл эсэхийг эргэцүүлэн сүмдээ очин залбирал үүлдэв. Тэгээд бурхны номоор мэрэглэж үзвэл “Хамгийн аз жаргалтай хүн” хэмээх угс тодрох нь тэр.

Сэтгэл санаа нь үймэрч догдолсон гэсгүй сүүлдээ жаалыг цэцэрлэгээс авчран эхнэрээ эрлэгт алдсан бөгөөд өөрийн гэх үр хүүхэдгүй хөгшин Лю хэмээх номхон зөвлөн зарцал аваачиж өгөв. Тэгээд хүүг үл таних тариачны гэр бүл сүмийн хурдэн дээр орхисон хэмээх зарыг тараажжээ. Түүнээс хойш хэсэг хугацаа өнгөрөхөд хүү жирийн хүний хүүхдийн хэмжээтэй болж, хэлд болон хэлд оров гэнэ. Сонин хачин байдлаар төрсөн болохоор нь хүүг Өндгөн төрөлт хэмээн нэрлэсэн байв. Сүмд хүүг нүд үзүүрлэн өндөгнөөс төрсөн бөгөөд нохой шиншлэхгүй амьтан гэж хэлдэг ганц нэг лам ч байв.

Гэвч хүүд бас буруу гэмээр зуршил байсан нь бүр багаасаа хоолонд ховдог, дарсанд шунамгай байдал аж. Хүү авсан таван нас хүрэхдээ бурхны ном гадарлах болсон төдийгүй гардан зодооны эрдэмд ч сурсан байв.

Харамсалтай нь мань хүн хүрц түргэн ааштай нэгэн байв. Өөрийг нь гомдоосон лам нарын гавлыг нээхээсээ ч буцахгүй байсан бөгөөд сүм хийдийн хэвшмэл амьдралд үйдаж цөхрөн хaa нэгтээ явж одохыг хүснэгжлэх ажгуу. Гэхдээ эцгийнх нь оронд эцэг болсон Лю хөгшнийг өрөвдөөд тэгж үл төвдөх бүлгээ. Гэвч нэгэнтээ хөгшин Лю хүнд өвчлөн

хэвтжээ. Өндөгийн төрөлт бүтэн дөрвөн шоно, дөрвөн өдөр Люг жинхэнэ хүүгийн ёсоор хувцасаа ч тайлангүй цурамхийлгүй харж асарсан ч Лю нас баржээ. Тэгэхэд Өндөгийн төрөлт асар ихээр гашууджээ.

Түүнээс нэг их удалгүй Өндөгийн төрөлт нэгэн санваартны нум сум, хувцас эдлэлийг хулгайлсан аваад сүмээс чөлөөтэй явж одов. Түүнээс хойш тэр олон он, сарыг улс орныхоо өнцөг булан бүрээр хэсүүчлэн тэнэж өнгөрөөв. Өндөгийн төрөлт хaa сайгүй хоол гүйн олж идсээр явсан агаад харин замд дайралсан булш бунханд байнга хүндэтгэл үзүүлэх болгое. Тийн явахдаа өөртэй нь ижил бадарчин хийж яваа даяанч наргтай зам нийлэн заримдаа хэдэн долоо хоног, сараар хамт явцгаадаг байв.

Гэхдээ ийн аялан явах нь өөрийнх нь жинхэнэ зорилгод хүрэхийн өмнөх түр зуурын хэрэг гэдэгт Өндөгийн төрөлт хатуу итгэдэг байв. Тиймээс ч элдвийн онцгой хүндэрэл бэрхшээл, зовлон зүдгүүрийг үл амссан агаад нэгэнтэй Мөрөөдлийн Үүл хэмээх алдарт уулын даваан дээр нэгэн хадан цохиог олж үзжээ. Тэрхүү дун цагаан хадан цохио өмнөх замд нь хөндөлсөн тэнгэр хаан сүүхийх нь өртөнцийн хамгийн мухарт ирэв үү дээ гэмээр сэлгэгдэл төрүүлэх нь ер бусын. Түүнийг гайхан алмайрч байх зуур араас нь хэн нэгэн:

- Буцаад яв, буцаад яв. Та төөрчихлөө хэмээн хэлэх нь дуулдас.

Эргэн харвал нэгэн мөргөлчин байх ажээ. Тэр явуулын хүн замаар орон алхах зуураа, энэ ямар газар болохыг лавласан Өндөгийн төрөлтийн асуултанд хариулан, ярьж гарав.

- Энэ бол Цагаан үүлний агуй хэмээх нутаг бөгөөд Цагаан бичний сүнсний орон юм аа. Тэр Цагаан бич диваажингийн тарниийн хамгаалагч. Харин энэ цохио хараалын шившлэгээс хамгаалдаг гэнэ лээ хэмээн тэр мөргөлчин ярив.

- Диваажингийн тарни гэж юу юм бэ? Яагаад энэ хараалын шившлэгтэй ууланд түүнийг байлгадаг юм бол?

- Энэтухай цөөхөн хүн мэднэ. Эрт галавын цагт Ертөнцийн захирагч Бичний сүнсийг Диваажингийн тарниийн хамгаалагчаар томилсон гэдэг. Гэвч тэр хамгаалагч байх үүргээ байнга мартдаг хайхрамжгүй нэгэн байж. Учир нь бичний дурсгүй ааш хэзээ ч арилшгүй юм байж. Нэгэнтэй бүх сүнснүүд Баруун орны эх дагинын төрсөн өдрийн баярт уригдаад явчихсан хойгуур мань бичний сүнс ариун тарниийн номын нэг хуудсыг сэм ураад авчихаж. Түүнийгээ бичин сүрэгтэй үзүүлэх санаатай байж. Тэгээд газарт бууж ирээд нөгөө тарниа хуулан бичиж дуусаагүй байтал төрсөн өдрийн баяр тарчихжээ. Баяраас ирсэн

Ертөнцийн захирагч номын нэг хуудас, хамгаалагчийн хамт алга болсныг үзээд ихэд хилэгнэн, бичний сүнсийг шүүн асууж гэм буруут нь хүлээлгэсэн гэдэг. Тэр цагаас хойш цагаан бичний сүнс мөнөөх нэг хуудсыг агуйд үүрд хадгалан сахихаар шийтгэгдсэн агаад хадан цагаан хошуу бол бичин сүрэг, хараалын шившилэгээс хамгаалан тавигдсан эд юм хэмээн мөргөлчин яржээ.

- Энэ ч харин сонирхолтой түүх байна даа. Харин та хамгийн гол зүйлийг надад хэлсэнгүй. Тэр бичвэрт юу байгаа юм бэ дээ хэмээн Өндгөн төрөлт лавлав.

- Энэ бичвэрт зуун найман удаа хувилан төрөх нууц тарнийг тайлсан байгаа гэж би бодож байна гэж мөргөлчин хариу өгүүллээ.

- Хувилан төрөх гэнэ ээ хэмээн Өндгөн төрөлт дуу алдаал, ертөнцийн захирагч тэгж уурлах нь ч аргагүй л байж дээ. Тэгээд энэ нэвтэршгүй саадыг байгуулж дээ гэлээ.

- Жилийн гурван зуун тавин есөн өдөр нь хадан хошуу байгаа энэ газар нэвтэршгүй байдаг. Харин тавдугаар сарын тавны өдөр дундын хоёр цагийн хугацаанд л агуяа хамгаалалтгүй хоцордог юм гэдэг. Учир нь энэ цагт Бичний сүнс Ертөнцийн захирагчид очиж жилийнхээ ажлыг тайлагнадаг учиртай гэнэлээ. Тэр хоёр цаг дуусахад хүжний цагаан утгаа манаач анхилам үнэр үнэртэн Бичний сүнс эргэж ирэхийн дохио болдог юм гэсэн гэж мөргөлчин тайлбарлав.

- Агуин нуущад нэвтрэх гэж хэн ч оролдоогүй хэрэг үү?

- Нэгэн хэрмэл лам агуяа дээр ирсэн боловч, хадан хясаанаас агуяа хүрдэг хавцал дээрх нарийхан гүүрээр гарч чадалгүй айгаад буцсан гэсэн. Тэр гүүр өдөр ч гэсэн тас харанхуй байдаг англ дээрх маш нарийхан гүүр гэсэн.

Мөргөлчин Өндгөн төрөлт хоёр ийн ярилцаад зам салав. Мөргөлчний яриа Өндгөн төрөлтийн сэтгэлийг ихэд хөдөлгөв. Тэрхүү агуяа хүрч нууцыг тайлах хүн нь чухам өөрөө юм шиг Өндгөн төрөлтөд бодогдон амар заяа үзүүлэхгүй байсан хэрэг.

Дөрөвдүгээр сар дөнгөж эхэлж байсан тул хэдхэн долоо хоног хүлээх л үлдсэн байлаа. Тэр өвс, мөчир түүн цуглувуулж уулын бэлд овоохой барьж авлаа. Тэгээд агуу их адал явдалд бэлтгэн хүлээж эхэлжээ. Тэгээд цаг нөхцөөхийн тулд дарс ууж гарлаа. Тэгсэн нөгөө дарс нь цаг хугацааг түргэтгэх бус харин ч улам яаруулах өвчин тусгасан тул мань хүн нэгэн шөнө овоохойгоосоо гараад хадан хошуут зүглэлээ. Гэвч шигүү ой дундуур хэсэг амьсгаадан зүтгэж яваад толгой тархи нь овоо сэргэлэн болж, дарс нь гарч ухаан ороод буцсан ажээ.

Тэгээд овоохойдоо шургаж аваад хүлээлтээ үргэлжлүүлэв.

Тэгсээр тавдугаар сарын тавны өглөө Өндгөн төрөлт орноосоо өндийн хадан хошуу уруу хараа бэлчээлээ. Түүнд хадан хошуухижигхэн болсон мэт санагдж байлаа. Өндгөн төрөлт мөргөл залбираа үйлдээр өдөр дунд болгоход тэнгэр бүрэн цэлмэж хадан хясаа нов ногоон уулан дунд тунгалаг тодорхой сүглийн харагдах ажээ. Өндгөн төрөлт хамгийн бөх гутлаа өмсөн гартаа бат бөх багаж зэвсгээ бариал уул уруу шуударлаа. Тэгтэл явах зам нь эхнээсээ л туйлын хүнд болж эхэллээ. Учир нь түүний замд нэгэн балархай зөрөг хааяа нэг үзэгдээд алга болчхоод байсан бөгөөд Өндгөн төрөлт зүтгэсээр яваад нэг л мэдэхэд хүн нэвтрэхийн аргагүй битүү ширэнгэ ойд орчихсон байлаа. Гэхдээ нөгөө балархай зөрөг хааяа харагдсаар байсанд Өндгөн төрөлт түүгээр баримжаалан урагшиллаа. Тэгсээр нэлээд хэдэн километр явсны эцэст мөнөөх жим нэгэн их хадан хясааны ирмэгт аваачлаа. Тэрхүү хадан хясааны ёроолд голын ус хөөсрөн урсах аж. Тэрхүү өргөн хавцыг Өндгөн төрөлт гайхшран харж зогстол ирмэгийн чулууд гэнэт хөдлөн нарийхан нуман гүүр бий боллоо. Тэрхүү гүүр зөвхөн ганц тоо өргөнтэй аж. Тэндээс нэг л хазгай гишгэвэл доош нисч үхэхээр байлаа.

Өндгөн төрөлт нэг гүнзгий амьсгал аваад урагш алхлаа. Алхсаар явтал гүүр дуусч, чулуун дундуур нэвт гарсан хонгил өмнө нь харагдлаа. Хонгилын тогтон дээр “Цагаан үүлийн агуй” хэмээн сийлсэн байв. Тэр очих газраа очжээ.

Өндгөн төрөлт урагшиллаа. Энэ хавийн газар үнэхээр үзэсглэлэнтэй ажээ. Тэр эргэн тойрноо анхааралтай ажиглаад авирч эхэллээ. Гэвч нэгэн содон үнэр үнэртэх нь тэр. Доош харвал Ертөнцийн захирагчийн хүжний тавиураас цагаан утгаа дэгдэн анхилам үнэр хамар цоргилоо.

Энэ бол Цагаан бичний сүнс диваажингийн орноо зочлоод эргэж ирсний дохио ажээ. Үүийг мэдээл Өндгөн төрөлт айн сандарч хонгилыг уруудан буцаж гүйлээ. Тэгээд гүүрэн дээгүүр харайлгалаа.

Сандарсандаа халт гишгэн золтой л доош хийсчихсэнгүй. Эцсийн мөчид арайхийн тэнцвэрээ олоогүй бол тэргээ доорх хадан дээр бяц унах нь зайлшгүй байсан хэрэг. Тэгээд Өндгөн төрөлт гүүр гаралаа нэг гүнзгий амьсгaa аваад цааш гүйлээ. Хадан цохио улам нарийссар байсан ч Өндгөн төрөлт түүн дээгүүр амжин гүйж гарлаа.

Тэгээд овоохой уруугаа гэлдрэх зуураа зорьсон ажил бүтээмжгүй болсонд өөрийгөө зэмлэж явав.

- Ямар тэнэг юм бэ. Ингэж их хүлээж, ингэж их явчхаад нөгөө Диваажингийн номыг хаана байгааг ч мэдэхгүй байх гэж. Одоо дахиад

гурван зуун жар хоног хүлээх хэрэгтэй болох нь хэмээн тэр өөрөө өөртөө ярж явав. Тэр хоромхон зуур сэтгэлээр унасан ч угийн хөгжүүн хүн тул бушаж сэргэлээ.

- За яахав. Одоо би ямар ч байсан очих замаа мэддэг болчихлоо. Дараагийн удаа илүү дөхөм боллоо. Гүүрээр нэг гарч болсон юм дахиад гарчхаж болох биз. Дараагийн удаа эргэн тойрныг харж цаг алдах хэрэгтүй учраас шуудхан очоод номыг авчихна даа хө. Тэгээд бушаж эндээс ирээд уншаад байдал хэрэг хэмээн Өндгөн төрөлт өөрөө өөртөө хэлсээр явжээ.

Ийнхүү өөрийгөө урамшуулсан Өндгөн төрөлт тавысан зорилгоосоо няцаахгүй хэмээн шийдсэн авай. Гэхдээ түүнд бүтэн жилийн турш овоохойдоо байгаад байх ямар ч шаардлагагүй байсан тул замд гарч ойр хавийн нуттуудаар хэрэн хэсч эхлэв. Тэрээр олноор хэсүүчлэн хоол гүйж явахдаа замд дайралдсан их бага булш бунхад, сүм хийдүүдэд хүндэтгэл үзүүлсээр явж байв.

Тийн байсаар жил тойрч тавдугаар сарын тавны өдөр болоход Өндгөн төрөлт урьлынхаасаа хавьгүй сайн бэлтгэлтэй байж байлаа.

Тэрээр урьд жилийнх шиг дарсанд мансуурсангүй, харин сэтгэлээ амаржуулан бататгахын тулд мөргөл залбирал үйлдэж, бясалгал хийж байв. Тавны өглөө тэр эртгэн босоод замд гаран явсаар хадан хошуу цэлмэг тэнгэрт тодорхой харагдаж эхлэх тэр агшинд хавцлын ирмэгт хүрч очсон байлаа. Тэр нарийхан гүүрийг дахин амжилттай гатлан хадан хонгилд тулж очлоо. Тэр урьлын явдлаас сургамж авсан тул эргэн тойрны гоо үзэмжийг ширгэн сонирхохыг үл төвдөн шулуухан урагшиллаа. Тэгсээр урьд жил нь хүрээл буссан тэр газарт нэгэн хар завсар байхыг харлаа. Мөнөөх ариун номонд хүрэх хаалга мөн бололтой. Түүгээр орвол ерлийн өрөөнөөс тав дахин том баймаар нэгэн саруул танхимд орж очлоо. Тэгтэл тэр танхимиын буланд бас нэг хаалга байх нь ёстой нөгөөх хайсан газар байх нь дамжигүй санагдав. Өндгөн төрөлт доош бөхийн уг заалсаар орж явчихлаа.

Эн бол хаалга, хана, тааз нь бүгд чулуунаас бүтсэн цэвэрхэн жижигхэн өрөө байв. Өрөөнд чулуун ор, чулуун сандал, чулуун ширээ, сандал гээд тэр чигтээ чулуун тавилга дүүрэн байх аж. Бас чулуун шүүр, бийр, янтай ч үзэгдэв.

Өндгөн төрөлт тэр бүтгийг тэмтрэн үзвэл бүгд чулуунаас бүтсэн хөдөлгөөнгүй зүйл байх ажээ. Тэр өрөөний өнцөг булан бүхнийг нэгжин үзсэн ч диваажингийн номтой төстэй гэмээр зүйл олж чадсангүй тул хэсэг гайхшран зогсож байгаад өмнөх том танхим уруу бушаж орлоо.

Тэгж байснаа танхимын хананд сонин хачин дурс байхыг гэнэт анзаарч тэрхүү тарниийн бичвэр нь жирийн номын адилаар биш харин чулуун ханан дээр сийлэгдсэн болохыг гэнэт ухаарах нь тэр.

Ариун гэгээн ном түүний өмнө байж байлаа. Өндгөн төрөлт догдолсондоо нудээ арчаад бичвэрийт уншихаар зэхлээ. Гэтэл хүжийн үнэр анхиллаа. Өөрөөр хэлбэл Бич харуул бас л цагаа ололгүй эргэж ирж байгаа нь тэр ажээ.

Өндгөн төрөлт тэр даруй бүхнийг умартан агуйгаас гүйн гаралд хонгил, гүүрийг дамжин балархай мөрийг мөшгин хар эрчээрээ хайрлагасаар овоохойдоо буцан ирлээ.

Тэгээд бүтэн жилийных нь хүлээлт, бэлтгэл талаар болсонд гутарсандаа цурхиран уйллаа. Тэгж байснаа шидэг тарниийн бичвэр тэр асар том агуйн танхимын бүх ханаар дүүрэн ярайж байсныг эргэн саналаа. Тэгвэл Бичний сүнсийг эргэн иртэл тэр бүхнийг хэрхэн тогтоож авах билээ гэж Өндгөн төрөлт бодлогоширлоо. Тэгээд бэх, цаастай байсан ч бичиж авч амжихгүйгээ ойлгоод мэгшүүлж байснаа сүүлдээ бүр цурхиран уйллаа. Өндгөн төрөлт ийнхүү бүтэн гурван шөнө, гурван өдөр зогсолтгүй уйлсан бөлгөө.

Тийн уйлж байтал хэн нэгэн гаднаас,

- Ийм чимээгүй газар шуугиан тарьж уйлаад байдаг хэн билээ? хэмээн хэлэхийг сонслоо. Өндгөн төрөлт толгой өндийлгөн харвал, урт цагаан сахалтай өвгөн зам дээр зогсон түүнийг харж байх ажээ. Сэтгэлээ нээх ханьтай болсон Өндгөн төрөлт овоохойноосоо үсрэн гарч хамаг юмаа уудлан ярилаа.

Түүний бүх яриаг сонссон өвгөн хамгийн сүүлд толгой дохин,

- Тийм ээ. Энэ бол үнэхээр хэцүү л дээ. Би ч нэг удаа тэр агуйд очиж байсан учраас бичвэр үнэхээр урт гэдгийг мэднэ. Гэхдээ чиний хувь тавилан хүрвэл тэр бүхнийг буулган бичиж авах хугацаа олдох нь мэдээж гэж өгүүллээ.

Өндгөн төрөлт өвгөнийг гайхан харах зуур цаадах нь яриагаа үргэлжлүүллээ.

- Би тийм богино хугацаанд тэр бүхнийг хуулах чадалтай бийр байдгийг мэдэхгүй юм. Харин нэгэн шидгэн наадал тэр их бичвэрийг дээр нь бүрхэх юм бол өөр дээрээ хувилж авдаг цаас байдаг тухай ярысан юм. Гэхдээ түүнийг хэрэглэх ёстой хүн нь хэрэглэх учиртай юм. Тэр хүн ариун тарнийг муу зүйлд биш зөвхөн сайн сайханд зориулах сэтгэлтэй байх ёстой. Хэрэв тиймгүй бол тэр цаас нь цагаан хэвээрээ үлддэг учиртай.

Өндгөн төрөлт дээрх яриаг сонсоод өвгөнд талархал илэрхийлэхээр харвал өвгөн аль хэдийн алга болчихсон байлаа. Тэр Өндгөн төрөлтөд нэг болтын итгэл найдвар, нөгөө болтын эргэлзэх сэтгэл төрүүлээд явж одсон байлаа. Одоо нэг бол бодлоосоо татгалзах, эсвэл дахин турван зуун жаран тав хоног хулээх хоёрын нэг үлдсэн байлаа.

Өндгөн төрөлт дахин овоохойгоо орхин замд гарч, хоол хүнс гүйн хэсүүчилж, мөргөл залбирлаа үйлдэн, сүсэгтнүүдэл чадлын хэрээр тус болон явлаа. Тэгсээр дараа оны тавдугаар сарын таван дөхөж ирэхэд мань хүн уулан дахь жижиг овоохойдоо эргэж ирэн гурав дахь оролдлогоо хийгээд үзэхээр зэхлээ. Тэр дахин хүчээ хураан зүрхээ чангаж нэг зуун ширхэг цав цагаан цэвэр цаас бэлтгэн бүтгийг нь нямбайлан дутаарлалаа.

Тав дахь өдөр ирж, хадан хошуу агуин амсраас хөдөлж эхлэхэд Өндгөн төрөлт аль хэдийн замдаа гарчихсан байв. Түүнийг гүүрэн дээр ирэхэд азарган бороо шаагъж байсан тул гүүрийн чулуу гөлийн халтиргаатай болж, үнэхээр явах боломжгүй болсон байв. Гэвч амьд хүн аргатай гэгчээр Өндгөн төрөлт цаастай үүргэвчээ нуруундаа зүүгээд гүүрийн доор орон гараараа гүүрээс зуuran зүүгдсээр аварга том аалз мэт ямх ямхаар урагш ахиж эхэллээ. Тэгсээр байж аймшигт хавцлыг туулаад хонгилыг зорилоо. Тэр хонгилд очоод өвдөг сөхрөн сууж тангарагаар өргөлөө.

- Өндгөн төрөлт хэмээх мөргөлчин миний бие хэрэв диваажингийн тарнийн нуущад нэвтэрч чадах юм бол түүнийг зөвхөн сайн сайхны төлөө ашиглана. Би үүнийг муу муухайд огтхон ч хэрэглэхгүй бөгөөд диваажингийн хүсэл зоригт нийцүүлэх болно. Хэрэв намайг энэ тангаргаасаа няцвал диваажин намайг шийтгэн орчлон дэлхийгээс устгах болтугай.

Тэрээр ийн хэлээд өндийн босч агуин зүг шуударлаа. Тэр амьсгаагаа ч дарж амжилгүй цагаан цааснуудаа гарган агуин ханан дээр нааж эхэллээ. Тэр агуин зүүн хананд арван турван ширхэг цаас наагаад гүйцээсэн ч баруун хана нь хавьгүй том, хорин дөрвөн цаас наасан ч дуусах өдий харагдаж байв. Тэгээд хорин тав дахь цаасаа боодлоос нь сугалтал хүжний танил үнэр сэнгэнэх нь тэр. Хэдий бүгдийг хийж амжаагүйдээ гутарсан ч бас ч гэж нэлээд ажил амжуулсандаа сэтгэл хангалиун болсон өндгөн төрөлт ашигласан цааснуудаа буцаан аваад цагаан цааснуудаа үлдээн яаран буцаж овоохойдоо иржээ.

Одоо шалгах цаг иржээ. Тэр бичвэрийн доторх нууцыг зөвхөн сайн сайхны тулд ашиглана хэмээн тангарагласан билээ. Түүнд тэрхүү

иуущад нэвтрэх хувь тавилан байгаа бол цаасан дээр бичвэр тодрон гарсан байх учиртай билээ. Хэрэв тиймгүй бол цаас цагаанаараа байх ёстой аж. Өндгөн төрөлт үүнийг шалгахдаа ялыгүй алгуурлав. Учир нь тэр санаснаар нь болохгүй байх вий хэмээн ихэд тутшиж байсан бөлгөө. Түүний зурх хүчтэй цохицсоор цаасан боодлыг задлан овоохойныхоо шалан дээр тараан тавилаа. Гэтэл юу болсон гэж санана. Цааснууд бүгд л анх худалдаж авсан шигээ цав цагаан байх нь тэр. Өндгөн төрөлт балмагдан сандарч цааснуудыг нарны гэрэлд сайтар харлаа. Тийм ээ. Цааснууд дээр үнэхээр ямар ч бичиг тэмдэг алга, хов хоосон байлаа.

Бүтэн хоёр жилийн зүтгэл, хүлээлт нь ийнхүү талаар болсонд Өндгөн төрөлт туйлын ихээр гашуудан газар сөхрөн унаж цурхиран уйлж эхэллээ.

Тийнхүү хэдэн цагийн турш уйлж байтал нэгэн хүний дуу гарч Өндгөн төрөлт сэхээ орлоо. Харвал мөн өмнө нь ирж байсан цагаан сахалтай өвгөн хэдэхэн алхмын зайд зогсож байх нь тэр.

- Энэ бүхэн бүтэшгүй зүйл байна. Би таны зөвлөснөөр хийсэн боловч болсонгүй. Миний хувь тавилан хүрсэнгүй. Бүх цааснууд цагаан хэвээр байна гэж Өндгөн төрөлт дуу тавилаа.

Тэгэлгүй яахав. Цагаан байх ёстой. Ямар тэдэн дээр бийрээр юм бичсэн биш. Гэхдээ би чамд нэг зүйл хэлээгүй орхичихсон байна. Тэр цааснууд тусгай бэхээр бүрхэгдсэн байдал бөгөөд дээр нь буусан бичиг өдрийн наранд харагддаггүй юм. Харин шөнийн сарны гэрэлд бол үзэгдэнэ. Тийм болохоор тэргэл сартай шөнийг л хүлээх хэрэгтэй дээ гэж өвгөн хэлэв.

Энэхүү хөндлөнгийн хүн Өндгөн төрөлтэд ийн хоёр дахь удаагаа урам өгсөн тул мань хүн тэргэл сартай шөнийг турван өдөр хүлээлээ. Тэгээд гурав дахь өдрийн орой овоохойныхоо хажуугийн шовх уулан дээр авиран гаралд хамаг цаасаа өвсөн дээр тараалаа. Сар ч мандан тэргэл болон тунгалагшлаа. Өндгөн төрөлтийн үгээр хэлж боломгүй баяслыг төрүүлсэн будэг бадаг үсэгнүүд ч цаасан дээр үзэгдэж эхлэх нь тэр. Тэргэл сартай шөнө мөнх үргэлжлэхгүй гэдгийг тэр тооцоолсон учраас бийр, бэхээр зэвсэглэсэн байв. Тэр цаасан дээрх үл уншиж чадах үсэгнүүдийн дурсийг хичээнгүйлэн тодруулсаар сар жаргахаас өмнө ажлаа дуусгалаа.

Тэгснийхээ дараа тэр өндийн босоод тэнгэр лүү ширгэн,

- Гэвч би нэг ч үт ойлгосонгүй. Миний мэддэггүй хэлээр бичсэн байна шүү дээ хэмээн хашгирлаа.

Тэгтэл хаяа нэгтээгээс мөнөөх хөгшин мөргөлчийн дуу хадаж,

- Ариун явдалт нагацыг хай хэмээн цуурайтах нь тэр.
- Ариун явдалт нагац эгч гэж хэн юм бол? Хаанаас хэрхэн олох вэ? хэмээн Өндгөн төрөлт давтан давтан хашгирсан боловч эргэн тойрон анир чимээгүй хэн ч хариу өгөөгүй билээ.

Тэр ариун нандин тарнийг уншиж чадах хэн нэгнийг олж чадах болов уу? Тэр хэн нэгэн нь Ариун явдалт нагац эгч гэдэг нь мөн юм болов уу?

Өндгөн төрөлт жаахан эд хогшлоо бөөгнүүлж аваад замд гарч тэр нэгэн хүнийг хайхаас өөр аргагүй боллоо.



Бичвэр

Мөргөлчин Өндгөн төрөлт уул хөндий, уужим тал, ус мөрнийг гатлан олон олон хот тосгодыг дамжин Ариун явдалт нагац эгчийг бэдрэн явлаа. Гэхдээ ингэж явахдаа Ариун явдалт нагац эгч үрүү улам дөтөлсөөр яваагаа хэрхэн мэдэх билээ. Тэгсээр түүнд нэгэн өдөр мэргэн санаа төрөв гэнэ. Өглөө нь хоноглосон буудлаасаа гарсан мань хүн ойролцоо тосгон дахь дэвүүр худалдааллаг дэлгүүр лүү яаравчлав. Өндгөн төрөлт тэндээс далдуу модны навчаар хийсэн томоос том дэвүүр худалдан аваад дээр нь “Ариун явдалт нагац эгчийг хайж байна” хэмээн томоор бичлээ. Ингэснээр эрлээ түргэтгэнэ гэж тэр тооцоолжээ. Үнэхээр ч мань хүн нэг их хол явах хэрэг гарсангүй. Ердөө л мөнөөх дэлгүүрийн эзэн түүнийг ийн бичиж байхад нь харчхаад гайхан дуу алдаж,

- Чи чинь бас л Ариун явдалт нагац эгчийг хайж яваа хүний нэг үү? Хэн түүнийг хайдагтүй юм бэ? гэх нь тэр.

Мэл гайхсан Өндгөн төрөлт, чи түүний тухай мэддэг гэж үү гэж лавлалаа.

- Мэддэг гэнэ үү дээ. Түүнийг мэддэггүй хүн харин байдаг гэж үү? Сүүлийн сард даяанчлан бадарчилж яваа лам бүхэн түүнийг зорьдог болсон. Түүний ятгалгаар Төгөлдөр Ян буюу Ахмад бурхан хоол хүнс түгээж байгаа. Та ч гэсэн аягаа дүүргээд авахад гэмгүй л байх.

- Тэр Төгөлдөр Ян, Ахмад бурхан гэдэг хаана байдаг хүн бэ?

- Эндээс хоёр өдөрчийн зайд Их Хуя уулын бэлд байдаг юм даа.

Энэ үед Ариун явдалт нагац эгч зөгнөлт үг биелэгдэх эсэхэд гайхан

догдолсоор он цагийг элээж байлаа. Түүний толгойд диваажингийн хатан хааны хэлсэн үт байнга эргэлдэх ажээ.

УЛИАС СААТУУЛНА.

ХАРИН ӨНДӨГ БҮГДИЙГ ТАЙЛБАРЛАНА.

ХАЙГААД ХЭРЭГГҮЙ ӨӨРӨӨ ОЛДОНО.

ХАЙСАН Ч ЦАГИЙН ГАРЗ.

Ян буюу Улиас түүнийг саатулсан гэдэгт тэр итгэлтэй байлаа. Харин өндөг цаг хугацааны дараа ирэх байх гэж тэр найдаж байв. Гэхдээ хайгаад хэрэгтүй, өөрөө олдоно гэдэг нь чухам ямар утга учиртай болохыг ману хүн үл ойлгох ажаам. Хайсан ч хaa хайхаа мэдэхгүй болохоор утгагүй мэт бодогдж байв. Гэхдээ л Төгөлдөр Яны гэрт байх ёстойгоо ойлгож байлаа. Гэхдээ өөрөө олдоно гэдэг нь чухам юу гэсэн үг юм бол? Ямар ч байсан сүсэг бишрэлтэй нэгэн нь л түүнийг хайж ирэх байх гэж Ариун явдалт нагац эгч таамаглаж байв.

Төгөлдөр Ян хайр харамгүй өглөг түгээж энэ тухай зар хodoод хоосон сүсэгтиүүдийн дунд ойн түймрээс ч хурдан тархаж, нэр алдар нь цууртайж буй нь Ариун явдалт нагац эгчид тустай хэрэг гэж бодож болохоор ажгуу. Хэрэв ийн өглөг харамгүй түгээвээс эхнэрийнхээ хамт диваажинд очих болно гэдэгт Төгөлдөр Яныг итгүүлэх тийм ч хэцүү бус байлаа. Ийнхүү өөрийг нь хайж ирсэн нэг ч хүнгүй байсаар бүтэн сар өнгөрсний эцэст хаалгач ирж нэгэн хүн зорин ирснийг дуулгавай.

Тэрхүү ирсэн хүний нэрийг Өндгөн төрөлт гэдгийг Ариун явдалт нагац эгч сонсоод бүрч ч их баярлалаа. Тийм ээ. Үнэхээр л тэр хүн өндөг нэртэй өөрөө олддог байна.

Түүний нүд нь сэргэж ирсэн ч тэрхүү хөндлөнгийн хүнийг болгоомжтой утгах ёстой гэж өөртөө хэллээ. Яагаад гэвэл тийм хүн ирснийг Төгөлдөр Янд хэльс гэвэл мөнөөх диваажингийн хатан хаантай уулзсан, хатан ямар уг хэлсэн тэр угэнд нь Төгөлдөр Яны нэр хүртэл орсныг нэгд нэгэнгүй тоочих ёстой болох нь мэдээж. Ариун явдалт нагац ямар их хэрэгт оролцож буйгаа мэдэхгүй байсан ч нууцыг заавал тайлан ойлгохыг эрмэлзэж байв.

Тийм хүсэл Өндгөн төрөлтийн цээжиннд ч мөн адил буцалж байлаа. Тэр удтал бодсоны эцэст өөрт нь тусалсан цагаан сахалт өвгөн бол Бичний сүнс өөрөө байсныг ойлгожээ. Өндгөн төрөлтийг үнэн сэтгэлээсээ зүтгэсэн зүтгэлийг Бичний сүнс агуйн хаалгач мэдээд өөрөө тусалж, тарниий номыг авахуулаад улмаар Ариун явдалт нагац эгч дээр авчирч буй бололтой. Гэхдээ одоо хэрэв Өндгөн төрөлт

нуруундаа үүрсэн үүргэвчин дэх тарниийн номын тухай нэг л удаа ам ангайвал бүх зүйл талаар өнгөрөх байсан байв.

Энэ аюулаас Ариун явдалт нагац эгч түүнийг аварлаа.

- Агуу их үйл хэргийн гэрч бол oo та минь! хэмээн Ариун явдалт нагац эгч инээмсэглэн чангаар өгүүллээ,

- Энэ мөргөлчин бол миний урыд дүрд ихэд сайн хандаж ивээн хайрлаж байсан хүн юм. Одоо та нар надал яж хандаж байна, яг л тэгж байсан хүн дээ гэж тэр өгүүллээ.

Өндгөн төрөлт энэ үгиээс юу ч ойлгосонгүй. Гэвч тэр үт дуутарсангүй. Учир нь тэр хоёрыг учруулсан энэ адал явдлын учир уттыг Ариун явдалт нагац эгч лав өөрөө тайлах биз, тийм болохоор чимээгүй л харж байя гэж тэр шийдсэн байв.

Тиймээс Бурхан Буддагийн агуу гайхамшигт нууцыг Төгөлдөр Яны хамтаар нэгэн дуугаар шагшин гайхаад урыд насынхаа явдлыг хоёулхнаа ярилцыа хэмээсэн Ариун явдалт нагац эгчийн саналыг хүлээн авлаа.

Тэгээд тэр хоёр хоёулхнаа үлдмэгц урьл эртээс өнөөг хүртэл тохиолдсон явдлын талаар бие биедээ дэлгэрэнгүй ярьж гарлаа. Яриа дуусаагүй шахам байхал түргэн зантай Өндгөн төрөлт ариун тарниийн номыг гаргаж ирэх гэсэн боловч Ариун явдалт нагац эгч түүнийг болиууллаа.

- Энэ хэргийг ганц цагт юм уу ганц өдөр хийгээд дуусчихдаг юм биш. Тийм болохоор бил маш анхааралтай төлөвлөгөө зохиох хэрэгтэй. Тарнийг судлахад олон сар шаардлагдана. Үүнд бас мөнгө хэрэгтэй болно. Түүнчлэн бидэнд бусдын тусламж хэрэгтэй. Гурван толгой хоёр толгойноос явч илүү хэмээн эмэгтэй өгүүллээ.

Тэр дээр цагт диваажингийн хатан хаантай уулзахын өмнө орхисон хүү Хар тавхайт нь ойролцоо нэгэн сүмд бийг Өндгөн төрөлтөд тайлбарлалаа.

Тэр хоёр Хар тавхайт уруу элч илгээн, дуудуулахаар тохиролцлоо. Мөн Хар тавхайтыг ирсний дараа гурвуулаа алсын нэг далд газар очин сэтгэл санаагаа ариуттан бясалгал хийхээр явна хэмээн Төгөлдөр Янд итгүүльс гэж ярилцаа.

Тэгээд энэ тухай Төгөлдөр Янд хэлтэл цаадах нь эхнэрийн хамт тун ч дурамжхан байлаа. Эр эм хоёр Ариун явдалт нагац эгчийн ярьдаг гэгээнтнүүдийн тухай домгийг сонсох туйлын дуртай байсан ба санскрит судрыг уншуулан баяслаг байсан болохоор тэр л дээ.

Ариун явдалт нагац эгч, Төгөлдөр Ян эхнэр хоёрт өөр нэгэн ертөнцийн нууцыг тайлж өгнө гэж амлаад өмнө нь хийж байсан шигээ

заан унасан Бодисадын хувилгааны дурд хүртэл хувилж үзэв.

Эцэст нь төгөлдөр Ян түүний хүснэгтийг хүлээж авснаар бараахгүй сайхан байр хүртэл гаргаж өглөө. Тэр нь Яны гэрээс холгүй орших хэд хэдэн өрөө бүхий сайхан байшин байлаа. Төгөлдөр Ян жилд өрөө байр түрээслэгчдээсээ мөнгөө авахдаа тэнд хэд хоног байрладаг байжээ. Тийм ч болохоор уг байранд гол зуух, хоолны агуулах, тавилга хэрэгсэл гээд бүх зүйл бүрэн байлаа. Байшин тал бүрээсээ ханаар хүрээлэгдсэн агаал шорын ганц хаалгатай аж. Тэр хаалгыг цоожлоод түлхүүрийг нь Ариун явдалт нагац эгчид хүлээлгэн өгчээ.

Төд удалгүй Хар тавхайт хүрэлцэн ирэхэд ээж нь хүүгээ Төгөлдөр Ян, түүний эхнэр, Өндгөн төрөлт гуравт танилцууллаа. Хар тавхайт байшиングийн буланд байсан дарсны тухай дараа нь эгчийнхээ тухай асуулаа. Тэгээд олон жилийн омнох түүхийг сонсоод Тан гүрний хатан хааны булшинаас хэрхэн амь гарсныг тайхан, эзжийнхээ яриаг шимтэн чагнаж байв.

Ийнхүү дахин нийлсэн ээж хүү хоёр Өндгөн төрөлтийн хамт ийнхүү хүний нүднээс далдхан нуутджад авлаа.

Тэгсний дараа Ариун явдалт нагац эгч бичвэрийг хэрхэн орчуулахаа төлөвлөн ярилаа.

- Энэ бичвэрийг орчуулан бичихэд чиний авчирсан цаас хэтэрхий том далbagар байна гэж тэр Өндгөн төрөлтөд хэлжээ.

Өндгөн төрөлт ч даруй явж, жижигхэн цааснууд болон дээд зэргийн чанартай бийр, бэх олж ирлээ. Тэгээд тэд сууцгаан Ариун явдалт нагац эгчийн хятал хэл үрүү орчуулан хэлэхийг Өндгөн төрөлт бичиж авсаар байв. Хар тавхайт энэ үед бэх сэлбэх, бийрийг бэхэнд дүрэх зэргээр бас л завгүй ажиллаж байлаа. Тэгсээр тэд орчуулгын ажлаа нэгэн шөнө, нэгэн өдрийн хугацаанд хийж барлаа. Ариун явдалт нагац эгч дараа нь бүх ажлаа нямбайлан шалгаж дуусаал Өндгөн төрөлтийн авчирсан нуушлаг хэл дээрх эх хувийг галд шатаалаа. Ариун нандин ном нэг л хувь байх ёстой хэмээн тэр үүнийгээ тайлбарласан болгое.

Тэднийг ийнхүү жинхэнэ судлах, сурх ажлаа эхлэхэд бэлэн болоод байхад Төгөлдөр Ян сүүлчийн удаа ирлээ. Тэр их хэмжээний мөнгөтэй хайрцаг тэвэрсэн зарцаа дагуулан иржээ.

- Та бүгдийг ариун үйлсээ бүтээхэд энэ тус болох болов уу гэж би найдж байна. Та бүхний бүтэн жилийн хэрэгцээг би хангана гэж Төгөлдөр Ян хэлсэн авай.

Үнэн хэрэгтээ тэдэнд зээлүүлсэн мөнгө тодий чинээ алт болно хэмээн Ариун явдалт нагац эгч амласан учраас Төгөлдөр Ян ингэсэн

бөгөөд хүү Хар тавхайт нь мөнгийг алт болгон хувиргадаг шидтэй юм байжээ. Ян тэдэнд дахин сайн сайхныг хүснээд өөрийнх нь ивээлд ийм сайхан ажил хийгдэж байгаад сэтгэл ханан бушлаа.

Хэрэв тэр мөнөөх гурвыг ном үзэхээр бэлтгэж байгааг харсан бол амаа ангайлган гайхах байсан биз.

Хамгийн эхлээд Ариун явдалт нагац эгч Хар тавхайтыг ертонцийн дөрвөн зүтгээс широо авчурулахаар явууллаа.

Түүнийг хойт, өмнө, зүүн, баруун зүтгээс авах ёстой агаад түүнийг авчирсан хойно Ариун явдалт нагац эгч уутанд хийгээд дээрээс нь есөн шидийн юмс нэмэрлэв. Тэр нь алт, сувд, мод, чулуу, талх, гурил, нүүрс, түлээ зэрэг байлаа. Тэгээд ханын дэргэд шивээ хана босгон түүн дээрээ гурван дэнлүү асаан байрлууллаа. Өмнө нь ширээн дээр бурхдын хөргийг залсан байв.

Дараа нь хэрэглэх ёстой цаас, бийр, бэхэндээ шид оруулах ёслол хийллээ. Тэр ёслолоор тэд долоон өдрийн турш өдөр бүхэн долоо дахин тарни бичин шившилэг хийллээ. Үүний хойно сүнснүүдийг дуудах цаг ирснийг Ариун явдалт нагац эгч дууллагаа. Тэрхүү сүнснүүд урьд өмнө нь хэзээ ч ердийн хүний дууллагаар ирж байгаагүй гэж Ариун явдалт нагац эгч нэмж тайлбарлав.

- Биднийг дуудахад тэд ирэх болов уу хэмээн Өндгөн төрөлтийг асуухад, хэрэв ирвэл бид яах болж байна хэмээн Хар тавхай нэмж асуулаа.

- Та нар арван эрхтнээ бүрэн захирдаг болсон цагт хэмээн Ариун явдалт нагац эгч хариулаад эдгээр эрхтнүүдэл хамарагддаг арван сүнс тэр үед дууллаганд ирэхээс өөр аргагүй болно. Тэд хэрэв аймаар харагдвал та нар айснаа үзүүлж болохгүй, харин их муухай дүртэй байвал шоолон инээх хэрэгтэй шүү. Тэд хүссэнийг чинь биелүүлэх болно. Харин буруу харьшвал буцаж ирэхээргүй явчхаж мэднэ шуу хэмээн Ариун явдалт нагац эгч нөгөө хоёртоо тайлбарлан хэллээ.

Тэгээд тэд Ариун явдалт нагац эгчийн заавраар тарни шившилэг уншицаар нэг, хоёр, гурван долоо хоног болжээ. Тэр үеэс хойш зарим шинж тэмдгүүд тухайлбал зэр зэвсгийн дурс үзэгдээл алга болох болов. Улмаар дерев, тав, зургаан долоо хоногийн шившилэгийн үеэр заримдаа ганцаараа заримдаа олуулаа сүнснүүд харагдсаар долоон долоо хоногийн эцэст бүх сүнснүүд цугларлаа.

Сүнс бүхэн олон дагуултай байсан боловч жижигхэн өрөөнд огтхон ч шахцалдахгүй байсан богоөд тэдний ард нь Өндгөн төрөлт, Хар тавхайт нар зогсож байсан бол өмнө талд нь Ариун явдалт нагац эгч

байж байлаа.

- Бид гурав бол бурхны сонгосон элч нар билээ хэмээн Ариун явдалт нагац эгч тэдэнд мэдээлээд бид нар диваажингийн нууц тарнийн ёсиг судлах болно. Үүнд та нар туслах хэрэгтэй. Ажил дууссаны дараа та нар байдаг газартaa бушаж очно. Тэр үед та бүхнийг шагнаж урамшуулах болно гэж хэлэв.

Сүнснүүд зөвшөөрч буйгаа хэлээд мэхийн ёслоод тарж одошгоо.

Гэвч Өндгөн төрөлт сүнснүүдийг захиран залахыг олон жил мөрөөдөж байсан хүн байжээ. Тиймээс мань хүнтэр шөнө харанхуйгаар ороноско босон өрөөндөө очоод шившлэг хийлээ. Гэтэл гэнэт тэнгэр нүргэлэх мэт дуу гаралт өрөөнийх нь ханан тушаа нэгэн аймшигт амьтан бараантан бий боллоо. Тэрхүү сүнсний нүд зэс мөнгө мэт эргэлдэн хацар нь ягаарч сахал үс нь сорвийн боссон аж. Хуяг дуулга нь алгаар түярах нь харагдав.

- Эзэнтэн минь. Таны дуудсанаар ирлээ. Юу гэж тушаах сан бол гэж тэр хүнгэнэлээ.

Хөөрхий Өндгөн төрөлтийн ам хатан зүрх нь дэлсэж юу хэлэхээ мэдэлгүй дээмий жаал холхилоо. Тэгж тэгж хашааны эргэн тойрны ханан дээр харц нь тогтлоо.

- Энэ хашаанд сүүдэрлэх газар алга гэж тэр хэлээд, Төгөлдөр Яны цэцэрлэгт буй жимсний дөрвөн модыг энд авчир гэж Өндгөн төрөлт хэллээ.

Сүнс нэгэнтээ бувтнаад алга болмогц асар хүчтэй салхи дэгдэн хавь орчинд галав юүлэх шиг болов. Хөөрхий муу Өндгөн төрөлт айсандaa аньсан нүдээ энэ бүхэн намдаж чимээ алдарсан хойно нээвэл Төгөлдөр Яны цэцэрлэгт байсан аварга том дөрвөн мод өмнө нь найгаж байх нь тэр.

Ариун явдалт нагац эгч үүнийг бас харжээ. Мэдэгдэхгүй байхаас аргагүй юм. Тэгээд Өндгөн төрөлтийг хатуу зэмлэлээ. Харин цаадах нь үүний хариуд, би ганц удаа л оролдоод үзсэн юм. Одоо дахиад тэгэхгүй хэмээн бувтанаасан белгэе.

Гэвч Төгөлдөр Яны цэцэрлэгийн дөрвөн мод алга болсон шуугиан дорхноо тархав. Салхинд хийсчихсэн бол ядаж мөчир навч нь ч үлдмээр юм даа хэмээн Ян чихээ маажин бодож зогстол хөгшин асрагч Ван гүйж ирэн нөгөөх моднууд Ариун явдалт нагац эгчийн хашаанд байж байгааг дуулгав.

- Хашааны эргэн тойрон хана босгон хаалгыг нь түгжсэн байх ёстой. Чи тэр моднуудыг тэгээд яаж олж хараа вэ гэж тэр өвгөн Ванаас

асуув.

- Моднууд хананаас гурав дахин өндөр болохоор харагдалгүй яахав. Өмнө нь тийм юм лав харагдаагүй дэг.

Төгөлдөр Ян энэ бол Ариун явдалт нагац эгчийн ид шидээр хийгдсэн зүйл гэдгийг ойлгоод зарцаа энэхүү үзсэн харснаа хэнд ч хэлэхгүй байхыг хүслээ.

Гэвч өвгөн Ван дахин нэг оньсоготой учирлаа. Учир нь Ариун тарний эхний хэсэгт эд юмыг өөрчлөн хувиргахыг заасан байсан учраас манай турван баатар Ван өвгөнөөс будаа, ногоо авчрахыг хүсэхгүй боллоо. Гайхсан Ван өвгөн агуулахаа үзвэл бүх зүйл урьдын янзаар байж байв. Тэгээд энэ тухай эзэндээ айлтгавал эзэн нь урьдын адил чимээгүй байхыг тушаажээ.

Ийнхүү бараг турван жил болоход манай турвын зорилго биелэх ойртсоор л байлаа. Тэл нар далан хоёр төрлийн шидэд суралцжээ. Хүн тус бүр үүл хөлөглөх, газар доор нутгдах, уулыг нүүлгэх гол мөрний урсгалыг өөрчилж чаддаг боллоо. Бүгд хүссэн дүрсэндээ хувирч чаддаг, ердийн гамбирыг дайчин эр болгодог, гал, ус, суманд ажирдагтуй шидтэй болжээ. Энэ бүхнийг ганцхан Бодисад хувилгаан нь л хийж чаддаг бөгөөд сэтгэл муутны гарг орвоос тун аюултай зүйл гэдэг нь мэдээж. Тийм ч учраас Ертөнцийн захирагч Цагаан бичийг тэрхүү тарнийн бичвэрийг хамгаалулахаар илгээсэн ажээ.

Гэхдээ тэр тарнийн нуущал нэвтрэгсэд жаахан дутуу орхих юм бол муу үр дагавар учирдаг юм санж. Тэгвэл Өндгөн төрөлт тухайн үед ариун бичвэрийг буулгаж авахдаа зарим хэсгийг орхисон тул тэр гурав олсон ид шидээ чөлөөтэй хэрэглэх болжээ. Тиймээс ч Хятадын хойт хэсэгт дайн дажин дэгдсэн бөгөөд Ариун явдалт нагац эгч, Өндгөн төрөлт, Хар тавхайт турвын нэр муугаар дурсагдсан буй заа.

Харин тэд тэр үед номоо дуусгаал явахдаа Төгөлдөр Янд талархал илэрхийлэхээ мартсангүй.

- Би түүнд өөрийнхөө хөрөнгийг мануулж байх бар өгнө гэж Хар тавхайтыг хэлэхэд,

- Бид түүнээс зөндөө мөнгө авсан шүү дээ. Тийм болохоор би энэ чулуун довцгийг алт болгон хувиргах болно хэмээн Ариун явдалт нагац эгч дуугарлаа.

- Сайн байна. Тэр алтыг чинь миний бар хамгаалах болно хэмээн Хар тавхайт хашигирлаа.

- Гэхдээ турвууланг нь дурсаж байг л дээ гэж Өндгөн төрөлт хэлээд,

- Би чулуун дээр бил гурвын дурстэй сийлбэр үлдээнэ гэлээ.

Эдгээр нь хамгийн тохирсон бэлгэ болно гэж тэр гурав тохиролцлоо.

Ариун явдалт нагац эгч шивлэг үйлдэн чулуун довцог уруу үлээгээд баруун гарсаа хүргэхэд чулуу алт болон хувирлаа. Хар тавхайт цаасаар барны дурс хайчлаад агаарт шидэн “хурдан” хэмээн хашгираа. Цаас газарт унангутаа хувиран, архиран ярзайсан амьд бар бий боллоо.

Бар минь, бар минь

Алт баялгийг

Амь хайргүй манаарай.

Хар тавхайт ийн тушаагаад барыг ахин цаасан хэлбэр оруулаад тэр цаасаа алтан довцгийн ёроолд байх агуй уруу хийлээ.

Дараа нь Өндгөн төрөлтийн ээлж болоход тэр зартай сайн барималчийн сүнсийг барин авчраад өөрсдийнхөө баримлыг хийлгэлээ. Тэрхүү баримал тэр гуравтай усны дусал шиг адилхан болжээ.

Ариун явдалт нагац эгч хатан хааны хэлсэн мэргэн зөгнөлд сая л бүрэн дүүрэн итгэлээ. Улиас, өндөг гээд яг таарчээ.

- Диваажингийн хатан хааны хүслээр бил учирсан билээ. Одоо түүний зарлигийг сонсоцгоо. Тэр налтай хорин найман жилийн дараа уулзья гэсэн юм. Тийм болохоор тэгж дуудтал нь бил хүлээх ёстой боллоо. Гэхдээ дуудсан цагт нь очижгүй бол хатан хааныг гомдооно гэдгийг хүн бүр санаж явах хэрэгтэй хэмээн Ариун явдалт нагац эгч хэллээ.

Тэр тийн хэлээд нөгөө хоёрыгоо доор үлдээн цэнхэр тэнгэрт уусан, нисч одлоо. Өндгөн төрөлт эд хэрэглэлээ агаарт шидэн хязгааргүй урт гүүр болгоод түүгээрээ өгсөн явж одов. Харин Хар тавхайт:

- Би лонхны диваажинд баймаар байна гэж хэлээд газарт гүн шигдсэн лонхны амсраар шурган алга болов.


Ийнхүү тэд алга болцгоосон агаад Төгөлдөр Ян ч тэр, зарц албатууд нь ч тэр тэднийг хэээч оролдоогүй юм гэдэг. Харин нэгэнтээ цэцэрлэгт явж байсан жаал хөвгүүн тэр гурвын баримлыг олж үзээд эн тухай Төгөлдөр Янд дуулгажээ.

Сайн нохдууд нь үхээгүй, харин мөнхийн царцмал амьдралд байгааг Ян олж үзээд хөөрөн баясчээ. Тэдний ариун гэгээн ажил дууссан бөгөөд алтан довцог бэлгэ болгон үлдээснийг Төгөлдөр Ян олж үзлээ.

Эрчүүд улмаар алтан довцгийг өнхрүүлэн Яны гэрт аваачихаар цуглараад гар хүрмэгц дотроос нь аймшигт бар үсрэн гарч ирж тэдний сүнсийг зайлцуулах шахжээ. Тарж зүтгсан эрчүүд эргэн харахад бар баарал

сураггүй болсон байж. Дахин оролдвол дахин тийм зүйл тохиолдсон тул алтыг тэр хэвээр нь орхисон агаад алтан довцгийн нүүрэн талд хэзээ нэгэн цаг амьдарч байсан хачирхалтай гурвины амьд мэт баримал дурс харагдан байх болжээ.

Тэр цагаас хойш хорин найман жил өнгөртөл энэ байдал огтхон ч өөрчлөгдсөнгүй ажээ. Харин хорин найман жилийн хойно тэр газарт аялагчдын нэг мөнөөх баримлаас хэлтэрхий ч үлдэлгүй бутран алга болсныг олж үзсэн байна. Тэгэхэд тэнд шаасаар хайчилсан барны дурс хэвтэж байсан гэнэ.



Монхжин

Диваажингийн хатан хаантай учирсан тэр нэгэн түтшүүртэй уулзалтаас өмнө, Ариун явдалт нагац эгч бодол санаанд алга болсон охин нь л байлаа. Тэр хаана байна, өөрийгөө ирээдүйд хэрхэн бэлтгэж байгаа бол? Гэвч түүнээс ямар ч сураг гарсангүй.

Үүнд гайхах явдалгүй юм. Учир нь охин амьд хүмүүсийн орчлонг аль хэдийн орхин оджээ. Тэр одоо авран гурван настай охин болж дахин төрсөн аж. Тэвчээргүй зангиийнхаа уршигаар ийм байдалд хүрчээ. Эрчилсэн шуурга шуурсан тэр нэгэн шөнө хар салхи дэгдэн, эхээс нь салгаж агаарт хөөрөн авч явжээ. Айж эмээсэн охин салхинд эргэлдэх хооронд чихэнд нь дараагийн үгс тод сонсогдоо:

“Болж буй явдаас бүү ай.

Цаг нь ирэхээр чи хатан хааны суудалд сууна.”

Эцэст нь хар салхи түүнийг зөвлөн тэгч газар буулгав. Охины сэтгэлээс сая олж сонссон үгс үл гарна. Тэр Зүүн гүрний нийслэлийн нэгэн нарийхан гудамжинд зогсож байлаа. Хааны ордны гялттансан дээвэр тэндээс харагдана. Тэрээр заль мэх, цэцэн цэлмэг үт ашиглан орлонд орж, улмаар хан хүүгийн өргөөнд нэвтэрлээ. Хоромхон зуурын энэ айлчлал нь түүний аминд хүрчээ. Сайхан зөgnөлд автсан охин хэрэг явдлыг хурдаасгаж, хан хүүг өөртөө татсанаар хэзээ нэгэн цагт хатан хаан нь болох байх гэж найдсан аж. Гэтэл хаяны ордны сахиус бурхад түүний гоо үзэсгэлэнтэй хүн төрхөнхүү хуурtsангүй. Түүний ил шидтэй үнэг гэдгийг тэд мэдэх билээ. Тийм үнэг хан хүүд хор уршиг тарина гэж тэд үзэх аж. Харанхуй шөнөөр охин хан хүүгийн өргөөнд ормогц, өрөөнд их гэрэл цацарлаа. Харуулууд юу болсныг харахаар гүйж ирэхэд, хан хүү тайван нойрсож байв. Харин өрөөний буланд үхсэн жижиг үнэг хэвтэнэ.

Түүнийг ордныхон гаргаж шатаалаа. Ариун явдалт нагац эгчийн

охины сүнс аль хэдийн дахин төрөхөөр замаа хөөж одсон аж. Ордонд гарсан учир битүүлэг явдлаас хойш удалгүй Зүүн гурний нийслэлийн иргэн Ху овогтой баян худалдаачны эхнэр охин төрүүлж, түүндээ Мөнхжин гэдэг нэр хайлжээ.

Он жилүүд Өнгөрч Ариун явдалт нагац эгч, Хар тавхайт хүү Өндгөн төрөлт хоёрыг орхин суралтасарсан охиноо сайтар хайхаар шийдлээ. Илбийнхээ хүчээр охины сүнс Ху овогтны гэрт байгааг мэдэж авав.

“Царайлаг, сайхан хүүхэд байна. Гэвч тэр Пэичоу хот дахь уйл явдалд оролцохын тулд илбийн ухаанд суралцах хэрэгтэй.”

Ингээд Ариун явдалт нагац эгч охиныг ид шидэд хэрхэн уруу татан оруулах талаар арга ухаан сийлж эхлэв. Илбэ нь зовлонд унasan, өлсгөлөнд нэрвэгдсэн, аюулд байгаа хүмүүсийн анхаарлыг татдаг билээ. Гэтэл худалдаачин Ху овогтын гэр бүлд эд хөрөнгө, нэр төр гээд дутах зүйл үтгүй тул Мөнхжин далд шидийн ухааныг сонирхогчийн нь лавтай.

Тэгтэл Ариун явдалт нагац эгч дараах арга мэхийг бодож оллоо. Тэр хэдхэн үлээхэд л худалдаачны дэлгүүр, агуулах, гэр орон нь шатаж, Ху овогтны гэр бүл ядуурлын туйлд хүрлээ. Өвлийн дунд сар байсан бөгөөд газар дэлхий цасанд хучаастай. Гэрийн эзэн хуучин нөхдөөсөө тусламж гүйхаар гадагш гарлаа. Түүний эхнэр охин хоёр муу оромжиндоо сууж үлдэв. Гэвч тэд тэвчихийн аргагүй их өлсөв.

- Охин минь, чи гараад улаан будайн боорцог хэдийг худалдаж аваад ирээч. Эс тэгвээс чи бил хоёр авааг чинь ирэхийг үзэхгүй юм шиг байна. Миний дэрэн доор хэдэн зэс зоос байгаа. Бидэнд өөр юу ч үлдсэнгүй. Түүнийг аваад ямар нэг илэх юм олж ирээч гэж хатагтай Ху гунигтайгаар өгүүлэв.

Олдсон найман зэс зоосоо гартаа атгасаар ноорхой хувцас, цоорсон гуталтай Мөнхжин цасан дундуур алхав. Хотын гудамжны цас хайлж, шавхай болж хувирчээ. Охин булан тойрохдоо хальтирч унав. Түүний хувцас ус шавхайтай холилдож, гартаа аттаж явсан зооснууд нь газраар нэг тарлаа. Найман зоосноос нэг дутаж, түүнийгээ удаан гэгч хайсан ч олдсонгүй. Даарч чичирсэн охин боорцогны наймаачин дээр орж гартаа байгаа бүх мөнгөө атуулав.

- Нэг зоос нь хонхойсон байна, тэрнийг чинь би авахгүй гэж хэлээд тэр зургаан боорцог л өглөө.

Бүсээ хонхойсон зоосны дундах нүхээр сүвлэн гаргаж аваад, Мөнхжин буцах замдаа гарав. Хол явж амжаагүй байтал нэг гартаа таяг, нөгөө гартаа сагс барьсан эмгэнтэй тааралдлаа.

- Охин минь, чи сая юу худалдаж авсан бэ? гэж тэрээр шүдгүй амаа хөдөлгөж асуухад охин ч түүнд авсан боорцгоо үзүүлэв.

- Би өчигдрөөс хойш хэлэн дээрээ юм тавысангүй. Чи надад нэгийг өгөөч гэж эмгэн гуй.

Мөнхжин өөрөө хэчинээн их өлсөж байсан ч настангаас эмээхдээ нэг боорцог өгөв.

- Охин минь, би нэг боорцонд цадсангүй. Үлдсэнээ бас надад өгөөч гэж эмгэн гуйлаа.

Мөнхжин хариуд нь ээжтэйгээ хамт өлбөрч үхэхийн даваан дээр байгаагаа, яаж нэг зэс зоосоо гээсэн, өөр нэг зоосыг нь худалдаачин хотойсон гэж голоод аваагүй түүхээ ярьж өгөв.

- Тэгвэл чи наад боорцгоо өөрөө ав даа. Надад хэрэгтүй. Чиний сайхан сэтгэлтэй эсэхийг л шалгасан юм. Чи үнэхээр өрөвч охин юм. Надад өгсөн боорцогны чинь оронд би тус хүргэнэ ээ. Хотойсон зоосоо гаргаад ир дээ гэж настан хэлэв.

Мөнхжин зэс зоосыг бүснээсээ сугалан гаргалаа. Эмгэн түүнийг гартаа авч нэг үлээгээд буцааж өгөв. Зэс зоосны хоттор арилж шинэ мэт гялалзана.

- Хөөх, ямар гайхалтай юм бэ! Та надад наад аргаа заагаад өгөөч гэж Мөнхжин дуу алдан өгүүлэв.

- Энэ бол өчүүхэн илбэ төдий юм. Хэрвээ чи надаар ямар нэг юм заалгая л гэж бодож байгаа бол үүнийг уншаарай. Энэ номонд олон янзын хэрэгтэй зүйл зааж бичсэн байгаа. Гачигдалтай үедээ номоо нээж суралцаарай. Ойлгомжгүй юм гарвал Ариун явдалт нагац эгч гэж дуудагтун. Би чамд туслах болно. Харин чи юу хийж байгаагаа хэнд ч бүү мэдэгдээрэй гэж хэлээд эмгэн сагснаасаа час улаан даавуунд боосон жижиг ном гаргаж охинд өгөв.

Мөнхжин номыг авч талархаад, хэд алхаж байгаад эргэж харваас настан агаарт ууссан мэт алга болсон байлаа. Охин өөрт үлдсэн мөнгөө хадгалахаар шийджээ. Гэртээ хариад ээждээ хоёр зэс зоосоо цасанд гээчихсэн гэж хэлэв. Тэр хоёр боорцгоо идэх зуур ноён Ху ирж, хуучин зарц байсан хүн нь турван зуун зэс зоос өгснийг баяртайгаар мэдэгдэв.

Гэвч мөнгө ганц хоёр өдөртөө л хүрэлцээд, байдал бүр дордов.

- Гачигдал гэж үүнийг л хэлэх байх, бяцхан ном бидэнд яж туслахыг харья гэж Мөнхжин өөртөө шивнэв.

Шөнө дунд охин орноосоо босч, номоо цонхон дээр тавиад сарны тэрэлд уншив.

Номын эхний хуудсанд “Мөнгө арвижуулах нь” гэсэн гарчиг харагдав. Илбийн аргыг уншваас ингэж өгүүлжээ.

“Ямар ч хамаагүй нэг уяа юм уу буч авч зэс зоосонд сувлэ. Үүдэндээ гаргаж тавиад саваар тагла. Гартаа аяга ус барин хуудасны төгсгэлд бичсэн шившлэгийг долоон удаа давт. Газар тавысан сав уруугаа балга ус цацаал “Хурдан!” гэж хэл.

Мөнхжин хотторыг нь засуулсан зоос,nom боосон туузыг ашиглан илбийг туршиж үзэв. Тэр мөнгө тагласан шилийт сөхөж үзвээс үнэхээр мянган зэс зоос туузанд мушгирсан могой мэт байж харагдлаа.

Мөнхжин маш их баярлав. Гэвч эцэг эхдээ энэ мөнгийг хаанаас авсан гэж хэлэх вэ? Тэр хаалгаа чимээгүй нээж, гадаа цасан дээр зооснуудаа тавив. Нууц ивээн тэтгэгч тэдэнд шене мөнгө орхиж гэж харагдуулах гэсэндээ хатагтай Ху өглөө босод хаалга онгойлгоод, гадаа хэвтэх мөнгийг олоод яг л тэгэж бодлоо. Ноён Ху харин гэнэтийн бэлэг хаанаас гарч ирснийг олох гэж толгойгоо гашилгав. Түүний эхнэр дэмий юманд санаагаа зовоохгүй байгаач гэж нөхрөө зэмлэв. Ноён Ху монгороор түлээ, будаа, ногоо худалдаж аваад их л сэтгэл хангалаун байв. Дараагийн шене Мөнхжин илбээ давтаж, аав нь ахиад л учрыг нь олох гээд чадсангүй.

Хандивын гэж ойлгосон мөнгө удалгүй дуусч, ноён Ху хуучин нийз нараасаа, эхнэр нь хөршүүдээсээ тусламж гүйхаар явжээ. Гэртээ ганцаараа үлдсэн охин номоо дэлгээд, хоёрдугаар хуудсанд юу гэж бичсэнийг уншлаа. Энэ удаа “Будаа арвижуулах нь” гэсэн гарчиг гарч ирэв. “Тэнгэр газрын ивээлээр билд будаагаа арвижуулаад байвал хоосон хоноход хүрэхгүй” гэж Мөнхжин бодлоо. Заавар нь яг л урьдын илбэтэй адил байв. Тэр хэдхэн ширхэг будаа үлдсэн шуудайг үүдэндээ тавиад дээрээс нь өөрийн хувцасаараа бүтээлээ. Шинэ шившлэгийг уншаал, амандаа балгасан усаа түүн дээрээ цацаал “Хурдан!” гэж хэллээ. Тэтгэл юу болсон гээч! Хуучин шуудай задарч гал тогооны өрөөний шалаар нэг будаа асгарав. Будаа эссеөр л. Охин сандран орилвоос хажуугийн байшинд байсан ээж нь юу болж буйг үзэхээр гэр лүүгээ гүйж ирэв.

Гаднаас хүн орж ирэхэд илбэ зогслоо. Мөнхжин өрөө дүүрэн будаа хаанаас гарч ирснийг тайлбарлан ядна. Аргаа бараахдаа тэр гаднаас нэг өндөр хүн орж ирээд, томоос том шуудай дүүрэн будаа асгачхаал, үгний зөрөөгүй гаралд явчихсан гэж тайлбарлав.

Хатагтай Ху охиныхоо ярьсанд итгэв. Харин ноён Ху энэ удаа хууртсангүй. Тэр Мөнхжинд үнэнээ хэлэхийг шаардаж, эс тэгвээс саваагаар зодно гэж сүрдүүлэв.

Ноён Ху, түүний хачирхалтай охин хоёрын тэмцэл үүгээр эхэлсэн билээ. Зодуулахаас айсан охин авдаа бүх үнэнээ ярж өгчээ. Түүнийг сонссон ноён Ху галзуурах дөхөв. Ид шид гэх мэт хориотой зүйлээр оролдсон хүнийг захирагч нар хэрхэн шийтгэдгийг тэр мэдэх тул, уг дуутуй номыг зуух уруу шидэж шатахыг нь харж зогсов. Охиндоо харин болсон бүх явдлыг март гэж хэлжээ.

Хэлэхэд амархан ч хийхэд хэцүү. Хандивласан мөнгө, шидэг будаа ч дууслаа. Тэл урьд өмнийхөөс илүү хэцүү байдалд оров. Хатагтай Ху гэр бүлдээ туслах гэж байсан охиндоо ширүүн хандлаа гэж нохрөө зэмлэв. Хоосон ходоод, хуурай амын эрхэнд орсон ноён Ху охиноосоо номыг нь шатаасанд училал гүйж, мөнгө болон будааг арвижуулахад хэлж байсан шившлэгээ санахыг гүйлаа.

Мөнхжин энэ хооронд гэртээ гарсаа хумхин суусангүй. Тэр заасан ёсоор Ариун явдалт нагац эгчийг дуудаж түүнээс тусламж хүсчээ. Хөгшин шидтэн түүнд дараах аргуудыг зааж өгчээ. Хaalга, цонхoo онгойлголгүй гэрээсээ хэрхэн гарах, модон савааг яаж өөрийн унтаж буй дүр төрхөнд хувиргах, хулс унан үүлэн дундуур Ариун явдалт нагац эгч дээр хэрхэн очих гэх мэт элдвийн шид.

Аав нь охиноо өдөр дуудаад, урьдаа шившлэгээ санаач гэхэд нүдээс нухалсан Мөнхжин өгүүлсэн нь:

- Таныг хүсвэл би оролдоод үзье. Намайг үг хэлэх зуур та сандал дээр сууж байгаарай хэмээв.

Ху ноён ч сандал дээр суув. Мөнхжинг “Хурдан!” гэж хэлэхэд аав нь сандалтайгаа дээш хөөрлөө. Хөөрхий ноён Ху таазанд толгойгоо цохиод даруйхан буулгахыг хүсэв.

- Намайг учлаарай. Миний санаж байгаа цорын ганц илбэ олстөлен гэдсийг шаттахгүй нь гэж Мөнхжин өгүүлэв.

Гэвч тэр хийсэн хэрэгтээ гэмшиж, аавыгаа буулгаад хоёр уяа нэг зоостой бэлдүүлэв. Гэтэл ноён Ху хөрхон биш, нэг зуун уяагаар илбэдэхийг хүсэв. Гэрт нь ийм олон байхгүй тул төв гудамжны худалдаачин дээр очиж сураглав.

- Надад нэг зуун уяа байгаа. Гэхдээ та түүгээр яах гэсэн юм бэ? гэж асуув.

- Зоос сүвлэх гэсэн юм аа гэж ноён Ху хариулав.

- Баяр хүргэе. Та их мөнгтэй болжээ дээ. Уяанууд энэ байна, үнэ нь хорин зоос гэж наймаачин өгүүллээ.

Гэтэл ноён Худ төлөх хорин зоос ч байсангүй. Тэр мөнгөө сүүлд нь егье гэхэд дэлгүүрийн эзэн зөвшөөрсөнгүй. Эцэст нь тэр гэртээ хариад

хоёр уяагаараа илбэдэж сурав.

Өдөр бүр уяанд хэлхээн зоос, гал тогоо дүүрэн будаатай болжээ. Мөнхжингийн илбийн ухаан сайжрах тутам авынх нь шунал ихэссээр л. Тэр оронцог болсон гэрээсээ нүүж, олон сайхан цэцэрлэгтэй том байшинд оржээ. Охиныхоо далд авьяасанд хянахаа ч больж. Гэтэл нэг өдөр ноён Ху лангун дээрээ тавих хоргойгоо арвижуулахыг заалгахаар Мөнхжинг хайв.

Охин гэртээ байсангүй, удаан хайсны эзэст хамгийн жижиг өргөөнд ортол Мөнхжин аяга усны хажууд өвдөглөөд сууж байлаа. Тэр улаан хулуу авч, дотроос нь олон жижиг улаан үр гаргаад газар асгав. Дээрээс нь тайрсан сүрэл асгаад, шившлэгээ хэлсний дараа аягтай ус авч балгаад “Хурдан!” гэхэд, гэнэт улаан хувцас өмссөн тут жадтай хоёр зуун морьтой дайчин эрс гарч ирэн жагсацаав. Туйлын гайхсан ноён Хугийн нүдэн дээр охин нь цагаан хулуу авч, мөн л дотроос нь цагаан үрийг нь гаргаж газар асгалaa. Түүн дээрээ тайрсан сүрэл хийж шившээд ус балгаад “Хурдан!” хэмээвээс өмнө нь цагаан хувцастай хоёр зуун морьтой дайчин эрс зогсоно. Мөнхжин үсний зүүлтээ аваад үнэт сэлэм болгон хувиргаад түүгээрээ дохио өгөхөд, хоёр тал байлдаж эхлэв. Цэцэрлэгийн талбай хэдий жижиг ч дөрвөн зуун дайчин эрс дотор нь уujuухан багтаад тулалдаж байв.

Ноён Ху энэ бүхнийг тэвчиж харж чадсангүй. Тэр гэртээ гүйж ороод гал тогооноос хурц заадуур авчрав. Гэтэл тоглож дууссан охин цэргүүдийг хулууны үр, үрийг бушааж хулуу болгосон байлаа. Ноён Ху түүний араас нь ирээд, охиндоо сээрмжлүүлэлгүй заадуураар агаарт даллав. Мөнхжингийн хүзүү оногдож, толгой нь газар унав. Айж сандарсан ноён Ху бие болон толгойт бутны ард нууж, цэцэрлэгийн хаалгыг түгжлээ. Түүний сэтгэл өдөржин өвдсөөр, орой өлрийн гүнит түүхээ эхнэртээ ярьж өглөө. Хатагтай Ху гайхшран:

- Чи хээээ нийм аймшигт хэрэг үйлдсэн гэж? асуув.
- Өнөөдөр, яг үд дунд гэж тэр хариуллаа.
- Хатагтай Ху санаа нь амарсан шинжтэй,
- Тэнд хэн унтаж байгааг очоод хараач гэж хэлээд охиныхоо ёрөө үрүү дагуулан явлаа. Мөнхжин эсэн мэнд орон дээрээ унтаж байв.

Тэр нүдээ нээгээд,

- Аав аа, та миний хүзүүг ямар чанга цохив оо гэж хэлэв.
- Учир битүүлэг охиноосоо тийм ч амар салахгүйгээ ноён Ху ухаарлаа. Хээээ нэгэн цагт хэрэг явдал илрэх юм бол гэр бүлээрээ хатуу шийтгүүлэх тул ноён Ху охиноо хурдан гэрлүүлж гэрээсээ холдуулахыг

хүсэв. Ноён Ху юмны нарийн учир ойлгохгүй Чиао нэртэй тэнэг эр олж, Мөнхжин дуртай дургүй түүнтэй суув. Эхнэрийнхээ үйлдэх шидийг хараад гайхах ухаангүй тул Мөнхжин гэртээ дуртай илбээ үзүүлдэг байлаа. Тэгтэл зун болж халуу шатав. Мөнхжин нөхөртөө өндөр газар гарч, сэргүүцэх үү гэхэд Чиао зөвшөөрөв. Хөөрхий залуу хүний хэлснийг л дагадаг нэгэн билээ. Тэд сандал дээр сууж, эхнэр нь шившлэгээ амандаа уншив. Тэгэхэд их гэрэл цацарч, сандал дээшээ хөөрөн хот дундуур ниссээр хамгийн өндөр байшин болох харуулын цамхаг дээр буулаа. Сэргүүн салхи таатай үлээж, Мөнхжин торгон дэвүүрээр сэвнэ.

Тэдний доор эргүүл хийж яваа хоёр харуул ярилцана.

- Хөөс, тэр цамхгийн орой дээр юу байна аа? гэж нэг нь асуув.

- Хоёр хэрээ юм уу даа гэж ногөө нь таамаглав.

- Үгүй байх аа.

- Тэгвэл тэдний нэг нь яагаад далавчaa дэвээд байгаа юм бэ?

- Далавч биш ээ, тэр чинь дэвүүрээр сэвж байгаа эмэгтэй байна шүү дээ.

- Эмэгтэй хүн ч бай, хэрээ шувуу ч бай, энд байх зохисгүй. Нум сумаар харваад үзье л дээ.

Харуул ингэж хэлмэг нум сумаа авч харвав. Хөөрхий Чиао гуяндаа сум зоолтоостой доошоо унаж ирэх нь тэр. Ингээд хэрэг манджээ! Мөнхжин илбийнхээ хүчээр гэртээ эргэж харьсан ч Чиао шүүгчил байшагдан, ганцаараа биш эхнэртэйгээ цамхаг дээр сууж байсан нь тогтоогдлоо. Мөнхжинг олж ирэх зарлиг буув.

Аргаа барсан бүсгүй Ариун явдалт нagaц эгчээс тусламж хүсэв. Тэр Зүүн гүрний нийслэлийг орхиж, Ариун явдалт нagaц эгчтэй хамт амьдрах болсондоо туйлын баяртай байлаа. Мөнхжин ганцаараа Чэнгчуо хот орж заалгасан худагны дэргэд очив. Тэр худагны ирмэг дээр гишгэн доошоо үсрэв.

Худаг дотор ямар ч ус байсангүйд тэр гайхсангүй. Мөнхжин унасан ч үгүй, тэр зөвлөн гэгч агаарт хөвсөөр худгийн ёроолд буулаа. Харанхуй байв. Тэгтэл хүлээж байсан охидууд гарч ирээд Мөнхжинг тосч авав. Тэд харанхуйгаас гарч, хоёр талдаа ховор мод ургасан, гялтганасан эрдэнэсийн чuluун замаар дагуулж явсаар газар тив дээр хаана ч байхгүй тансаг орлонд ирцгээв. Хээнцэр хүлээн авалтын танхимд Ариун явдалт нagaц эгч охиноо уттаж авахаар зогсох аж.



Гурван анд

Чэнгчоу хот дахь Мөнхжингийн үсэрч орсон худагнаас холгүй орших хөл хөдөлгөөн ихтэй нэгэн гудамжинд Жэн нэртэй нарийн боовны худалдаачин аж төрдөг билээ. Махны наймаачин Чанг, гоймонгийн худалдаачин Ву, Жэн гурав сайн андуул бөгөөд турвуулаа том биетэй, хүчтэй, арилжаа наймааны ухаанд гаралтай аж. Жэн урд өдөр нь зарах нарийн боов, мантуугаа жигнээд, маргааш өглөө нь эртлэн босч тэдгээрээ гудамжинд дэлгээд суулаа. Ирээд удаагүй байтал баларчлан явдаг ламтны хөгжим дууллав. Харваас намхан, хиртэй уранхай хувцастай, толгойгоо ороож боосон салбархай даавууны цаанаас ургаж зууралдсан үсээ цухуйлгасан нэгэн ламтан доголсоор ирлээ.

“Чамд аз жаргал,
Эд хоронго хүсэн ерөө.
Надад ганц зэс зоос л
Өөч хайрлагтуун!”

Тэрээр ингэж хэлээд Жэний өмнө очиж зогслоо.

- Ламтан та яасан эрт морилж байх юм бэ? Надад танд өгөх үлдэгдэл хоол гаралтай байна. Мөн ганц зэс зоос ч алга даа гэж нарийн боовны худалдаачин өгүүлэв.

- Беөрөнхийлсөн будаа чинь ямар үнэтэй вэ? гэж ламтан асуув. Тэр бол яхын аргагүй Хар тавхайт мөн байлаа.

- Том нь хоёр, жижиг нь нэг зоос. Та хоёр зэс зоос л өгчих, тэгээд аль алинаас нь нэгийг ав даа гэж Жэн санал болгов.

- Томыг нь ээждээ өгнө өө гэж Хар тавхайт хэлэв. Түүний хумс

хирээр дүүрсэн болохыг Жэн анзаарав. Тэрээр цавцайсан цагаан боөрөнхийлсон буудал болтол нь гартаа базаад хэлсэн нь:

- Эзж минь наян настай. Ийм хатуу хоолыг яаж даахав. Оронд нь бууз өгөөч.

- Одоо наад буудал чинь хэн ч авахгүй дээ гэж Жэн үглэн үлдэгдэл хоолны тавганд хийлээ. Тэр жигнүүрээс бууз авч ламтанд өгөв.

- Дотор нь юу хийсэн бэ? гэж асуунгуутаа балиар гартаа атгав.

- Дээд зэргийн үхрийн мах гэж Жэн хариуллаа.

- Манай эзж мах иддэгтүй. Оронд нь боорцог өгчих.

Төвөгтэй ламтангийн салахын түүс болсон Жэн хагарсан буузаа үлдэгдэл хоолны тавганд хийгээд, хүссэнээр нь боорцог өглөө. Гэтэл тэр мантуу авьяа хэмээв. Уур нь хүрсэн Жэн:

- Та хоёрхон зоос өгчхөөд миний турван янзын хоолыг үрэгдүүллээ! Боорцог аваад явж үз гэж хашхиран хөөв.

Хар тавхайт явахынхаа өмнө Жэний зарж байгаа хоол уруу сэмхэн үлээчхээд явлаа. Худаалдаачны санаа амрав. Гэтэл тэр хоол тавьсан ширээгээ хараад нүдэндээ итгэсэнгүй. Бууз, мантуу, нарийн боов нь бүгд шатсан түлээ мэт хар болсон байв. “Тэр муу ламтангийн хийсэн ажил! Би түүнийг барина даа!” гээд Жэн хойноос нь гүйлээ.

Гэвч хэргийн эзнийг гүйцэж чадсангүй. Хариугүй буцахын даваан дээр танил хөгжим сонсгодов. Жэн тэр зүг үрүү очтол, махны наймаачны үүдэнд олон хүн цугларсан харагдана.

“Чанг наймаачны муҳлагийн тэнд яагаад хүмүүс цугласан юм бол?” гэж тэр гайхширав.

Ойртож очвоос настайвтар эмэгтэй газар хэвтэж харагдав. Хажууд нь хүү нь болотой нэг залуу сэрээх гэж оролдоно. Эцэст нь тэр босоод, хүүгээ наалаад, орь дуу тавьсаар явлаа. Жэн найзаасаа учрыг асуув.

- Ийм наймаа байх ч гэж! Дөнгөж сая нэг доголон ламтан ирээд,

“Чамд аз жаргал,
Эд хөрөнгө хүсэн ерөө.
Надад ганц зэс зоос л
Өгч хайлрагтун.”

гэж хэлэв. Би түүнд өглөг өгөхөд дэндүү эрт байна аа хэмээвээс тэр урлаж, миний муҳлагт орж ирлээ. Тэгээд ширээн дээр байсан хатагтай Тигийн захиалсан гахайн толгойнд гарваа хүргээд нэг юм бувтнав. Энэ хооронд хатагтай Ти захиалсан юмаа авахаар ирлээ. Гэтэл тэр гахайн

толгойнд гарсаа хургэмэгц, тэр нүдээ нээж харснаа хатагтайг хазчихав! Тэгээд тэр ухаан алдсан юм гэв.

- Наад ламтан чинь ёстой мангас юм аа гээд Жэн өөрт тохиолдсон бүхнээ Чангд ярив.

Тэр хоёр хамтарч ламтангийн араас хэдэн цаг хөөсөн ч олсонгүй. Ингэсээр тэд гоймонгийн худалдаачин Ву дээр ирлээ. Тэнд бас нэг юм тохиолдсон харагдav. Ву өөрийн туслах залуут зодож байлаа.

- Чи наад залуугаа яасан гэж зодоо вэ? гэж Жэн Чанг хоёр нэгэн дуугаар асуув.

- Миний үйлчлүүлэгчид ирээд л яваад байна, гэтэл энэ муу залхуу амьтан галаа асааж чаддаггүй. Үүнээс болж би ганц таваг гоймон ч чанаж чадсангүй!

Нарийн боовны худалдаачин, махны наймаачин хоёр нэгэн зэрэг:

- Танай дээр нэг доголон, заваан ламтан өглөг гүйж ирсэн үү? гэж асуухгаав.

- Тийм ээ, түүүн ирээд явсан. Та хоёр яагаад энэ талаар мэдэхийг хүсэв. Би түүнд огех юм алга гэхэд тэр үг дуугаралгүй гаралд явсан. Гарахлаа зуух уруу нэг үлээсэн юм. Аан, би одоо л юу болсныг ойлголоо! Ингэхэд гэмгүй хүн зодуулж байна шүү дээ!

Ву үгээ хэлж дуусав уу, үгүй юу нөгөө ламтны хөгжим ойрхон дуулдлав. Гурван найз нэг хүн мэт зэрэг босоод урд нь зогсох ламтанг барьж авахыг завдав.

Доголон ламтан гүйшгэлэхгүй хурдан гүйсээр хотоос гарлаа. Нэг мэдэхэд бүгл дацангийн гадаа иржээ. Ламтан тийшээ гүйж оров. “Одоо л нэг баригдах нь” гэж гурван найз баярлаад хойноос нь оршигоо. Дацангийн голд Будда бурхны том баримал байлаа. Ламтан түүний гарцаар дамжин мөрөн дээр нь гарч, толгойноос зууран,

- Бурхан Будда, намайг авраач! гэж орилов. Баримлын толгойноос зуурахад толгой тасарч унаалаа. Хар тавхайт Буддагийн гэдсэн дотор гүйж орлоо.

- Одоо чи баригдлаа! гэж Чанг хэлээд баримлын гарцаар дамжин хүзүүн дээр гаралд доошоо өнгийж харав. Тэгтэл хүзүүнээс гар гарч ирэн Чангийг хөлиноос нь татаж, баримал дотор оруулав.

Жэн баримлын хүзүүн дээр гарч зогсоод найзыгаа дуудавч хариу сонсогдсонгүй.

Түрүүчийн гар гарч ирэхэд Чанг:

- Ноёнтон, би таны араас дагахаа больё. Танд хэчинээн бууз, мантуу хэрэгтэйг асуухаар би ирлээ гэж аргаа баран хэлэв.

Гэвч гар нарийн боовны худалдаачныг хөлнөөс нь барин доош орууллаа. Гойモンгийн худалдаачингийн өвдөг чичирсээр зогсоно. Тэр бас л найз нарынхаа адил доошоо оров.

Буддагийн баримал дотор тас харанхуй. Түүний хөл нэг зөвлөхөн юман дээр буухад,

- Чи над дээр гишгээд байна шүү дээ! гэж Жэн орилов.
- Чанг, чи хаана байна?

Чанг хариу дуугарав. Ламтан харин аль хэдийн алга болжээ. Гурван наиз цаашаа явцгаавас гэрэл гарч, том чулуун хашааны хаалга нээгдэв. Түүний цаана уул ус, ой мод, тариан талбай байх бөгөөд Жэн, Чанг, Ву нар явсаар нэг жижиг байшигт олж харлаа. Дотроос нь сайхан зантай настан гарч ирээд, ядарч өлссөн хүмүүсийг хоол ундаар дайллаа. Найзууд эрлээ үргэлжлүүлэхийн даваан дээр ногөө ламтан өөрөө орж ирэхэд бүгд түүн үрүү дайрлаа. Гэтэл гэрийн эзэгтэй энэ бол миний хүү гэв. Тэр эмэгтэй бол Ариун явдалт нагац эгч, хүү нь харин Хар тавхайт болж таарав. Худалдаачид болсон явдлаа ярихад авхай хүүгээ загнаж, училт гүйлгав. Тэгсэн ч гэсэн гурван найзуудын сэтгэл гонсгор хэвээр л байв.

- Та нарын гомдлыг барагдуулахын тулд миний хүү сурсан эрдмээсээ үзүүлнэ ээ. Та бүгд нэр хүнд бүхий хүмүүс болох тул хэдэн илбэ заалгахад илүүдэхгүй биз гэж Ариун явдалт нагац эгч хэлэв.

Худалдаачлал түүний үг таатай санагдлаа. Хар тавхайт хулуу гаргаж ирээд, гартаа барин “Хурдан!” гэж хашгирахад давалгаалсан их ус болж хувирав. Гурван найз “Гайхалтай!” гэж шагшрав. Хар тавхайт илбээ буцаасны дараа дахиал “Хурдан!” хэмээвээс хулуу дотроос их гал асч эхлэв. Найзууд ахин гайхамшигийг шагшрав.

- Ламтан ах аа, наад хулуугаа надад өгөхгүй ю? гэж махны наймаачин гүйв. Ариун явдалт нагац эгчийн зөвшөөрөхөд, Хар тавхайт шидээт хулуугаа бэлэглэв.

Тэр өөр нэг илбэ үзүүлж эхлэв. Цаасаар морь хайчлан газар тавиад шившлэг уншив. Эцэст нь “Хурдан!” хэмээвээс цаас цагаан адну болж хувирав. Хар тавхайт морио унаж давхичхаад буухад, морь буцаад жирийн цаас болов.

- Та нарын хэн үүнийг авмаар байна? гэж Хар тавхайт асуув.
- Би авья гэж Ву хурдан хэлэв. Ингээд морь түүнд очив.
- Манай гурав дахь хүн юу авах вэ? гэж Ариун явдалт нагац эгч хүүгээсээ асуув.
- Яг одоо миний толгойнд юу ч орохгүй байна гэж тэр хариулав.

Энэ хоромд гаднаас дахин нэг хүн орж ирлээ. Пиэти авхай өөрийн охин Мөнхжинг танилцууллаа.

- Надад нэг санаа байна гээд сандал авч, бас л шившилэгний тусламжтайгаар бар болгож хувиргав. Түүнийгээ унаж тэнгэрээр давхилаа. “Доошоо!” гэхэд бар буцаж ирээд дахин сандал боллоо.

Жэн энэ илбийг заалгаж авлаа.

- Та бүгд илбээ давт даа гэж Ариун явдалт нагац эгч хэлэв. Бүгд даалгавраа амжилттай биселүүлсний дараа Ариун явдалт нагац эгч өгүүлэх нь:

- Надад та бүгдээс гүйх зүйл нэг байна. Удахгүй Пиэчоуд уулзацгаая. Та бүгд тэндээс их буян хишиг хүргэх болно гэж амлав.

Гурван анд очихоо андгайлав. Хар тавхайт тэднийг гэрт нь хүргэж өгөхөөс өмнө бас нэг хүнтэй уулзацгаав. Шар нөмрөгтэй, чихэндээ алтан ээмэгтэй хамба лам ирж бүгдийн амрыг эрээд түүний холос харсан гал, ус, нисдэг морь, бар ямар учиртایг лавлан асуув.

- Хамба лам минь, бүү хилэгнэгтүн. Манай хүүхдүүд шинэ найз нартаа илбээ зааж өгсон юм гэж Ариун явдалт нагац эгч тайлбарлав.

- Надад илбээ үзүүлээч гэж хамба лам хэлэв.

Гурван анд хэлснээр нь болоход тэр илбийг нь өчүүхэн гайхамшиг гээд тоосонгүй.

Чанг хамбаас та тэгвэл бидэнд өөрийн шидийг үзүүлээч гэж гүйв.

Хамба лам юу ч хэлэлгүй баруун гарсаа гаргав. Түүний хурууны үзүүр бүрээс тэнгэр өөл алтан туяа цаашарч, туяа бүрийн үзүүрт Будда бурхан харагдлаа.

Жэн, Чанг, Ву гурав үг дуугүй агуу их шидтэний өмнө бөхийн ёсolloо.



Шулмыг дарсан нь

Шилдэнгүүд цугласан нь цаг хугацаа ойртсоныг илтгэж байлаа. Диваажингийн хатан хааны Пеичоуд болох үйл явдлын тухай зөгнөн хэлсэн зүйл биеллээ олоход тун дөхөж байв. Ариун явдалт нагац эгч энэ хэдэн жилийг тун ч их тэвчээртэй хүлээсэн ажээ. Харин одоо бүхэл бүтэн мужийг сүйрэлд оруулахаар завдаж эхлэв.

Тэр Мөнхжинг Пеичоу уруу илгээв. Гашуудлын цагаан хувцас өмсөн гартаа сагс барьсан эмэгтэй зөрөн өнгөрөх эрчүүдийн харцыг булаам үзэсгэлэнтэй харагдаж байв. Зоригтой нэг нь түүнийг хашаа явж байгааг асуухад,

- Хөөрхий нөхөр минь нас барсан учир амь зуулга залгуулахын тулд зарим зүйлээ зарах хэрэгтэй байна гэв.

- Зарах зүйл чинь тэгээд юу сан билээ?

- Түм түжигнэж бум бужигнасан зээлийн газар зайд гаргаж өгвөл би та бүхэнд үзүүльье гэлээ. Түүний хүслээр болж, Мөнхжин сагсаа доош тавив. Тэрээр нэг аяга усаар дүүргэхийг гүйхад хэрэгт дурлаж зогссон нэг нь түүний гүйлтиг биелүүлэв. Мөнхжин хутгаар газрыг ухаад сул шороог аваад нүхэнд ус хийв. Тэгээд зуурсан шавраар арван лаа хийлээ.

- Одоо миний лааг тус бүрийг нь турван зэс зоосоор худалдан авах уу? гэтэл түүнийг хүрээлэн зогссон олон чангаар инээлдэв.

- Шавар лаанууд хэнд хэрэгтэй юм бэ? Үүний хариуд бүсгүй ойр хавийн мухлагаас бамбар аваад лаануудад хүргэхэд тэд эрдэнэсийн

гэрлээр цацрав. Алмайрсан олон тэдгээр гайхамшигтай лааг гурван зэс зоосоор авахын тулд зодолдож, Бодиства ч өөрийн арван лаанаас бүрдэх наймаа дууссаны дараа яваад өгөв. Дараагийн өдөр тэр дахин зээлээр үзэгдэж, цугласан олон өдрөөс өдөрт нэмэгдсээр хот даяар түүний тухай мэдээ тархлаа. Эцэст нь түүний хайж байсан эрийн сонорт гайхамшигт лааны тухай мэдээ хүрэв. Хайж байсан эрийг Van Цэ гэх бөгөөд мужийн цэргийн захирагч тэрбээр б тохой өндөр, ханхар цээжтэй, төрөл бүрийн зэвсэг гаргууд эзэмшил нэгэн байлаа. Түүний багад эцэг эх нь нас барж, бага наасаа хэцүүгээр өнгөрүүлсэн түүнийг лав сайнд хүрнэ гэдэгт хүмүүс эргэлзэг байв. Харин энэ өдөр тэр гудамжаар сэлгүүцэнгээ шидэгт лааг гурван зоосоор зардаг эмэгтэйн хэр хөөрхнийг харахаар шийдэв. Тэрбээр цугласан олны дундаас урагшлан гарч ирээд өдрийн багц болох арван лааг бүгдийг худалдан авч хүмүүст тараан өгөв. Мөнхжин сагсаа авч явахад цэргийн захирагч түүний холоос дагав. Хот, хаалга, цаашлаад талбайгаас хоёр гурван бээр газар хөтлөн дагуулав. Цааш удаан явсан Van Цэ тэсгэлгүй бушаж явахаар завдан, эргэн тойрноо ажтал эгц өндөр уулс хүрээлэн байсан нь түүнийг төөрсөн байсныг илтгэлээ. Гэнэт Мөнхжин түүний хажууд инээмсэглэсээр хүрч ирэв.

- Таныг энд ирүүлэх гэж хэр зэрэг хугацаа орсныг мэдэх үү? Одоо харин миний ээжтэй танилцах цаг болжээ гэв. Гэв гэнэт тэд нэгэн байшигийн өмнө очиход түүний өмнө хээнцэр хувцастай, сурвалжит байрын настай авгай зогсож байлаа. Ариун явдалт нагац эгч,

- Van захирагч сайн явж байна уу? гэхэд хариуд нь Van Цэ мэхийв.

- Чи энэ дэлхий дээр гав ганцаараа. Чамд тусlamж хэрэгтэй учир энд авчирсан юм. Ийм сайхан эрд тохирсон сайн эхнэр хэрэгтэй. Би өөрийн охиньг чамтай гэрлүүлэхээр төлөвлөж байна хэмээв.

Van Цэд үүнээс өөр хүсэх зүйл байсангүй. Тэгээд сүйт бүсгүйн ах Хар тавхайтын тусlamжтайгаар гайхамшигтай хуримын ёслолд оролцохоор толгой эргэн явлаа. Тансаг хийцтэй нөмрөг, ховор идээ будаагаар дүүрэн бас ордны гоёmsog авхай нар дүүрэн байв. Van Цэ ч энэ завшаанаар угсаа гарлын тухай дурьлахад Ариун явдалт нагац эгч:

- Энэ зөв өө, сурвалжит болохын тулд чи бүх газрын захирагч байх хэрэгтэй гэж хариулав.

- Гэхдээ би чинь тосгоны цэргийн жирийн нэг ахлагч шүү дээ. Би хэрхэн хааны удамтай болох билээ? гэж Van Цэ эргэлзэв.

- Бидний тусlamжтайгаар чи бүх зүйлийг хийж чадна. Чиний эхнэр болох миний охин тушаалаа хүлээж байгаа зуун мянган цэрэгтэй. Van

Цэ инээж өгүүлэх нь:

- Зуун мянган цэргийг тэжээх үр тарианы агуулах, зэр зэвсгээр хангах зэвсгийн агуулах хэрэгтэй шүү дээ. Хараад байхад энд тийм зүйл харагдахгүй байна даа гэж хэлэв. Мөнхжин:

- Миний цэрэгт хоол ч, зэвсэг ч хэрэгтгүй. Би чамд үзүүлье гээд хоёр бяцхан хайрцааг авч, тус бүрээс шош болон зангиdsan сүрэл гаргаж ирэхэд тэдгээр нь хоёр зуун хүчирхэг, эр зоригт хороо болон жагсаж байв. Хязгааргүй az жаргалаар бялхсан Van Цэ хайрт эхнэрийнхээ дэргэд гурав, дөрөв хоносны дараа Peichoу уруу буцаж очиhoor шийдлээ. Түүнийг Хар тавхайт дагалдахаар болов. Удалгүй тэд Van Цэгийн бяцхан оромжинд оронгутуут хаалганы цаана хүн ирэх чимээ гарч, хаалга тогших сонсгодов. Van Цэ гадагш гартал цэргийн хуарангийн ахлагч хэдэн эрийн хамт ирсэн байлаа. Хуарангийн ахлагч тун сэтгэл дундуур байдалтайгаар,

- Peichoу мужийн захирагч гэж харамч хөгшин, хар амиа л бодох юм. Зургаан мянган цэрэгт ирэх сарын хөлсийг нь өгөхөөс татталзсан. Тэгтэл тэд хэрхэн амьдрах вэ? гэхэд Van Цэ:

- Бид одоо явал зохих вэ? гэж асуулаа.

- Бослого, үүнээс өөр арга зам алга!

Van Цэ сонссон бүхнээ Хар тавхайтад дамжуулахад тэр хариуд нь:

- Өөрийн бүх цэргүүдээ маргааш өглөө гэрийн гадна жагсаа гэлээ. Залуу ч түүний хэлсний дагуу өглөө цэргийн хуарангаас цэргээ гарган гэрийн зүг дагуулан ирэв. Хар тавхайт түүнийг гэрийн гадаа утгаж байлаа.

- Будаагаа даах хэмжээгээр өөрсдөө ав гэж хэлүүлэхэд гайхсан Van Цэ:

- Тэр их будаа чинь хаана байгаа билээ? хэмээвээс гэрт чинь байгаа гэсэн хариу сонсов. Van Цэ харваас гэрийн бүх өрөө цагаан будаагаар дүүрсэн байв. Цэрэг эрс ч Van ахлагчийн тушаасны дагуу үйлдэв.

Үдийн алдад харгалзагч нар ирэн, Van Цэг мужийн амбаны өргөө үрүү авч явав.

- Van ахмад аа, таны үйлдлийг би хэрхэн ойлгох вэ? Зөвхөн би л хуарангийн цэргүүдэд хувь хүртээх учиртай. Муу ахлагч чи миний эрх мэдлийг хууль бусаар булаан эзлэх хэн бэ? гэж захирагч ууртай нь аргагүй хэлэв.

Van Цэ хариу хэлэхийг завдтай харгалзагч нар цоожтой төв агуулахаас мянга мянган уут будаа хулгайлагдсан тухай мэдээлэв. Амбан захирагч:

- Болжээ, засгийн будааг хулгайллан цэргүүдэд нуушаар тараана гэнэ ээ. Түүнийг гянданд хориод учрыг нь олж хужрыг нь тунгаахаас нааш түүнийг бүү гарга! гэлээ.

Ингээд Ван Цэг баривчлав. Шийтгэлийн хунд хүчрийг даахгүйгээс айсан тэр гулдчин явахдаа алдагдсан үр тариаг хар шидтэнээс авсан гэдгээ хүлээн зөвшөөрөв. Тэр Хар тавхайтыг дүрслэн хэлж, харгалзагч нар ч түүнийг баривчлахаар гарав.

Энэ хооронд Хар тавхайт цэргийн хуаранд цэргүүдийг цутлуулаад, гэмт амбан захирагч өөрөө засгийн үр тариаг хулгайлж, нуушаар худалласан буруугаа Ван ахлагч дээр тохooж байгаа тухай ярьж байлаа. Тэр тэдний төлөө өөрийн амийг цөлж байгаа Ван Цэг чөлөөлж, амбан болон түүний захираганы эсрэг босохыг уриалав. Цэрэг эрс Хар тавхайтыг уухайлан дэмжсэн боловч Ван Цэг чөлөөлохөөр мужийн амбаны өргөө үрүү халдаж зүрхлэхгүй байлаа.

- Үүнийг надад даалгачих, гэхдээ Ван ахлагчийг өөрсдийн толгойлогч гэдгийг тангараглахад бэлэн байгаарай гэж Хар тавхайт зааварчлав. Тэгээд өөрийн баривчлагдахыг хүлээлгүйгээр захирагаа орж өөрийгөө тушаав.

Хар тавхайтыг Ван Цэгийн хэвтэх гянданд аваачив. Эхний хулс Хар тавхайтын нуруун дээр буухад гайхалтай нь тэр ясан ч угүй. Харин гяндангийн харгалзагч өвдсөндөө ёлж гарав. Хоёр дахь харгалзагч мөн л түүний адил цохиулав. Төдөлгүй бүх харгалзагчид ёлж гарав. Хар тавхайт шившлэг уншаад гав дөнгөө мултлав. Суллагдсан Ван Цэтэй хоёул амбан захирагчийн өргөө үрүү хурдлав. Тэднийг чөлөөлөгдсөнийг хараадаа ухаан алдтал айж, нуугдахыг завдсан золгүй захирагчийн толгойт Ван Цэ илдээрээ цавчин хаяв. Тэгээд тэр өргөөний хаалгыг нээхэд түүний 6000 цэргэг давалгаа мэт түрэн орж ирэв. Тэд захирагчийн албаны харуул, цэрэг болон түшмэл, гэр бүлийг хүйс тэмтрэн хоол хүнс, мөнгө, эрдэнэсийг булаан авав.

Тэр хооронд өргөөнөөс зутган гарсан 2 цэргэг Зүүн гүрний нийслэлд очин Пеичоуд бослого гарсныг мэдээлэв. Хаан бослого даруулахаар байлдаа урлаг гаргуун эзэмшсэн Лиу Иен-веи жанжинг 5000 цэргийн хамт илгээв. 5000 цэргэг дагуулан баривчлахаар ирж буйг сонссон Ван Цэ яахаа мэдэхгүй сандрахад Хар тавхайт, Мөнхжин нар түүнд туслах учир амар амгалан байхыг зөвлөв. Дайн дажинд дургүй Өндгөн төрөлт энэ үеээр хотыг орхиж, дашанд суухаар явжээ.

Лиу Иен-веи өөрийн хүчийг 1000, 3000, 1000-аар хуваахад Ван Цэ нэг хэсгийг хотоо хамгаалулахаар нөгөө хэсгийг харин 2 хуваан

дайсантай тулалдуулахаар үлдээв. Лиу Иен-вэи туршлагагүй, мөн дээр нь хол замыг туулсан байсан учир Пэичоу хотод орж ирэнгүүт Ван Цэгийн хүчинд бут цохиулав. Энэ үеэр Лиу Иен-вэи нь Туан Леи ахлагчид даалгавар өгөв. Туан Леи нууцаар 2 салаа явган цэрэг болслого гаргасан хуаран уруу илгээж төмөр хуяг дуулга гялалзуулан багахан хүнтэй дохөж очингуут түүнийг Лиу Иен-вэи өөрөө гэж итгэсэн Ван Цэгийн цэргүүд ухасхийн давхив. Тэр хооронд Туан Леин явган цэрэг хуаранг галдахад, сандарсан Ван Цэгийн цэргүүдийн тэн хагас нь Туан Леид цохигдов. Үлдсэн нь арайхийн буцаж ирэнгүүт Ван Цэ ихэд почирдсон нь илт байлаа. Гэвч Хар тавхайт түүнээс 500 цэрэг өгвөл Лиу Иен-вентэй нэгийгээ үзэлцье гэлээ. Удалгүй хааны цэргүүдийн ирсэн мэдээг сонсмоги Хар тавхайт цэргээ дагуулан гарч шидээлэсэн шуурга босгосноор дайснаа дарлаа. Ялагдсан Лиу Иеэ-вэи турван өдрийн дараа ямар ч элс шигэхээргүй дуулгаар цэрэг болон морьдоо тоноглов. Дараачийн удаа Хар тавхайт зэрлэг араатнууд гаргаж ирэхэд, хэсэг цэргүүд мөн л хиар цохиулав. Лиу Иен-вени морьдоо араатны хаан арслангийн зурагтай эллэлээр тоноглон авч явлаа. Гэтэл Хар тавхайт дэвүүрээ нэг далайлгаж хүйтэн салхи, хар үүл бүрхүүлэхэд Лиу Иен-вегийн 5000 цэргээс хэдхэн зуу нь л үлдэв. Тэдгээр цэрэг нь ядарч туйлдсан байв. Учир нь Мөнхжин хий харанга дэлдэж түгшүүр зарласан нь тэднийг ийн сандралд хүргэжээ.

Хааны зүдэрсэн цэргүүд буцав. Пеичоуд харин баяр хоор болж Ван Цэ нь Зүүн гурний энхийг сахиулагч хааны цолыг авч, Мөнхжин ч хатан хаанаар өргөмжлөгдөв. Хар тавхайт гүнтний суудалд сууж, Пиэти авхай өөрийн тусгай ордонтой болж, түүнчлэн дайнд оролцоогүй Өндгөн төрөлт хүртэл хувь хүртжээ. Жэн, Чан, Ву нар хотод ирж ажилд орох гэсэн хүсэлтэй олон түмэн иргэдийг дагуулж авчирлаа. Шинэ хаан зугаа цэнгэл, хууран мэхлэлтээс өөр юм мэдэхээ байв. Хотын эрдэнэс хангалтгүй санагдаж түүний албатууд шунаг хааны хүслийг хангахаар хулгайн гарсаа энд тэндгүй хүргэх болов. Хар шидийн ямар ч илбэнд гаргуун Хар тавхайт үргэлж дарс ууж согтуурсаар байв. Мөнхжин хатан хааны ямар ч үүргийг гүйцэтгэхгүй мөртлөө энгийн номхон иргэдээр тоглоом тохуу хийдэг болжээ. Хааны оройн зоогийн ширээг дээрмийн мал чимэх нь ердийн үзэгдэл болов.

Энэ явдалын тухай Өндгөн төрөлт мэдэх тусам ихээр гутарч байлаа. Тэнгэрийн ариун бичээст Ван Цэгийн болслого харамч шударга бус мүжийн амбангийн эсрэг чиглэхэд амжилт олно гэсэн ч, Ван Цэ үүнийг түйвуулан ашиглажээ. Хэрэг явдалд гутарсан Өндгөн төрөлт дацангaa

орхин явлаа. Псичноуд найр болж байхад Зүүн гүрний нийслэлд гашуудаж байв. Лиу Иен-веигийн мэдээг сонсоод байлдааны мэргэн аргыг эзэмшиэн Вен Ен-рог 100000 цэргийн хамт явулахаар болов. Ван Цэ түүнийг утаж хотын хаалтгыг нээлээ. Тэр өөрийн хүмүүсийн дээр хэрмийн хажууд зогсож байв. Түүний зүүн гар талд гоймонгийн худалдаачин Ву, нарийн боовны наймаачин Жэн, баруун гартаа махны муҳлагийн Чан хотын дээр хэнгэрэг дэлдэж байв. Мөнхжин өөрийн хамгаалагчдыг дагуулж ялагчийг хараахаар гарчээ. Вен Ен-ро цэргийн талд зогсож байлаа. Түүний хаалганы өмнө дөнгөж очингут Ван Цэ:

- Энэ нутгийн төр засаг доройтсон байсан тул би унагасан. Намайг улс орны энхийг сахиулж байхад харин яагаад эзэн хаан миний эсрэг цэрэг илгээнэм? гэхэд Вен Ен-ро:

- Чиний үйлдсэн гэмт хэрэг учлагдашгүй. Одоо чи миний цэргийн өмнө зогсож дийлэхгүй гэхэд,

- Тань шиг шударга хүн өтөл наасаа амар тайван өнгөрүүлсэн нь дээр байх даа гэж Ван Цэ тавлав.

Хилэгнэсэн Вен Ен-ро тулалдах тушаал өгч, бөмбөр цохин их цэрэг урагшлав. Гэтэл хар үүл гарч цахилгаан цахиж, ширүүн бороо орлоо. Мөн элдвийн араатан, чөтгөрийн царайтай дайчид гарч ирэхэд Вен Ен-рогийн цэргүүд ухрах нь ухарч, зутгах нь зутгаж, тулалдах нь тулалдаа.

Хааны цэргүүд цаашид хэрхэх талаар ярилцах зуур нэгэн эр босч ийнхүү зөвлөв.

- Би ч гэсэн энэ шидийг сурч байсан. Энэ шидийн эсрэг хонь, гахайн цус, адууны шээс болон сармис үйлчилдэг. Тэр нь илбийн хүчийг арилгахад тустай юм гэлээ.

Вен Ен-ро хойш нь тавилгүй тэр бэлдмэлийг бэлэн болгох тушаал буулгав. Зарлигийг ёсоор болгов. Бэлдмэлээс авч, бүх л сэлэм, жад, нум сумандaa түрхлээ. Тулалдааны өдөр нарийн боовны худалдаачин Жэн, махны муҳлагийн Чан, гоймонгийн наймаачин Ву хаандаа өөрсдийн юу чадагаа үзүүлэхийг хүсч тус бүр 500 цэрэгтэй давшив. Голд нь Ван Цэ, Хар тавхайтын хамт гол цэргээ удирдан явав. Гэтэл Хар тавхайтын ид шид үйлчлээгүй тул Ван Цэгийн хамт хот уруу зутгав. Вугийн шидээ морь цаас болоход Чаны хамт дайны талбайгаас арилав. Тэдний цэргийн хороо удалгүй хааны цэргүүдэд ялагдав. Жэн сандлыг бар болгон хувирган Вен Ен-рогийн нөгөө жигүүрийг устгахаар боллоо. Гэтэл түүний оролдлого бас бүтгэлгүйтжээ Жэн олзлогдов.

Тулалдаан үүгээр дуусав. Вен жанжны хамгийн их эмээдэг Өндгөн

терөлт хотоос явсныг Жэн олж мэдлээ. Тэр өөрөө одоо гянданц суух болов. Вен Ен –ро хотыг эзэлж авахыг хүссэн ч дэндүү олон мангас, зэрлэг амьтдаас болж хохирол их гарч байлаа. Мэргэн Вен Ен –ро хүртэл яахаа мэдэхээ байв. Шидэт үер, түймэр, шуурга, чөтгөр, зэрлэг араатан хотод дураараа дургиж, тэднээс маш муухай үнэр гарсан нь Тэнгэрийн хааны хамарт хүрлээ. Иймээс тэр өөрийн элчээ Пеичоу уруу тандуулахаар илгээв. Тэдний ярьснаар Цагаан үүлний агуйн ариун бичээст хамаг учир байлаа. Агуйн савдаг сармагчин учрыг тайлж, хүн терөлхтонд сайныг үйлдэнэ гэж хамбын хэлж байсныг ярив.

- Тэгтэл тэр өөрийн тангаргаа биелүүлсэнгүй гэж Тэнгэрийн хаан өгүүлэв.

- Эрхэм дээдэс ээ, түмэнтээ өршөөнө үү. Өндгөн төрөлт Пэичоуд болж байгаа үймэнд гар нийлж оролцоогүй. Энэ нь Ариун явдалт наагац эгч, түүний хар хүчийн үнэнгүүдээс үүдэлтэй билээ гэж Цагаан сармагчин тайлагнав.

- Цагаан сармагчин чи ариун бичээсийг хадгалах үүрэгтэй. Чи түүнийг хулгайд алдсан тул өөрийн биеэр энэ үймээнийг зогсоо.

Цагаан сармагчин хамгийн эхэлж Өндгөн төрөлтийг олохыг хүсв. Тэр Өндгөн төрөлтийг Алтан Улаан уулнаас олж, түүнд дайсны үнэн дүрийг гаргадаг Тэнгэрийн хаанаас гүйж авсан шидэт толийг өгөв. Өндгөн төрөлт талархлаа илэрхийлээд, Пэичоу уруу бушлаа.

Энэ үэр Мөнхжин нөхөртөө хааны жанжин Веэ Ен-рогоос салах арга зааж өгч байлаа. Тэр хотоос том тээрмийн чулуу зөвлөөд, түүнийгээ овоолоод дээр нь хаашаа очих зүг чигийг бичлээ. Мөнхжин шившлэгээ уншаад чулуун дээр ус амаараа цацаад “Хурдан!” хэмээв.

Вен жанжин дайснаа хэрхэг тухай ярилцаж байтал гэнэт дээрээс нь олон тээрмийн чулуу айсуйг харлаа. Гэтэл хэн нэгэн түүнийг хүчтэй гараараа зайлцууллаа. Хормын дараа түүний сууж байсан сандал аварга чулууны доор нэг тохой орчим гүн газарт шигдсэн байв.

Цэргүүдийнх нь хэн нь ч биш байсан тул Вен Ен-ро өөрийнхөө аврагчаас “Та хэн бэ?” гэж асуухад тэр эрэгтэй бийр гүйж аваад өөрийнхөө нэрийг бичив. Тэгснээ тэр цаасаа хуйлан эвхээд далд хийчхэв. Дараа нь гэнэт агаарт уусах мэт замхран алга болов. “Бас нэг чөтгөр” гэж цэргүүдийг хаширахад харин Вен жанжин тэр цаасан дээр бичсэн нэрийг уншиж амжжээ. Тэгээд “Зуун нүдэг” гэж бичсэнийг уншаад жанжин хэсэг зуур тээнэгэлzsнээ жилийн өмнө нэг хий үзэгдэл шиг хүний тухай зүүдэлснээ гэнэт санав. Тэрхүү зүүдэнд нь орсон хүн бол яг “Зуун нүдэттэй” адил байсан. Тэр бол их том хэрэг

хийснээсээ болоод тэнгэрийн орноос хөөгдсөн тул одоо учлалт гүйн өөрийнхөө толоо мөргөх мөргөлчдийг хайж яваа билээ. Вен Ен-ро өгөөмөр зантай хүн байсан тул өглөө сэргэцээ ойролцоо сүмд очиж Зуун нүдтийн төлөө түүнийг өршөөгөөч гэж залбирав. Дараа шөнө нь Зуун нүдэт түүний зүүдэнд дахин үзэгдэж Венд өөрийнх нь төлөө мөргөсөнд талархал илэрхийлээд цашид ч түүнд туслах болно гэж амлажээ. Одоо энэ амласан тусламж нь иржээ. Вен жанжин энэ хачин түүхийг цэргүүдээ яриад одоо тэнгэрийн орны сүнснүүд түүний талд байгаа гэдгийг бодоод баярлан инээд алдав.

Мөнхжин, түүний нөхөр болон дүү нь бүгдээрээ Ариун явдалт нагац эгчид туслахаар болжээ. Ариун явдалт нагац эгч Зүүн гүрний энхийг сахиулагч хаанд цэргүүдээ дахин удирахыг тушаав. Тэд хааны цэргүүдтэй Пеичоу хотын хаалганы дэргэд тааралдах үедээ тэднийг Ван Цэ өөрийн биеэр тэргүүлэн ирсэн ба Хар тавхайт, Мөнхжин, махны худалдаачин Чант болон гоймонгийн наймаачин Ву нар тэр хөгшин илбэчин эмэгтэй ямар ил шил үзүүлэх бол хэмээн бүгд анхааран ширтэж байв.

Бүрээ бөмбөрийн дуунаар Вен жанжны цэргүүд давшилтанд оров. Пиэти авхай цагаан морио яаралгүй урагш залав. Тэгнээ жадныхаа хүрц үзүүрээр арсыг нь цоо хатгаж цусыг нь аягатай усанд тосов. Тэгнээ устай холилдсон цусыг газарт цацан нэгэн шившлэг хэлснээ “Хурдан!” гэж хашхирав. Тэр дорхноо газар хөдөлж тэнгэр харанхуйлан цэргүүдийн дээр мөндөр асгаран буув.

Хааны цэргүүд үүнийг үзээд бужигнан сандрав. Вен жанжин зөвхөн мориноосоо унахгүй хичээхээс өөр арга байсангүй. Түүнд юу ч харагдахгүй, юу ч сонсогохгүй, юу ч үзэгдэхгүй болж зөвхөн унахгүй тогтох үлджээ. Гэнэт өмнө нь эрчилсэн хүй салхи үүсч мориных нь толгойн тушаа ирэхэл хүрц гэрэл өмнө нь гарав. Энэ гэрэл ямагт өмнө нь гэрэлтүүлж байсан тул тэрхүү гэрлийг дагаад явлаа. Ингэж тэрээр тулааны талбараас хэдэн мод газар холдоход энэ гэрэл түүнийг дагуулсаар хотын зүгт явсаар нэгэн жижиг боловч цэвэрхэн хийдийн хаалганы дэргэд ирэв. Вен жанжин мориноосоо буун хаалгаар оров. Нэг ламттан түүнийг ариун хутагтын дэргэд дагуулан авч ирлээ. Өндгөн төрөлт жанжныг нэрээр нь дуудан мэндлээд суухыг урьж цай аягалж өгөв.

- Та яаж миний нэрийг мэддэг билээ? гэж асуухад,
- Таны алдрыг эртнээс сонссон юм гэж Өндгөн төрөлт хариулаад үргэлжлүүлэв.

- Би таны морилон саатахыг хүлээж байсан юм. Гэхдээ тан шиг ийм агуу жанжин яагаад Пеичоугийнх шиг ийм газрын тулаанд амжилтгүй тулалдаад байна?

Вен Ен-ро түүний эсрэг ид шидтэй аргыг хэрэглэсэн тухай нэг бүрчлэн ярив.

- Би ийм төрлийн ид шидийг мэднэ. Тийм учраас танд тусалж чадна гэж бодож байна хэмээн Өндөн төрөлт хэлэв. Та энд тур амарч бай, дараа нь хоёул таны буудалласан газар хамт очь ё гэв.

Тэднийг очих үед хааны цэргүүд амь үрэгдэгсдээ тоолон явж байв. Тэд үнэхээр их хохирол амссан байлаа.

Дараагийн өдөр нь Ван Цэ дахин цэргүүдээ удирдан хотын хаалганы гадна ирэв. Ариун явдалт нагац эгчийн тусlamжтай тулааныг эцэс болгон Вен жанжны үлдсэн хэдэн цэргийг дарах зорилготой гарч ирцгээв.

Ван Цэ болон түүний туслагч нар урдын адил юу ч хийхгүй зөвхөн бамбайгаа барин харин Ариун явдалт нагац эгч шагаан морио хотөлсөөр гарч ирэхийг нь хүлээн зогсоно. Тэрээр гарч ирээд морины цусыг устай холин урдын адил давтахад аймшигтай их салхи салхи ханы цэргүүдийн өмнө хамба лам гарч ирээд хонх дамраа дуугаргаж эхлэв. Гэнэт хуй салхи тур зогссоноо эргэн эсрэг зүтг чиглэн явахад Ван Цэ үүний эсрэг юу ч хийж чадахгүй болж хотын хаалгаар санд мэнд орж хаалгыг арайхийн хаахад ханы цэргүүдийн дайралтад хэрмэн хана нүргэлж байлаа.

Тэд дахиад л хотод орж чадсангүй. Вен жанжин хамба ламын үнэлж баршгүй тусламжинд талархал илэрхийлээд цаашид яах хэрэгтэй зөвлөлдөв. Энэ үед Вен жанжны цэргийн ахмад Ма хүрч ирээд хот уруу элч явуулах зөвшөөрөл туйв. Энэ зоригтой төлөвлөгөөг сонсоод Вен жанжин маргааш нь Ма ахмадыг хот уруу ганцааранг нь явуулав. Ахмад Магийн үнэн зорилгыг хэн ч мэдэхгүй байсан тул энэ алхам нь дайнд өдөөсөн бас нэг үйлдэл болохоор мэдээ байв. Ван Цэ түүнийг хуучин найз шиггээ угтан авч яриаг нь сонсоод ханы цэрг хүч нь суларч өөрөө бууж өгөх төлөвлөгөөтэй юм байна гэж ойлгоо байв. Гэхдээ ахмад Ма Ван Цэтэй ид шидтэй хамгаалагчгүй ганцаараа байхад нь уулзах магадлал маш бага байв. Энэ тухай ярилцаад ахмад Ма махны худалдаачин Чангийн өрөөнд архи ууж хонов. Дараагийн тулаанд Чанг өрийнхөө ид шидийн хүчийг харуулах гэж тэсэн ядан хүлээж байсан тул зөвхөн Вуг дагуулан явав. Хар тавхайт тэр үед согтуу байжээ. Мөнхжин Ариун явдалт нагац эгч хоёр өөр өөрсдийн орлонд

амарч байлаа. Чанг хотын хаалганд хүрч дайсны цэрэгтэй уулзахаар очоод хулуугаа онгойлгож “Хурдан!” гэж хашгирахад юу ч болсонгүй. “Хурдан!”, “Хурдан!” гэж ахин дахин хашгирахад гал ч гарсангүй, ус ч урссангүй. Учир нь урыд шөнө Ма ахмад Чанг унтаж байхад нь очоод түүний хулуун дотор өөрийн авч явсан цус, сармисны бэлдмэлийг хийсэн ажээ.

Ван Цэ хэдийгээр Мөнхжинтэй гэрлэсэн боловч дайснаа хөлдөөн хэсэгт зуур гар хөлөө хөдөлгөж чадахгүй болгохоос өөр арга мэддэгтүй байв.

Ван Цэ хотын хэрмэн дээр зогсоод Вен жанжингийн цэргүүдийн эсрэг Чанг, Ву хоёр хэрхэн шидэт бар гаргахаар чармайн ядаж байхыг нь харав.

Зүүн гүрний энхийг сахиулагч хаан амаа нээж үт хэлэхийг завдтал зоригт ахмад Ма нэг ч зэвсэгтгүйгээр ойртон ирж хамгаалагч нарыг нь хүрч ирэхээс урьтан хүчтэй үлээхэд Van Цэгийн хамаг үүдэн шүдийг үйрүүлчихжээ. Van Цэ юу ч хэлж чадахгүй болж Чанг Ву хоёр хотын хаалганы гадна бүтгэлгүйтэн байв. Ариун явдалт нагац эгч хааны шүдийг эмчлэхээр оролдож одоо би ганцхан зүйлийг хийж чадна. Энэ бол Агуу шидтэн дээр очиж дээр үед хэрэглэж байсан ганц зүйлийг авах хэрэгтэй гэж хэлэв.

- Тэр чинь юу юм бэ? гэж Van Цэ хугарсан шуднийхээ завсраар арайхийн асуув.

- Хэдэн жилийн өмнө би хүүгээ дагуулан явж эрдэмд суралцаж байх үедээ хийсэн хар илд юм гэж Ариун явдалт нагац эгч хариулав. Үүнийг хэрэглэхдээ хар нохойн толгойг цавчиж газарт унах үед нь амжиж толгойт нь унагах гэсэн хүнийхээ нэрийг хэлэх ёстой юм гэхэд,

- Тэгвэл бил Вен жанжин болон түүний бүх дайчдын нэрийг хэлж дуусгах хэрэгтэй юм байна. Ингэвэл бил тэднийг ялах болно.

- Тэр илд чинь хаана байдаг юм бэ? гэж Van Цэ асуув. Би түүнийг тэнгэрийн уулын хамгийн өндөр оргилын хадан дунд нуусан. Хэрэв тэр газраа байгаа бол би одоо явж түүнийг ольё. Эргэж ирээд бүгдээрээ түүний гайхамшигт хүчийг үзье гэж хэлээд тэр гарч явлаа.

Энэ хооронд хааны цэргийн бас нэг эрэлхэг удирдагч хүрч ирэв. Тэр өөрийн 500 хүнээр хотын хэрмэн ханын доогуур хонгил ухуулах ажлыг удирдав. Тэд хотын байршлын тухай зургийг Жэнээс авсан тул энэ хонгил шууд хааны ордонд хүрэх ёстой байв. Өндгөн төрөлт тэдэнтэй хамт явж, шаардлагатай үед ид шидийн эсрэг арга хэмжээ авахаар төлөвлөжээ.

Ариун явдалт нагац эгч ид шидийн хүчээр өөрийгоо тэнгэрийн уулын оргилд зөөн аваачиж илдээ нусан газарт иртэл тэнд нь түүний илдээ нусан хадны дэргэд урт цагаан сахалтай өвгөн сууж байв. Ариун явдалт нагац эгч түүнийг таньдагтүй байсан тул мэхийн ёсолж мэндлэв. Тэр өвгөн Цагаан сармагчин бөгөөд Ариун явдалт нагац эгчийг устгахаар ирсэн байсныг тэр мэдсэнгүй.

- Настай эмэгтэй, та энд юу хийж яваа юм бэ? гэж Цагаан сармагчин түүнээс асуухад,

- Би энд өөрийнхөө орхисон илдийг авахаар ирлээ гэж тэр хариулаад бөхийн илдээ нусан газраас нь гаргаж авав.

- Надад түүнийгээ үзүүлээч гэж өвгөн гүйв. Ариун явдалт нагац эгч түүнд илдийг өгөхөд өвгөн илдийг нь авч ирийг нь дагуулан илээд буцааж өгөхдөө,

- Энэ илд тийм ч сайнгүй болжээ гэв. Ариун явдалт нагац эгч илдээ буусан автал тэр нь ердийн нэг хуучин илд болчихсон байсан тул авхай түүнд чадуулснаа ойлгов. Уурлан бухимдсандаа тэрээр өвгөн үрүү дайрахад өвгөн өөрийнхөө авч явсан хатгамалтай уутнаас толь гаргаж ирэв. Тэр толинд өөрийгөө харсан ямар нэг чөтөр шулам алин боловч хувирч өөрийн жинхэнэ муухай төрхөндөө ордгийг Ариун явдалт нагац эгч мэддэг байв. Тийм учраас Цагаан сармагчин уутнаасаа толийг гаргахын өмнөхөн Ариун явдалт нагац эгч нүдээ тас анив. Цагаан сармагчин харин тэнгэрийн орноос өөрийн элч, хамгалагч нарыг дуудан ирүүлж тэл түүнийг Тэнгэрийн хааны өмнө шүүхээр авч явав.

Энэ хооронд хотын хананы доогуур хонгил гаргаж байсан хүмүүс ажлаа дуусгажээ. Тэдний удирдагч болон Өндгөн төрөлт хамтдаа хамгийн түрүүн хотод нэвтрэн оров. Тэд Ван Цэгийн байгаа унтлагын өрөөнд орж ирэхэд тэрээр үйрсэн шүднээсээ болоод ярьж чадахгүй хэвээр байжээ. Тэнд ороод тэд Мөнхжин хатныг хартал ид шидэт далайгаар хамгаалуулсан байхыг нь харав. Өндгөн төрөлт нэгэн ариун шившлэг хэлтэл түүнийг хүрээлсэн далай нь алга болов. Тэд даруй өрөөнд орж ирээд рашааны хүчээр түүнийг эсэргүүцэх чадалгүй болгон хүлж гаргаал ордныг нь галдан шатаав. Дараа нь Пеичоу хотын гудамжинд гарч олон жилээр чөтөр шулмын дарлалд боолчлогдон байсан ард түмэнд тэднийг чөлөөлснөө зарлан мэдэгдэв. Энэ үед хотын гадна байсан Вен жанжин хотын хэрмэн хананы цаана тэнгэрт тулсан их утаа гарахыг үзээд хонгил гаргаж байсан хүмүүс хотод амжилттай нэвтрэн орсныг ойлгож, цэргүүдээ дагуулан нээлттэй хаалгаар нь орж хотын иргэдэд хоол хүнсийг өгчээ.

Гэхдээ тэл Хар тавхайттай тооцоо бодох хэрэгтэй байв. Тэр хаана ч харагдахгүй байв. Өндгөн төрөлт Ариун явдалт нагац эгчид зориулан барьсан ордон уруу явав. Ордон эзгүйрсэн байлаа. Тэрээр ордонд ороод өрөөний 4 буланг анхааралтай ширтэв. Өрөөний алсын буланд хана түшүүлэн тавьсан хуучин шүүр түүний анхаарлыг ихэд татахад Өндгөн төрөлт тэرنийг ширтэн харав. Энэ үед урт цагаан сахалтай өвгөн болох Цагаан сармагчин түүний дэргэд хүрч ирэхэд тэрээр гайхан харав.

“Тийм ээ тэр бол Хар тавхайт” гэж Цагаан сармагчин хэлээд тэр үнэн хэрэгтээ хэн байсныг нь харглаа гээд бүхнийг илчлэгч толио гаргаж шүүрэнд ойртуулан барихад шүүр алга болж оронд нь улаан үнэг хана налан сууж байв. Энэ явдал удаан үргэлжилсэнгүй. Хэдхэн мөчийн дараа тэнгэрээс аянга нүргэлэх мэт чимээ гарч Хар тавхайт үнэтийг устгажээ. Гадаа хөөрөн баярлах чимээ сонсдов. Юу болсныг мэдэхээр гараад хартал Мөнхжин хатны ордонд аянганд ниргуулж үхсэн улаан үнэг хэвтэнэ.

Вен Ен-ро жанжин ард олны өмнөөс талархсанаа хэлэхээр Өндгөн торолтийг хайгаад олсонгүй. Учир нь тэрээр өөрийн найз Цагаан сармагчингийн хамт Тэнгэрийн хаанд очиж бүхнийг илтгэхээр явчихсан байлаа.

Вен жанжин цэргүүдийн хамт хотын дотуур сүр жавлантайгаар явж Пеичоу хот бүрэн чөлөөлөгдлөө. Ван Цэ цаазаар авахуулах ял авсан аж. Пэичноу хотод амар тайван эргэж ирлээ.

Цагаан сармагчингийн алдааг училсан тул тэрээр Тэнгэрийн улсдаа буцав. Харин түүний оронд Ариун явдалт нагац эгчээр Цагаан үүлний агуйд харуул хийлгэхээр шийдвэрээ. Тэрээр зөвлөн шийтгүүлсэндээ баярлаж байсан боловч удаалгүй газар хүчтэй хөдлөн нурж түүний сууж байсан агуин хаалгыг даран битүүлсэн тул хаашаа ч гарч чадалгүй үүрд тэндээ үлдجээ. Түүнээс хойш хэн ч Ариун явдалт нагац эгчийн сургийг сонссонгүй.



Хэвлэн нийтлэлийг
Интерпресс XXX



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй
“Хаддэгийн боловсролыг дэмжих
(READ) төслийг”-ийн хурээнд хэвлэв.
Худалдааныг хориглоно.